БИЧИЛ ГЛОБУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

БИЧИЛ 2.0

# ХБҮЦ

20 ТЭРБУМ

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ

БИЧИЛ ГЛОБУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ ХХК

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co CAPITAL

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

# Агуулга

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ** ........ **6**
**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД** ........ **10**
**НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР** ........ **11**
**ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ........ **13**
**ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД** ........ **14**
**НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН** ........ **15**
1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ ........ 16
1.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ........ 22
1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ........ 23
1.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ ........ 25
**ХОЁР. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ** ........ **26**
2.1. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ........ 27
2.2. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 29
2.3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ........ 30
2.4. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ ........ 32
2.5. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ........ 36
2.6. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ........ 43
**ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ** ........ **47**
3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 48
3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 49
3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ........ 54
3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ ........ 55
3.5. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ ........ 59
3.6. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БУЦААН ХУДАЛДАХ НӨХЦӨЛ ........ 59
**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ** ........ **63**
4.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ ........ 64
4.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ ........ 66
4.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ........ 68
4.4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ ........ 69
4.5. ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ ........ 72
4.6. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ........ 81

4.7. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТУХАЙ....83
4.8. ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ....85
4.9. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ....86
**ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН ....91**
5.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН....92
5.2. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМУУД....94
**ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА....96**
6.1. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР...97
6.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР....97
6.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ....98
6.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ....99
6.5. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ....99
**ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ ........ 103**
7.1. АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ....104
7.2. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ....107
7.3. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ....109
7.4. ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ....111
7.5. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ....112
**НАЙМ. ХАВСРАЛТ....113**
8.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ....114
8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ....116
8.3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ....121
8.4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ....127
8.5. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ129
8.6. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ....134
8.7. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ135
8.8. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ....137
8.9. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ....138
8.10. ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ....151
8.11. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ....169
8.12. ХУУЛИЙН ФИРМИЙН ДҮГНЭЛТ....178
8.13. НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ....237

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

## График

График 1. Монгол Улсын Бодит ДНБ-ийн өсөлт, хувиар ....16
График 2. Инфляц ба бодлогын хүү ....17
График 3. 2023 оны инфляцын төсөөлөл ....17
График 4. Мөнгөний нийлүүлэлт ба заавал байлгах нөөцийн хувь ....18
График 5. Зээлийн өрийн үлдэгдэл, их наяд төгрөг ....18
График 6. Зээлийн хүү ба хадгаламжийн хүү ....19
График 7. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд, сая ам.доллар ....19
График 8. Ам.долларын ханшийн өөрчлөлт ....20
График 9. Гадаад валютын улсын нөөц, сая ам.доллар ....20
График 10. Монгол Улсын төсвийн орлого ба зарлага, (их наяд төгрөг) ....21
График 11. Ажилгүйдлийн түвшин ....21
График 12. Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс ....22
График 13. Зах зээлийн үнэлгээ, (их наяд төгрөг) ба ДНБ-тэй харьцуулсан харьцаа 22
График 14. Нийт хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг) ....23
График 15. Нийт өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг) ....23
График 16. Зээлийн багц (тэрбум төгрөг) ба чанаргүй зээлийн хувь ....24
График 17. Банк бус санхүүгийн салбарын нийт орлого, нийт зарлага ба цэвэр ашиг (тэрбум төгрөг) ....24
График 18. Нийт хөрөнгө (тэрбум төгрөг) ба хөрөнгийн өсөлт (хувиар) ....37
График 19. Нийт хөрөнгийн бүтэц, актив талаас (тэрбум төгрөг) ....37
График 20. Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас (тэрбум төгрөг) ....37
График 21. Өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг) ....38
График 22. Зээлийн багцын чанар ....38
График 23. Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг, (тэрбум төгрөг) ....39
График 24. Ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөжийн харьцаа үзүүлэлтүүд ....40
График 25. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг) ....41
График 26. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөлтийн гүйцэтгэл ....61
График 27. Инфляц ба бодлогын хүү ....67
График 28. Системийн нөлөө бүхий банкнуудын төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү ....67
График 29. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны жилийн өгөөж ....68
График 30. Хөрөнгийн багц дахь зээлийн анх олгосон хэмжээ (сая.төг) ба эзлэх хувийн тархалт ....76
График 31. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдлийн тархалт, сая төгрөг ....77
График 32. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангиллаар ....77
График 33. Хөрөнгийн зээлийн багцын үлдэгдлийн тархалт, (сая төгрөг ба хувь) ... 78
График 34. Хөрөнгийн багц дахь анх зээл олгосон огнооны тархалтаар ....79
График 35. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацааны тархалт ....80

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ ЭМ ПАРТНЕРС ҮЦК ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
БЛЭЙЗ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Хүснэгт

Хүснэгт 1. БНХАУ ба Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал....16
Хүснэгт 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл ....27
Хүснэгт 3. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл....28
Хүснэгт 4. Компанийн түүх....28
Хүснэгт 5. Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Төлөөлөн удирдах зөвлөл....31
Хүснэгт 6. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх удирдлагын баг....32
Хүснэгт 7. Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг)....36
Хүснэгт 8. Орлого, үр дүнгийн тайлан, мянган төгрөг....38
Хүснэгт 9. Мөнгөн гүйлгээний тайлан, мянган төгрөг....40
Хүснэгт 10. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд....41
Хүснэгт 11. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд....41
Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл....48
Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл....48
Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн....52
Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн санхүүгийн тайлан, тэнцэл....54
Хүснэгт 16. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр....55
Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл....56
Хүснэгт 18. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал....56
Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл....57
Хүснэгт 20. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл....60
Хүснэгт 21. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр....68
Хүснэгт 22. Төлбөрийн хуваарь ба төлбөр тооцох аргачлал....69
Хүснэгт 23. Төлбөрийн график, сая төгрөгөөр....72
Хүснэгт 24. Хөрөнгийн багцын үзүүлэлтүүдийн хураангуй....73
Хүснэгт 25. Хуулийн шаардлагад нийцэж буй байдал....73
Хүснэгт 26. Зээлдэгч ба зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур....74
Хүснэгт 27. Хөрөнгийн зээлийн багцын шинжилгээний хураангуй үр дүн....75
Хүснэгт 28. Зээлийн багцын дүн, анх зээл олгосон ангиллаар....76
Хүснэгт 29. Зээлийн багцын дүн, зээлийн үлдэгдлээр....76
Хүснэгт 30. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангиллаар....77
Хүснэгт 31. Хөрөнгийн зээлийн багц, үлдэгдэл хугацааны ангиллаар....78
Хүснэгт 32. Хөрөнгийн багц дахь зээлийг анх олгосон огноо, улирлаар....78
Хүснэгт 33.. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацаа, улирлаар....79
Хүснэгт 34. Зээлийн багц, хүүгийн түвшнээр....80
Хүснэгт 35. Зээл ба барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа....80
Хүснэгт 36. Учирч болзошгүй эрсдэлүүд....86
Хүснэгт 37. Учирч болзошгүй эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө....87
Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчтай холбоотой дүрэм, журмууд....94

## Схем

Схем 1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас үүсгэх процесс....25
Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт....29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ

Схем 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн хувь эзэмшлийн бүтэц........30
Схем 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц........44
Схем 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлууд........49
Схем 6. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал........64
Схем 7. Сул чөлөөтэй хөрөнгийг байршуулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслүүд........71
Схем 8. Төлбөрийн дараалал........71
Схем 9. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах хэлбэрүүд........82
Схем 10. Модулийн үндсэн бизнес процесс........83
Схем 11. Татан буугдах нөхцөл........85
Схем 12. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны явцад учир болзошгүй эрсдэлүүд........86
Схем 13. Анхдагч зах зээлийн арилжааны үйл явц........97

УЛААНБААТАР ХОТ
ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01



## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

**БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 03 өдөр    № 23/25а/04    Улаанбаатар хот

**Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.5 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12-р зүйлийн 12.2 дахь хэсэг, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК (РД:6999131) (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг хүртэл нийт дүнтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 200,000 (хоёр зуун мянга) ширхэг хүртэл хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж дээр нийтэд санал болгон гаргасугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг Хавсралт 1-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуурыг Хавсралт 2-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шалгуурыг Хавсралт 3-р тус тус баталсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Н.Гантулга)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА    Н.ГАНТУЛГА

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

2023-06-15
БҮРТГЭВ-02
2023.06.02 БҮРТГЭВ № 01

"Бичил Эй Би Эс Плас Тэк" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ... сарын ...-ны
өдрийн ........тоот [illegible]
03/25а/07

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЭК" ХХК-ИЙН**
**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

| | |
|---|---|
| **Үнэт цаасны төрөл** | **Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас** |
| **Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага** | **Монголын хөрөнгийн бирж** |
| **Үнэт цаасны нэр** | **Бичил 2 ХБҮЦ** |
| **Үнэт цаасны тоо ширхэг** | **200,000 (хоёр зуун мянга) ширхэг хүртэл** |
| **Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ** | **100,000 (нэг зуун мянга) төгрөг** |
| **ХБҮЦ-аар татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн** | **20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг хүртэл** |
| **Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа** | **2023.06 сар** |
| **Үнэт цаасны хүү, хувь хэмжээ: /жил/** | **18.5%** |
| **Үнэт цаасны хугацаа: /хоног, сар, жил/** | **24 сар** |
| **Үнэт цаасны хүүгийн төрөл** | **Тогтмол** |
| **Үнэт цаасны хүү тооцох суурь хоног** | **365** |
| **Үнэт цаасны хүү төлөх хугацаа: /давтамж/** | **Улирал тутам** |
| **Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хугацаа** | **Жилд 1 удаа** |
| **Үнэт цаасны хаагалалт, төлбөр тооцоо:** | **Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв** |
| **Үнэт цаасны зарцуулалт:** | **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багцыг худалдан авах санхүүжилт** |
| **Барьцаа:** | **Автомашины фидуци бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс** |

...ЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
M... STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023 он 06 сар 02
№ 01

"Бичил Эй Би Эс Пласс ТЗК" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 24-ний
өдрийн ....... тоот шийдвэрийн хавсралт-2
23/25а/07

"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИЙН
ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨД ТАВИГДАХ ХУУЛИЙН ШААРДЛАГА

| | |
|---|---|
| 1. | Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны эзэмшүүлэгчийн бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх; |
| 2. | Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийн барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх; |
| 3. | Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, хүүтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх; |
| 4. | Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх; |
| 5. | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, хэрэгжилт суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх; |
| 6. | Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрдөгдөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх. |

—oOo—

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 ₮ 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС24...

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 26-ны
өдрийн ........ дугаар шийдвэрийн хавсралт №3
[illegible]/asa/07

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИЙН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨД ТАВИГДАХ САНХҮҮГИЙН ШАЛГУУР**

| | |
|---|---|
| 1. | Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх; |
| 2. | Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх; |
| 3. | Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх; |
| 4. | Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх( тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх), харгалзан үзэх; |
| 5. | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх; |
| 6. | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх: |
| 6.1. | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 55%-с илүүгүй байх; ӨОХ = зээлийн сарын төлбөр / (Өрхийн сарын орлого (татвараас өмнөх)) |
| 6.2. | Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрэхгүй байх. ЗҮХ = (Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл ) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ) |
| 6.3. | Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх; |
| 6.4. | Үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх; |

---oOo---

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163665
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023.06.02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгож байна. Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) -иас нэг бүр нь 100,000.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000.0 ширхэг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК нь энэхүү 20,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий үнэт цаасыг гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Бичил глобус финанс ББСБ ХХК (цаашид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эсхүл Үүсгэн байгуулагч гэх)-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багц болгон шилжүүлэн худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд бүрэн зарцуулна. Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй.

**ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХАРИУЦАХГҮЙ ! БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ , БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. Энэхүү Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК болон Андеррайтер Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

УЛААНБААТАР
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
6999131
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд үнэт цаасыг худалдаж буй үйл ажиллагаа |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд буюу Бичил глобус финанс ББСБ ХХК |
| Баталгаат үнэт цаас | Үнэт цаас гаргагчийн арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг ойлгоно. |
| Бирж эсхүл МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| Зээл | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу олгож буй зээл |
| Зээлдэгч | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу хүүгийн хамт эргүүлэн төлөх төлбөрийн үүрэг хүлээсэн этгээд |
| Зээлийн баримт бичгүүд | ББСБ-аас зээлдэгчид олгосон зээлийн гэрээ, барьцааны (фидуцийн) гэрээ болон зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүд |
| Зээлийн гэрээ | Зээлдэгч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээ |
| Зээлийн дансны бүртгэл | Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээлэл |
| Зээлийн эргэн төлөлт | ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөр |
| МҮЦАЭХ | Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо |
| Төлбөр цуглуулах данс | Зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг хүлээн авах зорилгоор банканд тусгайлан нээсэн тусгай зориулалтын компанийн данс |
| Үйлчилгээ үзүүлэгч | Үнэт цаас гаргагчтай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлттэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх үйлчилгээг үзүүлж буй этгээд |
| Үнэт цаас гаргагч | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож буй тусгай зориулалтын компани буюу Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК |
| Үнэт цаас эзэмшигч | ТЗК-ийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авч, эзэмшиж буй этгээд |
| Үнэт цаасны төлбөр | Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв буюу ҮЦТХТ |
| Хороо эсхүл СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| Хөрөнгийн багц эсхүл Зээлийн багц | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хооронд “Хөрөнгө худалдах, худалдан авах” гэрээний тусгай нөхцөлийн 1 дүгээр зүйлд тодорхойлогдсон, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүд |
| Хөрөнгийн багцын эсхүл Зээлийн багцын эргэн төлөлт | ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөр |

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
9023050184

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01



| | |
|---|---|
| Хөрөнгийн жагсаалт | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний Хавсралт 1-д заасан, худалдаж байгаа автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн жагсаалт |
| Хөрөнгө | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1-д заасан үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх |
| Хөрөнгө итгэмжлэн удирдагч | Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | Хөрөнгөөр баталгаажсан, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас |
| Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх | Зээлдэгч сар тутам зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хэсэгчлэн, эсхүл бүрэн төлөх тохиолдол |
| Шаардлага хангахгүй хөрөнгө | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ", "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д тодорхойлсон хөрөнгө |
| Шалгуур үзүүлэлт | Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/07 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүд |

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183865
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.12 өдөр
ЗӨВШӨӨРӨВ
№ 01

# ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | Бичил глобус финанс ББСБ ХХК |
| Үнэт цаасны төрөл | Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| Үнэт цаасны нэр | Бичил 2 ХБҮЦ |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100,000.0 (нэг зуун мянга) төгрөг |
| Үнэт цаасны тоо ширхэг | 200,000.0 (хоёр зуун мянга) ширхэг хүртэлх |
| Үнэт цаасны нийт үнийн дүн | 20,000,000,000.0 (хорин тэрбум) төгрөг хүртэлх |
| Үнэт цаасны хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| Үнэт цаасны хүү | 18.5 (арван найм аравны тав) хувь |
| Үнэт цаасны хүүгийн төлөлт | Улирал тутамд |
| Үнэт цаасны хүү тооцох суурь хоног | 365 (гурван зуун жаран тав) хоног |
| Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт | Хөрөнгө оруулагчид төлөх үндсэн төлбөрийн 50 хувийг Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа мөн сарын мөн өдөр төлнө. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.) Үлдэгдэл төлбөрийг Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 сарын дараа мөн сарын мөн өдөр шилжүүлнэ. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.) |
| Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр | Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн орлого |
| Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татвар | 5.0 (тав) хувь |
| Үнэт цаасны хадгалалт | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд арилжаална. |
| Хөрөнгийн багцын дүн | 24,237,058,803.4 (хорин дөрвөн тэрбум хоёр зуун гучин долоон сая тавин найман мянга найман зуун гурав) төгрөг (дөчин) мөнгө |
| Зээлийн тоо | 1,468 |
| Зээлдэгчдийн тоо | 1,468 |
| Барьцаа | Автомашины фидуци бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс |
| Зээлийн чанар | 100 хувь хэвийн |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Бичил глобус финанс ББСБ ХХК-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцыг худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагаа санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд зарцуулна. (энэхүү санхүүжилтийг татахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс гаргахгүй болно.) |

Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК
АТА9998 6939131
9023050164

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

| | |
|---|---|
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | |
| БИЧИЛ ГЛОБУС | **Бичил глобус финанс ББСБ ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол (14180), Ногоон нуурын гудамж, Прован оффис, 705 тоот<br>(+976) 7000-2020<br>www.bichilglobus.mn<br>info@bichilglobus.mn |
| **Үндсэн Андеррайтер** | |
| ULZII &Co CAPITAL | **Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 тоот<br>(+976) 7777-6377<br>www.ucc.mn<br>info@ucc.mn |
| **Зээлийн шинжилгээ гаргагч** | |
| Onch& Company | **Онч Аудит ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян-Гүн гудамж, ICC тауэр, 15 давхар<br>(+976) 7012-0450<br>www.onch.mn<br>info@onch.mn |
| **Хуулийн фирм** | |
| MDSKhanLex | **Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 13 давхар, 1301 тоот<br>(+11) 330048<br>www.mdskhanlex.com<br>info@mdsa.mn |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч фирм** | |
| UAF ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС | **Юнайтед Айр Файнэнс ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005-1007 тоот<br>(+976) 7012-2346<br>www.uaf.mn<br>info@uaf.mn |

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС САНАЛ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ ХООРОНДОО БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ/ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧТЭЙ ЭНЭХҮҮ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ ГАРГАХААС БУСДААР АЛИВАА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ/БОЛОН БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАРИЛЦАА БАЙХГҮЙ БӨГӨӨД ХОЛБООТОЙ ЭТГЭЭДҮҮД БИШ БОЛНО.**

УЛААНБААТАР ХОТ
ЭН ДИ ЭС П/ТЗК ХХК
ATA9998 9023050164

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# НЭГ. Хөрөнгө оруулалтын орчин

БИЧИЛ 2.0

# ХБҮЦ

20 ТЭРБУМ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-06-15
БҮРТГЭВ-02
СЭХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

## 1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

### ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Монгол Улсын бодит эдийн засаг 2022 онд 4.8 хувиар өсжээ. Өнгөрсөн оны эдийн засгийн өсөлтийг коронавируст цар тахал (Ковид-19)-ын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 0.8 пунктээр доогуур үзүүлэлт хэдий ч, 2022 оны Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 1.7 хувь өснө гэж үзэж байсан таамаглалтай харьцуулахад 1.5 дахин өндөр өсөлт юм.

*График 1. Монгол Улсын Бодит ДНБ-ийн өсөлт, хувиар*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2022 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт Олон Улсын банк, санхүүгийн байгууллагаас дэвшүүлж байсан таамаглалыг давахад БНХАУ нь "Тэг ковид" бодлогоо сулруулж, хилийн боомтуудаа шат дараалан нээсэн нь манай улсын уул уурхайн түүхий эдийн экспортод эерэгээр нөлөөлсөн. Тухайлбал, 2022 онд зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 13.3 хувь өссөн бол нүүрсний экспортын биет хэмжээ 97.1 хувиар, нүүрсний борлуулалтын орлого 134.0 хувиар тус тус өсжээ.

*Хүснэгт 1. БНХАУ ба Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал*

| Монгол Улсын 2023 оны эдийн засгийн өсөлтийн таамаглал | | БНХАУ-ын 2023 оны эдийн засгийн өсөлтийн таамаглал | |
|---|---|---|---|
| Монголбанк | 3.2% | Фитч агентлаг | 5.0% |
| Азийн хөгжлийн банк | 4.9% | Азийн хөгжлийн банк | 4.5% |
| Дэлхийн банк | 5.8% | Дэлхийн банк | 4.3% |
| ОУВС | 5.0% | ОУВС | 5.2% |
| Дундаж | 4.7% | Дундаж | 4.8% |

*Эх сурвалж: Банк, санхүүгийн байгууллагын вэбсайт*

Иймд 2023 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлт БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, түүхий эдийн эрэлтээс шууд хамаарахаар байгаа юм. Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас гаргасан тооцооллоор 2023 онд БНХАУ-ын эдийн засаг дунджаар 4.8 хувь буюу урт хугацааны зорилтот түвшин 5.0 хувьд ойртох эерэг хүлээлттэй байна.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

БНХАУ-ын бодит ДНБ-ийн өсөлт 2022 онд 3.0 хувь байсан талаар тус улсын Үндэсний статистикийн товчооноос мэдээлсэн. Энэхүү өсөлт нь АНУ, Япон, Герман гэх мэт хөгжингүй орнуудын 2022 оны эдийн засгийн өсөлттэй харьцуулахад харьцангуй өндөр өсөлт юм.

## ИНФЛЯЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГО

2022 оны 01 дүгээр сард Төв банкны бодлогын хүү 6.0 хувьд байсан бол оны эцэс гэхэд нийт 5 удаа бодлогын хүүг өсгөж 13.0 хувьд хүргээд байна. Монголбанкны зүгээс өнгөрсөн онд мөнгөний хатуу бодлогыг тууштай баримталсан нь инфляцын түвшин 2022 оны 01 дүгээр сард 14.6 хувьд хүрч, цаашид сар бүрийн инфляц 2 оронтой тоонд хадгалагдаж буйтай холбоотой байсан юм.

*График 2. Инфляц ба бодлогын хүү*




*Эх сурвалж: Монголбанк*

Мөн АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас 2022 онд бодлогын хүүгээ 0.25 хувиас нэмэгдүүлж 4.5 хувьд хүргэсэн нь бусад улс орнууд ам.доллартай харьцуулсан үндэсний валютын ханшаа мөнгөний бодлогын хэрэгслээр дамжуулан тогтворжуулах арга хэмжээ авахад хүргэжээ.

*График 3. 2023 оны инфляцын төсөөлөл*




Монголбанкны 2023 оны 3 дугаар сарын инфляцын тайланд дурдсанаар импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт манай улсын инфляцын 40 орчим хувийг бүрдүүлж байна. 2023 онд Төв банкны зүгээс инфляцын түвшин цаашид нийлүүлэлт, зардлын хүчин зүйлсийн нөлөөгөөр алгуур буурах хүлээлттэй байгаа хэдий ч эдийн засгийн өсөлт сэргэхийн хэрээр төсвийн зардал өндөр байгаа учраас эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэх эрсдэл хүлээгдэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15

СЗХ 2023.06.02 БҮРТГЭВ № 01

## МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эхний улиралд 30.9 их наяд төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оны эцсээс 4.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлт 2018 оноос хойш 2022 он хүртэл жилд дунджаар 11.1 хувийн өсөлттэй байна. 2020 онд мөнгөний нийлүүлэлт 16.1 хувиар өссөн нь коронавируст цар тахлын үед эрэлтийг дэмжих зорилгоор Монголбанкнаас мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж байсантай холбоотой юм.

*График 4. Мөнгөний нийлүүлэлт ба заавал байлгах нөөцийн хувь*




*Эх сурвалж: Монголбанк*

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бага зэрэг сэргэж, банкны системийн нийт зээлийн өсөлт бага хэдий ч тогтвортой байгааг Төв банкны 2023 оны 3 дугаар сарын тайланд онцолжээ. Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотой банкны зээл олгох боломжтой төгрөгийн эх үүсвэр төдийлөн нэмэгдэхгүй ба банкууд зээлийн шалгуур, нөхцөлөө 2022 оны сүүлийн хагаст чангаруулсан зэрэг нь мөнгөний нийлүүлэлтийн хурд саарах нөхцөл болох хүлээлттэй байна.

*График 5. Зээлийн өрийн үлдэгдэл, их наяд төгрөг*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2022 онд банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 22.2 их наяд төгрөг байгаа бол банк бус санхүүгийн салбарын зээл 2.7 их наяд төгрөг буюу банкны салбарын нийт зээлийн 12.1 хувьтай дүйцэж байна. Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн жилийн дундаж өсөлт (CAGR) 6.6 хувь байгаа бол банк бус санхүүгийн салбарын жилийн дундаж өсөлт (CAGR) 33.0 хувь байна.

2022 онд бодлогын хүүгийн өсөлтийн нөлөөгөөр банкуудын шинээр татсан хадгаламжийн хүү 2023 оны 3 дугаар сарын байдлаар 12.9 хувь байгаа бол нийт зээлийн үлдэгдэлд тооцсон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.1 хувь байна. 2021 онд Монголбанкнаас бодлогын хүүг 6.0 хувь хүртэл буулгаж, харилцах болон хугацаагүй хадгаламжид хуримтлагдах хүүг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тооцохгүй байх хуулийн зохицуулалт хэрэгжиж байсан. Энэ нь 2021 онд зах зээл дээрх хүүгийн ерөнхий түвшин буурах нөхцөл болсон юм.

*График 6. Зээлийн хүү ба хадгаламжийн хүү*




*Эх сурвалж: Монголбанк, ҮСХ*

## ГАДААД ХУДАЛДАА БА ВАЛЮТЫН ХАНШ

Монгол Улсын экспортын орлого 2022 онд өнгөрсөн онтой харьцуулахад 35.6 хувиар буюу 3.2 тэрбум ам.доллароор нэмэгдэж 12.5 тэрбум ам.долларт хүрчээ. Энэхүү экспортын борлуулалтын орлогын дүн Коронавируст халдварын цар тахлын өмнөх 2019 оны экспортын орлоготой харьцуулахад 64.5 хувиар өндөр үзүүлэлт юм.

*График 7. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд, сая ам.доллар*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01



2022 оны байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 21.2 тэрбум ам.долларт хүрчээ. 2022 оны гадаад худалдааны эргэлтийг 2020 оны хил, гаалийн хөл хориотой байсан үеийн мөн үзүүлэлттэй харьцуулахад 65.0 хувиар өссөн. Гадаад худалдааны тэнцэл 3.8 тэрбум ам.долларын ашигтай гарсан бөгөөд 2019 онтой харьцуулахад 1.5 дахин өссөн эерэг үзүүлэлт болж байна. 2023 оны эхний улиралд гадаад худалдааны тэнцэл 1.8 тэрбум ам.долларын ашигтай гараад байна.

*График 8. Ам.долларын ханшийн өөрчлөлт*




*Эх сурвалж: Монголбанк*

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2022 оны жилийн эцэст 3,444.6 төгрөгт хүрсэн бөгөөд тус онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 20.9 хувиар суларчээ. 2019 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3.4 хувиар унасан бол 2020 онд 4.2 хувь, 2021 онд жилийн эхний ханш сүүлийн ханшаас өөрчлөгдөөгүй байсан. 2023 оны 3 дугаар сарын эцэст ам.долларын төгрөгтэй харьцах ханш 3,518.1 төгрөг байв.

*График 9. Гадаад валютын улсын нөөц, сая ам.доллар*




*Эх сурвалж: Монголбанк*

Монгол Улсын гадаад валютын нөөц 2021 оны 01 дүгээр улиралд 4,774.6 сая ам.долларт хүрсэн ба цар тахлын өмнөх үеэс ч өндөр түвшинд хүрсэн бөгөөд 2022 оны 01 дүгээр улирлаас эхлэн гадаад валютын улсын нөөц хумигдаж эхэлсэн нь хил, гааль нээгдэж бараа, үйлчилгээний төлбөр төлөлт ихэссэн, 1.5 тэрбум ам.долларын Чингис бондын үлдэгдэл төлөлт хийгдсэн нь ихээхэн нөлөөлжээ.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 ... 9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15 БҮРТГЭВ-02

СЭХ он сар өдөр 2023.06.03 БҮРТГЭВ № 01

## УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2022 онд 18.6 их наяд төгрөг байсан бол нийт зарлага, цэвэр зээлийн дүн 18.2 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 2.6 их наяд төгрөгөөр нэмэгджээ. 2020 онд коронавируст цар тахлын эсрэг Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь төсвийн зардлыг 2019 онтой харьцуулахад 31.6 хувиар буюу 2.6 орчим их наяд төгрөгөөр өсгөжээ. 2023 оны нэгдүгээр улиралд төсвийн тэнцэл 1 их наяд орчим төгрөгийн ашигтай гарчээ.

*График 10. Монгол Улсын төсвийн орлого ба зарлага, (их наяд төгрөг)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ажилгүйдлийн түвшинг Үндэсний статистикийн хорооноос зарласан улирлын мэдээллээс харахад 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 5.3 хувьд хүрсэн байна. 2022 онд ажилгүйдлийн түвшин ийнхүү буурч байгаа нь цар тахлын дараа дотоодын эдийн засаг аажмаар сэргэж буй эерэг дохио болж байна.

*График 11. Ажилгүйдлийн түвшин*




*Эх сурвалж: Монголбанк*

Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2022 оны эцэст 1,274.6 мянгад хүрсэн ба 2021 оноос 255.4 мянган хүнээр нэмэгдсэн нь дотоодын хөл хорионоос гарсан иргэдийн ажил эрхлэх сонирхол нэмэгдсэн, ажлын байрны эрэлт өсөж байгаа нь нөлөөлжээ.

УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ ПИ ЭС ПЛАС ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

## 1.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

*График 12. Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс*




2022 оны 12 дугаар сард үнэт цаасны арилжааны нийт үнийн дүн 170.4 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 4.5 дахин өссөн. Ийнхүү үнэт цаасны гүйлгээ нэмэгдэхэд системийн нөлөө бүхий банкууд болох Төрийн банк, Голомт банк олон нийтэд хувьцаагаа нээлттэй санал болгох үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлсэн нь нөлөөлсөн байна. Коронавируст цар тахлын өмнөх үе буюу 2019 онд сарын дундаж үнэт цаасны гүйлгээний дүн 13.4 тэрбум төгрөг байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 4.4 тэрбум төгрөг, 2021 онд 97.2 тэрбум төгрөг, 2022 онд 45.9 тэрбум төгрөг, 2023 оны 3 дугаар сарын байдлаар 24.7 тэрбум төгрөг болжээ.

*График 13. Зах зээлийн үнэлгээ, (их наяд төгрөг) ба ДНБ-тэй харьцуулсан харьцаа*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2022 онд Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд тухайн оны нэрлэсэн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 12.9 хувь буюу хөрөнгийн зах зээл нийт эдийн засгийн 12.9 хувьтай дүйцэж байгааг харуулж байна. 2021 онд Төв банкнаас мөнгөний зөөлөн бодлого барьсан ба Монгол Улсын Засгийн газраас иргэдэд нэг удаа олгосон тэтгэмж, бусад халамжийн бодлогууд нь хөрөнгийн зах зээл рүү орох мөнгөн урсгалыг нэмэгдүүлжээ. Сүүлийн байдлаар 2023 оны 3 дугаар сард Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.5 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 5.6 хувиар буурчээ.

## 1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Банк бус санхүүгийн салбарын **нийт** хөрөнгийн хэмжээ 2022 онд 3.5 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 30.1 хувиар буюу 817.0 орчим тэрбум төгрөгөөр өсжээ. Нийт хөшүүргийн харьцаа 1.6 буюу нийт өр төлбөр 37.8 хувийг эзэлж байна. 2018 оноос хойш хөшүүргийн харьцаа тогтмол өсөж байгаа нь итгэлцэл, өрийн бичиг, банк, санхүүгээс авсан зээлийн санхүүжилт нэмэгдэж байгаа нь нөлөөлжээ.

*График 14. Нийт хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

Салбарын **нийт** өр төлбөрийн дүн 2018 оноос хойш жилд дунджаар 44.6 хувиар өсөж байна. Банк бус санхүүгийн салбарын **нийт** өр төлбөрийн бүтэц 2022 онд итгэлцлийн үйлчилгээний өглөг 28.5 хувь буюу 381.1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оноос 54.3 хувиар өсжээ.

*График 15. Нийт өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

Харин бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 426.8 тэрбум төгрөг буюу **нийт** өр төлбөрт 32.0 хувийг эзэлж байна. Өрийн хэрэгсэл болон бусад өр төлбөрийн дүн 527.5 тэрбум төгрөг буюу нийт **өрийн** эх үүсвэрт 39.5 хувийг тус тус эзэлж байна.

Нийт хөрөнгөд эзлэх нийт зээлийн багцын дүн 2022 онд өмнөх оноос 35.3 хувиар өсөж 2,722.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн хувь 2022 онд 7.6 хувьд хүрч өнгөрсөн оноос 0.6 пунктээр нэмэгджээ. Цар тахлын эхэн үед буюу 2020 онд чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 10.3 хувьд хүрсэн ба чанаргүй зээлийн хувь бага зэрэг өсөх хандлага үзүүлж байна.

*График 16. Зээлийн багц (тэрбум төгрөг) ба чанаргүй зээлийн хувь*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

Банк бус санхүүгийн салбарын нийт орлого 2022 онд 867.9 тэрбум төгрөг, нийт зарлага 554.9 тэрбум төгрөг байсан бөгөөд цэвэр ашгийн дүн 313.0 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 103.0 орчим тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Нийт орлого 2022 онд 66.6 хувиар өсөж 868.0 тэрбум төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оноос 347.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

*График 17. Банк бус санхүүгийн салбарын нийт орлого, нийт зарлага ба цэвэр ашиг (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

## 1.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэдэг нь зээл, түрээс болон санхүүгийн түрээсийн гэрээ, моргейжийн зээл, авлага зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой санхүүгийн хэрэгсэл буюу хөрөнгөөр баталгаажсан, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна.

*Схем 1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас үүсгэх процесс*




### ХӨРВӨХ ЧАДВАР САЙН

Ирээдүйд мөнгөн урсгал бий болгох чадвартай зээлийн багцыг үнэт цаасанд хөрвүүлснээр тухайн үнэт цаасжуулж буй хөрөнгө болох зээлийн багцын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, улмаар хөрөнгө оруулагч нарт арилжаалах боломжтой, илүү хөрвөх чадвар сайн, үнэт цаас хэлбэрийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг санал болгох нөхцөл бүрддэг юм.

### ЭРСДЭЛ БАГА

Үнэт цаасжуулж буй хөрөнгийг тусгай зориулалтын компани руу шилжүүлснээр тухайн хөрөнгийн үнэ цэнэ анхны үүрэг гүйцэтгүүлэгч компанийн үйл ажиллагаанаас хамааран буурах, эргэн төлөлт тасалдах гэх мэт эрсдэлээс хөрөнгийг тусгаарлаж, хөрөнгө оруулагч нарыг хамгаалах боломжтой болдог. Ийнхүү тусгай зориулалтын компани нь үнэт цаасжуулсан хөрөнгийг бүрэн өөр дээрээ шилжүүлж авснаар тухайн хөрөнгөөс бий болсон мөнгөн урсгалыг эргэн төлөлт хэлбэрээр үнэт цаас эзэмшигч нарт олгох, хөрөнгийг удирдах үндсэн чиг үүрэгтэй ажиллах боломжийг олгодог ба тухайн хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлээс салангид авч үзэх боломжтой болдог юм.

### ТОГТМОЛ ӨГӨӨЖ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь компанийн бонд, банкны хугацаатай хадгаламж, Засгийн газрын бондтой төстэй бөгөөд хөрөнгө оруулагч нарт эрсдэл багатай, баталгаат, тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хөрөнгө оруулагч нарт үндсэн болон хүүгийн төлбөрийг найдвартай эргэн төлөх зорилготойгоор үнэт цаасжуулсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гэдгээрээ онцлогтой.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# **ХОЁР.** Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай

БИЧИЛ 2.0

**ХБҮЦ**

20 ТЭРБУМ

## 2.1. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

### ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бичил глобус финанс ББСБ нь анх 2008 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй, шуурхай бичил зээлийн үйлчилгээгээр бизнесийн гараагаа эхэлсэн. 2011 онд анхны хөрөнгө оруулалт болох 1.0 сая ам.долларыг Австрали улсаас татаж байсан туршлагатай ба 2013 онд Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан. 2022 оны байдлаар буюу анх үүсгэн байгуулагдсанаас хойш 15 жилийн дараа Бичил глобус финанс ББСБ нь Улаанбаатар хотод 15 салбар, орон нутагт 1 салбар буюу нийт 16 салбар нэгж, 15,000 гаруй харилцагчидтай болсон ба 70 гаруй чадварлаг мэргэжилтнээр дамжуулан 64.4 тэрбум төгрөгийн нийт зээлийн багцтайгаар, бичил санхүүгийн зах зээлд үйлчилгээгээ хүргэж байна.

*Хүснэгт 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл*

| | |
|---|---|
| Компанийн нэр | Бичил глобус финанс ББСБ |
| Хариуцлагын хэлбэр | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2013.07.17 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9015002106 |
| Регистрийн дугаар | 5729718 |
| Гүйцэтгэх захирал | Самдангийн Отгонбат |
| Үйл ажиллагааны чиглэл | • Зээлийн үйл ажиллагаа<br>• Факторингийн үйлчилгээ<br>• Итгэлцлийн үйлчилгээ |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 5,000,000,000.0 (таван тэрбум) төгрөг |
| Хувьцааны тоо ширхэг, төрөл | 100 (нэг зуун) ширхэг, Энгийн хувьцаа |
| Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ | 50,000,000.0 (тавин сая) төгрөг |
| Биржид бүртгэлтэй эсэх | Үгүй |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, гудамж, 101 барилгын 705 тоот |
| Утас | (+976) 7000-2020 |
| Цахим шуудан | info@bichilglobus.mn |
| Цахим хаяг | www.bichilglobus.mn |

### БИЧИЛ – ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮГИЙН ЭХЛЭЛ

Монгол Улсын санхүүгийн зах зээлд Бичил глобус финанс ББСБ үүсэн байгуулагдах болсон шалтгаан нь анх санхүүгийн зах зээл рүү хөл тавих үед Банк, санхүүгийн салбарт бичил зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тун дутмаг байсан бөгөөд санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээ нь түлхүү дунд түвшний, амьжиргааны түвшин сайн, тогтмол орлоготой иргэдэд чиглэж байсан. Хувиараа бизнес эрхлэгч иргэд, жижиглэн худалдааны бизнес эрхлэгч нар тухайн үед тогтмол орлогогүй, зээлийн барьцаа хөрөнгөгүй гэх шалтгаанаар арилжааны банкнаас зээл

авах шалгуурт тэнцдэггүй, зээл авах боломжгүй байсан юм. Энэхүү санхүүгийн үйлчилгээнд гарсан доголдол, хүртээмжгүй байдлыг арилгах зорилготойгоор анх барьцаагүй зээлийн үйлчилгээг Бичил глобус финанс ББСБ нь иргэдэд олгож эхэлсэн билээ.

## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БИЗНЕСИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

*Зураг 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бизнесийн үнэт зүйлс*




## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

*Хүснэгт 3. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл*

| № | Тусгай зөвшөөрөл | Олгосон огноо |
|---|---|---|
| 1 | Зээлийн үйл ажиллагаа | 2013.10.23 |
| 2 | Факторингийн үйлчилгээ | 2018.09.12 |
| 3 | Итгэлцлийн үйлчилгээ | 2019.12.04 |

## ТҮҮХЭН ХӨГЖИЛ

*Хүснэгт 4. Компанийн түүх*

**2021-2022 он**

- 2021 он: Ти Ди Би секьюритис ҮЦК ХХК-иар зуучлуулан **10.0 тэрбум төгрөгийн** хаалттай өрийн бичиг амжилттай татан төвлөрүүлсэн.
- 2022 он: Бичил Эй Би Эс Актив хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган **10.0 тэрбум төгрөг** амжилттай татан төвлөрүүлэв.

**2017-2018 он**

- 2017 он: Ниссан цахилгаан автомашиныг Монгол Улсын зах зээл, цаг агаарын нөхцөлд амжилттай туршин, **"Эко зээл"**-ийг нэвтрүүлсэн анхны санхүүгийн байгууллага болов.

**2015-2016 он**

- 2015 он: Иргэдийнхээ зээлжих боломжийг нэмэгдүүлэхийн тулд СЗХ-той хамтран ажилласны үр дүнд **Шимтгэлийг 0%** болгож хүүг холбогдох журмын дагуу өөрчлөлт оруулав. Үүний үр дүнд зээл авах хугацаа дагаад уртассан сайхан мэдээг харилцагч нартаа хүргэв.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.07
БҮРТГЭВ
№ 01

**2012-2014 он**

- 2012 он: санхүүгийн хүртээмжийг иргэдэд улам ойртуулахын төлөө 2009 оноос хойш 2012 оны байдлаар Улаанбаатар хотод **8 салбар** нэгжтэйгээр иргэдийнхээ тулгамдаж буй асуудалд шийдвэр гаргалтыг улам хурдасгаж ажилласан он жилүүд байв.

**2010-2011 он**

- 2011 он: **Австрали улсаас 1.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг** татсан. Зах зээл дээр байгаа дундаж хүүг эргэлтийн хөрөнгө оруулалтаар буулгаж, ажиллагсад болон зээлдэгчдийнхээ төлөлт болоод цалингийн асуудал дээр анхаарч ажилласан.

## 2.2. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бичил глобус финанс ББСБ нь компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн эрх барих дээд удирдлагатай. Гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг бөгөөд Бизнес хөгжлийн газар, Санхүү бүртгэлийн газар, Зээлийн газар, Захиргаа удирдлагын газар, Мэдээлэл технологийн хэлтэс гэсэн газар, нэгжүүдийг хариуцдаг.

*Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт*




УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ... ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт зааснаар "толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1 (хараат компани), 6.3 (охин компани), 6.8 (хараат болон охин компанийн үргэлжилсэн хэлхээ холбоо)-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ" гэж заасан байна. Энэхүү заалтын дагуу "Бичил глобус финанс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болон компанийн нэгдлийн бүтэц нь дараах байдалтай байна.

*Схем 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн хувь эзэмшлийн бүтэц*




(а) **С.Отгонбат** нь Бичил глобус ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн 94.4 хувийг эзэмшдэг. **Б.Хүрэлхүү** нь Бичил глобус ХХК-ийн 5.6 хувийг эзэмшдэг юм.

**(б) Бичил Глобус ХХК** Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, бизнесийн болон менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг.

**(в) Бичил глобус финанс ББСБ ХХК** Зээл, факторингийн үйл ажиллагаа болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага.

**(г) Эрдэнийн опал ХХК** Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, автомашины засвар үйлчилгээ, автозогсоол, гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэгч байгууллага.

## 2.3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнээс бүрдсэн байхаар заажээ. Үүний хүрээнд, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн №19/02А/106 тоот шийдвэрээр ТУЗ-ийн 3 ердийн гишүүн болон 2 хараат бус гишүүнийг тус тус томилсон байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ыг өөрийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжүүлэхийг эрмэлзэж ажиллаж байгаа ба ТУЗ-ийн гишүүд СЗХ-ны Компанийн засаглалын сургалтад бүрэн хамрагдсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

*Хүснэгт 5. Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Төлөөлөн удирдах зөвлөл*



Б.Хүрэлхүү
*ТУЗ-ийн дарга*

**Боловсрол**
- 2004-2006, МУИС, ХЗС, Хууль зүйн магистр;
- 1999-2001, МУИС, ХЗС, Эрх зүйн бакалавр;
- 1992-1996, МУИС, ЭЗС, Эдийн засаг, нягтлан бодогч, бакалавр;
- 1982-1992, Дархан-Уул, Дархан хот, 15-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн дарга;
- 2012-Одоо, "Эн Си Ди Групп" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2005-2012, "Номин Реалтор" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2003-2005, "Номин Холдинг" ХХК, Дотоод аудитын газрын дарга.



С.Отгонбат
*ТУЗ-ийн гишүүн*

**Боловсрол**
- 2011-2013, МУИС, Олон Улсын эдийн засгийн харилцааны магистр;
- 2006-2010, Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;
- 1992-2002, 12-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2013-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2017-Одоо, "Бэрс финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008-2009, "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;
- 2006-2007, "Оргил-Хотхон" ХХК, Гүйцэтгэх захирал.



Д.Ганболор
*ТУЗ-ийн гишүүн*

**Боловсрол**
- 2016-2019, Сити их сургууль, Архитектурч, Бакалавр;
- 2014-2016, Сити их сургууль, Үйлдвэр удирдлагын менежмент, Бакалавр;
- 2002-2005, ШУТИС, Нефть хийн өрөмдлөг, олборлолтын инженер мэргэжлээр бакалавр;
- 1992-2002, Дархан-Уул, Оюуны ирээдүй цогцолбор, Бүрэн дунд;

**Ажлын туршлага**
- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн гишүүн;
- 2022-Одоо, "Дархан төгөлдөр" ХХК, Ерөнхий захирал;
- 2017-Одоо, "Баянтөхөм шандат" ХХК, Зураг төслийн удирдах инженер:
- 2013-2017, "Ноёдын тууръ" ХХК, Зураг төслийн инженер;
- 2009-2013, "Нью Арена" ХХК, Захирал.



Б.Хишигсүрэн
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*

**Боловсрол**
- 2002-2006, Их засаг Их сургууль, Эрх зүйч мэргэжлээр бакалавр;
- 1992-2002, Увс аймаг, Улаангом, 2-р сургууль, Бүрэн дунд

**Ажлын туршлага**
- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн;
- 2021-Одоо, "Баясах трейд" ХХК, Хүний нөөцийн менежер;
- 2015-2021, "Бэрс финанс ББСБ" ХХК, Хүний нөөцийн менежер;
- 2009-2015, "Сод Монгол Групп", Хүний нөөцийн менежер;
- 2007-2009, "Очир угалз солюшин" ХХК, Хуулийн зөвлөх.



Н.Золжаргал
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*

**Боловсрол**
- 2001-2006, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага, Бакалавр;
- 1999-2000, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Референт;
- 1990-1999, Эрдэнэт хот, 5-р сургууль, Бүрэн дунд;

**Ажлын туршлага**
- 2017-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн;
- 2017-Одоо, "Бэрс финанс ББСБ" ХХК, Бичиг хэргийн ажилтан;
- 2013-2016, "Төрийн банк", Захирлын туслах;
- 2008-2012, "Умбайн шим" ХХК, Менежер;
- 2007-2008, МУИС-ОАСС, Нарийн бичиг.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БЭРС ПАЙ ТЗК ХХК
9023050164

## 2.4. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

*Хүснэгт 6. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх удирдлагын баг*



С.Отгонбат
*Гүйцэтгэх захирал*

**Боловсрол**
- 2011-2013, МУИС, Олон Улсын эдийн засгийн харилцааны магистр;
- 2006-2010, Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;
- 1992-2002, 12-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2013-Одоо, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн;
- 2017-Одоо, “Бэрс финанс ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008-2009, "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;
- 2006-2007, “Оргил-Хотхон” ХХК, Гүйцэтгэх захирал.



Б.Баярчимэг
*Дэд захирал*

**Боловсрол**
- 2019-2021, ХААИС, Бизнесийн удирдлагын магистр;
- 1999-2003, СЭЗИС, Банк санхүүч, бакалавр;
- 1989-1999, 24-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Дэд захирал;
- 2018-2019, “Голомт банк”, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал;
- 2003-2017, “Төрийн банк”, Хяналт шалгалтын газрын захирал.



Б.Даваабат
*Бизнес хөгжлийн газрын захирал*

**Боловсрол**
- 2008-2011, СУИС, Соёлын арга зүйч, Бакалавр;
- 2006-2008, Соёлын коллеж, Компьютерийн оператор, тусгай дунд;
- 1996-2006, 13-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2021-Одоо, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Бизнес хөгжлийн газрын захирал;
- 2020-2021, “Оранж электроникс“ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2016-2021, “Бичил Глобус” ХХК, Маркетингийн менежер;
- 2012-2016, “Креатив пролайн" ХХК, Брэнд менежер, Креатив директор;
- 2011-2012, “Хийморь принтинг” ХХК, Ахлах дизайнер.



Я.Адъяахүү
*Санхүү бүртгэлийн газрын захирал*

**Боловсрол**
- 1997-1998, Япон Улс, Сайтама их сургууль, Төрийн удирдлагын магистр;
- 1987-1991, МУИС-ЭЗС, Банкны эдийн засгийн бакалавр;
- 1975-1985, Улаанбаатар хотын 1-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2020-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Санхүү бүртгэлийн газрын захирал;
- 2018-2020, “Нэткапитал ББСБ” ХХК, Эрсдэлийн захирал, Дэд захирал;
- 2015-2017, “Глашиер ассет” ХОМК, Гүйцэтгэх захирал;
- 2009-2015, “Хас банк”, Хэлтсийн захирал, Газрын захирал;
- 1998-2009, “Худалдаа хөгжлийн банк”, Эдийн засагч, Эрсдэлийн шинжээч, Дотоод хяналтын алба, Газрын ахлах;
- 1992-1997, “Зах зээл судлалын хүрээлэн”, Судлаач.



Н.Гантулга
*Зээлийн газрын захирал*

**Боловсрол**
- 2011-2012, Газарчин их сургууль, Бизнесийн удирдлагын магистр;
- 2001-2005, ШУТИС, Математик загварчлал, Бакалавр;
- 1991-2001, Увс аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2021-Одоо, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Зээлийн газрын захирал;
- 2019-2021, "Бичил глобус ББСБ" ХХК, Салбарын удирдлагын мэргэжилтэн;
- 2017-2019, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Салбарын захирал;
- 2015-2017, “Бичил глобус финанс ББСБ" ХХК, Зээлийн менежер;
- 2014-2015, “Аварга Соёо” ХХК, Оффис менежер.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
он сар өдөр
2023.06.02 В
№ 01



Г.Юмсүрэн
*Дотоод хяналтын газрын захирал*

**Боловсрол**
- 2018-2020, СЭЗИС, Бизнесийн удирдлагын магистр;
- 2005-2010, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр;
- 1995-2005, Говь-Алтай аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**
- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Дотоод хяналтын газрын захирал;
- 2019-Одоо, "Добу кредит" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2017-2019, "Бичил глобус" ХХК, Зээлийн хэлтсийн захирал;
- 2011-2017, "Бичил глобус групп" ХХК, Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал;
- 2011, "Бичил глобус" ХХК, Менежер.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### 1000 цунх аян



Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "1000 цүнх" сайн үйлсийн аянд Бичил глобус финанс ББСБ нэгдэж амжилттай оролцож байна.

### Улаан загалмай нийгэмлэгтэй хамтрав




2019 онд Бичил глобус ХХК нь сайн үйлсийн аянаа улам төгөлдөржүүлэх зорилгоор Монголын улаан загалмай нийгэмлэгтэй гэр бүл, хүүхэд залуучуудыг хөгжүүлэх чиглэлд урт хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулав.

### "Тэрбум мод" хөдөлгөөнд нэгдэв



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд ББСБ-аа төлөөлж өөрсдийн зүгээс Монгол Улсдаа 500,000 мод тарих сайн дурын ажлыг зохион байгуулахаар хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.

### Амьдрал бэлэглэе аян




Коронавируст цар тахлын үед 51 бяцхан зүрхний амийг аврахад сайн дураараа Бичил Глобус финанс ББСБ-ын хамт олон цусаа өгч донор өдөрлөгт оролцов.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛ ТЗК ХХК
АТА9998 4 6999131
9023050154

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

## "ДуДу" хүүхдийн музей




Цар тахалтай хүнд хэцүү үед хүүхэд багачуудын цагаа өнгөрөөх дуртай ДуДу хүүхдийн музейд салбар нэгжүүд болон Төв салбарын ажилчид сайн дураараа ДуДу-г зогсоохгүйн төлөө нэгдэв.

## 1000 мод тарих төсөл




Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч цаг уурын нөхцөл байдалд хамгийн их өртөж байгаа Өвөрхангай аймагт сайн дурын ажилчидтайгаа хамт 1000 модыг тарьж ургах ургалтын системээр хангаж ажилласан.

## Хүүхдийн сайн үйлсийн аян




Бичил Глобус ХХК нь 2020 онд Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р дунд сургуулийн сурагч нарт "Хүмүүнлэгийн танхим" тохижуулж, хүлээлгэн өгөв. Мөн "Хүүхдийн баяр"-ын өдрийг тохиолдуулан гэмтлийн ГСҮТ-ийн Түлэнхий төвд 24 цаг тасралтгүй ашиглагдах хяналтын аппарат бэлэглэв.

## Хайртай бүхэндээ хамгаалах бүс



Бичил глобус санхүүгийн нэгдлээс "Хайртай бүхэндээ хамгаалах бүс" аян зарлаж жолооч нартаа зам тээврийн хөдөлгөөнд оролцохдоо бүсээ зүүж, гэр бүлээ хамгаалаарай гэсэн сануулгатай дугаарын тэмдэглэгээг 3,000 ширхэг хэвлэн хотоос гарч буй жолооч нартаа үнэ төлбөргүй тараасан.

## Орон сууцжуулах хөтөлбөр




2009-2018 онд Санхүүгийн нэгдлийнхээ 8 ажилтанд буцаалтгүйгээр Орон сууцны урьдчилгаа төлбөр олгосон.

## Монголын Залуучуудын Холбоо



2017 онд Монголын Залуучуудын Холбооны дэргэдэх Бичил Глобус санхүүгийн байгууллагын салбар зөвлөлийг байгуулсан.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПИ ЭС ТЗК ХХК
АТА9998 6969131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН АМЖИЛТ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

### АЛТАН ОД ШАГНАЛ




2021 онд Банк бус санхүүгийн салбарын "Шилдгийн шилдэг" Банк бус санхүүгийн байгууллагаар шалгарав.

### АЛТАН ОД ШАГНАЛ



2022 онд Банк бус санхүүгийн салбарын "Шилдгийн шилдэг" Банк бус санхүүгийн байгууллагаар шалгарав.

### GRAND 2018 ШАГНАЛ




2018 онд Монголын маркетинг менежментийн холбооны Банк, санхүүгийн салбарын шилдэг байгууллага шагнал "Grand гранпри" хүртэв.

### НАЙДВАРТАЙ ТАТВАР ТӨЛӨГЧ



2016 онд татвар төлөлтөөрөө дүүрэгтээ тэргүүлж "Найдвартай татвар төлөгч байгууллага"-аар шалгарсан.

### ЖУУХ БИЧИГ




2015 онд Хариуцлагатай нийгмийн даатгал төлөгч байгууллагаар шалгаран Нийслэлийн нийгмийн даатгалын газрын "Жуух бичиг"-ээр шагнагдав.

### ТАЛАРХАЛЫН БИЧИГ




2013 онд Монгол Улсын Татварын ерөнхий газар-аас Монгол Улсын татвар, хууль тогтоомжийг шударгаар сахиж, улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсанг үнэлэн Талархалын бичгээр шагнав.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

СЗХ
2023 .06. 02
БҮРТГЭВ
№ 01

# 2.5. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

*Хүснэгт 7. Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг)*

| Нийт хөрөнгө | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,522,608 | 2,386,894 | 5,542,376 |
| Нийт зээл | 24,036,597 | 42,645,565 | 64,369,867 |
| *Зээлийн эрсдэлийн сан* | *(798,691)* | *(369,147)* | *(350,373)* |
| Факторингийн тооцооны авлага, цэвэр | 2,273,101 | 980,630 | 225,370 |
| Эргэлтийн бусад хөрөнгө | 843,327 | 977,935 | 1,407,174 |
| **Эргэлтийн хөрөнгийн нийт дүн** | **27,876,942** | **46,621,877** | **71,194,414** |
| Эд хогшил | 121,579 | 144,925 | 242,585 |
| *Хуримтлагдсан элэгдэл* | *(65,856)* | *(86,702)* | *(112,723)* |
| Тээврийн хэрэгсэл, компьютер ба техник хэрэгсэл | 328,263 | 400,718 | 710,602 |
| *Хуримтлагдсан элэгдэл* | *(112,349)* | *(163,455)* | *(240,024)* |
| **Эргэлтийн бус нийт хөрөнгийн дүн** | **271,637** | **295,486** | **600,440** |
| Нийт хөрөнгийн дүн | 28,148,579 | 46,917,363 | 71,794,854 |

| Өр төлбөр ба эздийн өмч | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| Богино хугацаат зээл | - | 10,889,367 | 14,737,502 |
| Өрийн бичгээрх өглөг | 1,567,000 | 7,343,000 | 7,782,000 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 1,832,082 | 9,436,100 | 13,500,405 |
| Факторингийн үйлчилгээний өглөг | 1,606,653 | - | - |
| Бусад өр төлбөр | 4,743,100 | 1,435,571 | 7,526,298 |
| **Богино хугацаат өр төлбөр** | **9,748,835** | **29,104,038** | **43,546,205** |
| Урт хугацаат зээл | 5,731,000 | - | 5,041,000 |
| **Урт хугацаат өр төлбөр** | **5,731,000** | - | 5,041,000 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **15,479,835** | **29,104,038** | **48,587,205** |
| Энгийн хувьцаа | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 7,668,744 | 12,813,325 | 18,207,649 |
| Тайлант үеийн ашиг | 3,445,657 | 5,144,581 | 5,394,324 |
| Өмнө үеийн ашиг (алдагдал) | 4,223,087 | 7,668,744 | 12,813,325 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **12,668,744** | **17,813,325** | **23,207,649** |
| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | 28,148,579 | 46,917,363 | 71,794,854 |

*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

2022 онд нийт хөрөнгө 71.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оноос 53.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020-2021 онд буюу Монгол Улсад Коронавирус цар тахал (Ковид-19) -ын хөл хорионы дэглэм мөрдөгдөж байсан цаг үеүдэд нийт зээлийн багцаа 2021 онд 66.7 хувиар өсгөж чаджээ.

Нийт хөрөнгийн сүүлийн 3 жилийн дундаж өсөлт (CAGR) 59.7 хувь байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө 2022 онд ийнхүү хурдтай өсөхөд богино хугацаат зээл, өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээгээр татсан богино хугацаат өр төлбөр өмнөх онтой харьцуулахад 8.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

*График 18. Нийт хөрөнгө (тэрбум төгрөг) ба хөрөнгийн өсөлт (хувиар)*




Нийт хөрөнгийн бүтцийг задалбал 2022 оны эцсийн байдлаар 89.2 хувь буюу 64.0 тэрбум төгрөгийг зээлийн эрсдэлийн санг хасаж тооцсон цэвэр зээлийн үлдэгдэл эзэлж байна. Бэлэн мөнгө болон банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн дүн нийт хөрөнгөд 7.7% буюу 5.5 тэрбум төгрөгийг бүрдүүлж байна.

*График 19. Нийт хөрөнгийн бүтэц, актив талаас (тэрбум төгрөг)*




Нийт хөрөнгийн бүтцийг 2022 оны байдлаар эх үүсвэр талаас авч үзвэл нийт хөрөнгийн 57.7 хувь буюу 48.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг богино хугацаат зээл, өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээ, бусад өр төлбөр бүрдүүлж байна. Харин нийт хөрөнгийн 32.3 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

*График 20. Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас (тэрбум төгрөг)*




Нийт өр төлбөрийн бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 3 жилээр харвал 2020 онд банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээлийн санхүүжилт 37.0 хувь,

богино хугацаат өр төлбөрийн эх үүсвэр 63.0 хувийг эзэлж байжээ. 2021 оноос эх үүсвэрийн бүтцээ төрөлжүүлэн, 2022 оны эцэст итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр 31.0 хувь, богино хугацаат зээл 33.8 хувь, өрийн бичгээр татсан санхүүжилт 17.9 хувийг тус тус эзэлж байна.

*График 21. Өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг)*




Нийт зээлийн багцын чанарын хувьд 2022 онд хэвийн зээлийн багц 97.6 хувь, хугацаа хэтэрсэн зээл 1.5 хувь, чанаргүй зээлийн дүн 0.9 хувь тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн дүн 560.4 сая төгрөг байгаа бол зээлийн эрсдэлийн сандаа 350.4 сая төгрөгийн зээлийн эрсдэлээ удирдах нөөц сан байгуулжээ.

Бичил глобус финанс ББСБ-ын чанаргүй зээлийн түвшин 0.9 хувь байгаа нь банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн 7.6 хувьтай харьцуулахад 7.7 дахин бага үзүүлэлт болж байна. Ийнхүү анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын чанар маш сайн байгаа нь тус компанийн 2008 оноос хойш тасралтгүй, тогтвортойгоор үйл ажиллагаагаа эрхэлж, харилцагчдын түүхэн мэдээллийн бааз суурь, итгэлцэл, салбарын туршлагыг хуримтлуулж чадсантай холбоотой юм.

*График 22. Зээлийн багцын чанар*




*Хүснэгт 8. Орлого, үр дүнгийн тайлан, мянган төгрөг*

| Орлого, үр дүнгийн тайлан | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 8,783,344 | 10,238,660 | 20,598,828 |
| Зээлийн хүүгийн орлого | 7,901,043 | 9,708,232 | 20,402,597 |
| Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого | 882,301 | 530,428 | 196,231 |
| Хүүгийн зардал | (2,729,947) | (2,285,635) | (6,406,105) |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | (2,271,001) | (1,923,164) | (5,226,297) |

| | | | |
|---|---|---|---|
| Өрийн бичгийн хүүгийн зардал | (458,946) | (362,471) | (1,179,808) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **6,053,397** | **7,953,025** | **14,192,723** |
| Хүүгийн бус орлого | 76,982 | 101,362 | 516,428 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 2,296 | 775 | - |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 74,686 | 100,587 | 516,428 |
| Хүүгийн бус зардал | (1,653,155) | (2,787,053) | (8,726,212) |
| Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал | (20,967) | (781) | (238,460) |
| Боловсон хүчний зардал | (1,073,022) | (1,861,909) | (3,458,694) |
| Бусад үйл ажиллагааны зардал | (559,166) | (924,363) | (5,029,058) |
| **Цэвэр хүүгийн бус орлого (зардал)** | **(1,576,173)** | **(2,685,691)** | **(8,209,784)** |
| Болзошгүй эрсдэлийн сангаас өмнөх үйл ажиллагааны ашиг | 4,477,224 | 5,267,334 | 5,982,939 |
| Болзошгүй эрсдэлийн сан | (609,848) | 453,758 | 29,700 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | **3,867,376** | **5,721,092** | **6,012,639** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 1,989 | 36 | 5,656 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (36,970) | (4,438) | (13,558) |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг** | **3,832,395** | **5,716,690** | **6,004,737** |
| Татвар | (386,738) | (572,109) | (610,413) |
| Цэвэр ашиг (алдагдал) | 3,445,657 | 5,144,581 | 5,394,324 |

*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

2022 оны эцэст нийт цэвэр орлогын хэмжээ 14.7 тэрбум төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оноос 6.7 тэрбум төгрөгөөр буюу 82.6 хувиар өссөн байна. Цэвэр ашгийн хэмжээ 2021 онд 5.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 49.3 хувиар өссөн бол 2022 оны байдлаар 5.4 тэрбум төгрөгт хүрчээ. Сүүлийн гурван жилд цэвэр ашгийн дүн жилд дунджаар (CAGR) 25.1 хувиар өсөөд байна.

*График 23. Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг, (тэрбум төгрөг)*




Бичил глобус финанс ББСБ-ын цэвэр ашгийн маржин 2022 онд 25.5 хувь байгаа бол өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт 23.2 хувь буюу 2020 оны 27.2 хувийн түвшнээс буурсан үзүүлэлттэй байна. Ийнхүү өөрийн хөрөнгийн өгөөж буурсан нь эх үүсвэрийн бүтцэд нийт өр төлбөрийн эзлэх хэмжээ 2020 онд 15.4 тэрбум төгрөг байснаас 2022 онд 48.6 тэрбум төгрөг болж гурав дахин нэмэгдэж, эх үүсвэрийн хүүгийн зардал өссөн нь цэвэр ашгийг бууруулсан байна.

Бичил глобус финанс ББСБ 2022 онд 5.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахад цэвэр хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 78.4 хувиар өссөн хэдий боловч хүүгийн бус зардал компанийн өргөжилттэй холбоотой 2 дахин өсөж 8.7 тэрбум төгрөгт хүрсэн, бусад үйл ажиллагааны зардал 4 дахин өсөж 5.0 тэрбум төгрөгт хүрсэн нь тус тус ашгийг буурахад нөлөөлжээ.

*График 24. Ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөжийн харьцаа үзүүлэлтүүд*




Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 2022 онд 77.1 тэрбум төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оноос 23.9 тэрбум төгрөгөөр буюу 45.0 хувиар өссөн. Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 11.5 тэрбум төгрөгийн илүүдэлтэй буюу зээл олголт, эх үүсвэрийн зардлын мөнгөн төлбөрийг бүрэн төлөх чадамж бүхий мөнгөн урсгалтай байна.

*Хүснэгт 9. Мөнгөн гүйлгээний тайлан, мянган төгрөг*

| Мөнгөн гүйлгээ | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **35,297,295** | **53,186,009** | **77,145,593** |
| Зээлийн хүүгийн орлого | 7,598,131 | 9,546,224 | 20,473,443 |
| Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого | 902,591 | 592,481 | 196,365 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 76,981 | 76,089 | 472,056 |
| Бусад орлого | 26,719,592 | 42,971,215 | 56,003,729 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **(33,670,959)** | **(67,496,944)** | **(65,681,920)** |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн төлбөрт төлсөн | (128,555) | (5,893,358) | (3,818,097) |
| Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал | (5,839) | - | - |
| Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө | (443,340) | (242,525) | (583,540) |
| Боловсон хүчний зардал | (1,025,856) | (1,812,983) | (2,485,265) |
| Бусад мөнгөн зарлага | (32,067,369) | (59,548,078) | (58,795,018) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,626,336** | **(14,310,935)** | **11,463,673** |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого | 19,905,304 | 64,141,538 | 98,097,392 |

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага | (21,370,475) | (48,966,317) | (106,405,583) |
| **Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,465,171)** | **15,175,221** | **(8,308,191)** |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 161,165 | 864,286 | 3,155,482 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,361,443 | 1,522,608 | 2,386,894 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,522,608 | 2,386,894 | 5,542,376 |

2022 оны эцэст Бичил глобус финанс ББСБ-ын цэвэр мөнгөн гүйлгээ 3,155.5 сая төгрөг байсан бол эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.5 тэрбум төгрөг байжээ. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл жилд дунджаар 90.8 хувиар нэмэгдэж байна. Мөнгөн хөрөнгө ийнхүү нэмэгдэж байгаа нь тус компанийн богино хугацаанд түргэн хөрвөх чадварыг нэмэгдүүлж байна.

*Хүснэгт 10. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд*

| Харьцаа үзүүлэлтүүд | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа (current ratio) | 2.9 | 1.6 | 1.6 |
| Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа (quick ratio) | 2.8 | 1.6 | 1.6 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн харьцаа (cash ratio) | 0.16 | 0.08 | 0.13 |
| Өр зээл ба бэлэн мөнгөний харьцаа (Total loan to total deposit ratio) | 7.1 | 11.6 | 7.4 |

Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа 2022 онд 13.0 хувь орчимд хадгалагдаж байна. Эргэлтийн харьцаа буюу богино хугацаат хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар 1.6 буюу маш сайн байна. Эргэлтийн хөрөнгөд нийт зээлийн багц харьяалагдаж байгаа учраас эргэлтийн хөрөнгийн дүн богино хугацаат өр төлбөрөөс давсан үзүүлэлттэй байна.

*График 25. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг)*




*Хүснэгт 11. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

| Зохистой үзүүлэлт | Шалгуур | Тайлангаар | Шалгуур хангасан эсэх |
|---|---|---|---|
| **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт** | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 32.8% | Тийм |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15

СЗХ БҮРТГЭВ

| | | | |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 32.8% | Тийм |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 32.2% | Тийм |
| **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа** | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 12.0% | Тийм |
| **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт** | | | |
| Хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, - дутуу) | 356,980.4 | 356,980.4 | Тийм |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 0.8% | Тийм |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 0.7% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.2% | Тийм |
| Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| **Гадаад валютын ханшийн эрсдэл** | | | |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | ±40% хооронд | 0.0% | Тийм |
| **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 58.4% | Тийм |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 33.6% | Тийм |
| **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт** | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 0.8% | Тийм |
| **Өгөөж** | | | |
| Хөрөнгө (актив)-ийн өгөөж | | | 9.0% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | | 26.0% |

*Эх сурвалж: Бичил глобус финанс ББСБ-ын СЗХ-нд тайлагнасан 2022 оны жилийн эцсийн тайлан*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -06- 15

СЗХ БҮРТГЭВ

Банк бус, санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Бичил глобус финанс ББСБ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хангаж ажиллаж байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайн, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар шалгуурыг хангасан байгаа бол актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт болох нэг этгээд эсвэл хамааралтай талуудад олгох зээлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаан ажиллаж байна.

Мөн өөрийн хөрөнгийн 80.0 хүртэлх хувийн үнийн дүнтэй тэнцэх итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр болон өөрийн хөрөнгийн 50.0 хувь хүртэлх дүнгээр өрийн хэрэгсэл татах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байна. Банк бус, санхүүгийн байгууллагын үндсэн хөрөнгийн зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй байх шалгуурыг мөн хангаж байна.

## 2.6. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, түүнийг хэрхэн удирдах талаар дараах эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч ажилладаг.

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

**Макро эдийн засгийн эрсдэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтмол хянан, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдал, эрсдэл даах чадварыг үнэлж, зээлийн багцын төвлөрлөөс сэргийлэх зорилгоор СЗХ-ноос тогтоосон зохистой харьцааны шалгуурыг хангах, мөн холбогдох журмуудыг мөрдлөг болгох зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг.

**Хууль эрх зүйн орчин, зохицуулалтын эрсдэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдөх замаар эрх зүйн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.

**Зээлийн эрсдэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшинг тооцон, зээлийн үнэ цэнийн бууралт, чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн гаргасан зээлийн хувьд тогтмол хяналт тавин үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг.

**Хүүгийн эрсдэл**

Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээлийн хүүгийн нөхцөл байдлын шинжилгээ болон бусад зохистой харьцаа, хязгаар үзүүлэлтийг харгалзан зээлийн хүүг эх үүсвэрийн өртөгтэй уялдуулан тогтоодог.

### Үйл ажиллагааны эрсдэл

Дотоод үйл ажиллагаа, хяналтын систем, хүний хүчин зүйл болон технологийн доголдлоос бий болж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг.

### Төлбөрийн болон хөрвөх чадварын эрсдэл

СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон дотоодын санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг. Мөн эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэлийн засаглалын бүтцийн дагуу эрсдэлийн удирдлагын "Гурван давхар хамгаалалтын шугам"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг.

*Схем 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц*



## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ДОТООД ЖУРМУУДЫН ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын шинэ кодексыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах холбогдох журмуудыг баталжээ. Үүнд:

- **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам** Энэхүү журмаар ТУЗ-ийн бүрэн эрх, түүний бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, сонгох, хугацаанаас өмнө чөлөөлөх журам, дарга, гишүүд, нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага, ТУЗ-ийн хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэрэг харилцааг зохицуулж байна.
- **Дотоод хяналт, аудитын үйл ажиллагааны журам** Тус журамд компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоог бүрдүүлэх нь гүйцэтгэх захирлын үүрэг байх тухай зааж өгсөн бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлангийн талаар, хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах, комплайнсийн талаар, дотоод аудиторын эрх, үүрэг, аудиторын хараат бус байдал, дотоод аудитын үйл ажиллагааг удирдах ТУЗ-ийн бүрэн эрх, дотоод аудитын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэл зэрэг дотоод журмын заалтуудыг тусгажээ.
- **Эрсдэлийн удирдлагын бодлого, журам** Энэхүү журмын зорилго нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, баримтлах зарчим, эрсдэлийн ангиллыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шатыг тогтоох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдахтай холбогдон ажилтан, албан тушаалтан бүрийн эрх, үүргийг тодорхойлох, хянахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах юм.
- **Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгох журам** Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх, аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллагааг энэхүү журмаар зохицуулж байна.
- **Залгамж халааны бодлого** Тус журмаар ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг бэлдэх үйл ажиллагааг зохицуулахад оршино. ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халаа гэдэг нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын орон тоо гарсан тохиолдолд тэдний оронд сонгох хүний нөөцийг ойлгоно.
- **Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам** Энэхүү журмаар компаниас хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчдад болон нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгсэл (нэвтрүүлэх, нийлүүлэх мэдээллийн хэрэгсэл, давтамж), хариуцах албан тушаалтан зэргийг тогтооно. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь нийтийн хүртээл болгох замаар компанийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, дотоод буюу нийтийн хүртээл болоогүй мэдээллийг шударга бусаар ашиглахаас сэргийлэх нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг байна.
- **Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам** Тус журмаар компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулах ба хэлцэл хийх журам, сонирхлын зөрчилтэй этгээдэд тавих шаардлага, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний үр

дагавар, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас үүсэх хохирлыг арилгах, хариуцлагын талаар тусгажээ.

- **Мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдох сонирхлын зөрчлийг зохицуулах журам** Бичил глобус финанс ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа болох зээлийн болон итгэлцлийн үйл ажиллагаатай холбогдон компани, ажилтнууд болон компани хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн хооронд үүсч болох сонирхлын зөрчлийг бууруулах, үүссэн үед ил тод тайлагнах замаар хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- **Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам** Энэхүү журмын зорилго нь Бичил глобус финанс ББСБ-ын хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, тэд нарт мэдээлэл хүргэх чиглэл, зарчимыг тогтооход оршино.
- **Шүгэл үлээх үйл ажиллагааг зохицуулах журам** Тус журмаар компанийн хэмжээнд шүгэл үлээх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилготой. Мөн энэ журамд шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээх ажиллагааг хэрэгжүүлэх, шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ, хариуцлага зэрэг зохицуулалтыг тусгасан байна.
- **Ёс зүйн дүрэм** Энэхүү журмаар Бичил глобус финанс ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд болон бүх ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим, дүрмийг тогтоож өгсөн байна. Мөн ажилтан үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ баримтлах зарчим, хариуцлагыг Ёс зүйн дүрэмдээ оруулсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

УЛААНБААТАР ХОТ
АТА9998

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# ГУРАВ. Үнэт цаас гаргагчийн тухай

БИЧИЛ 2.0

ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Үүсгэн байгуулагчийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 23/01а/01 тоот шийдвэрээр Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 118 дугаар тогтоолоор олгогдсон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Тусгай зориулалтын компани буюу Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК болж компанийн үйл ажиллагааны чиглэл болон нэршил өөрчлөгдсөн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байна.

*Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл*

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК |
| Хувьцаа эзэмшигч | Бичил глобус финанс ББСБ ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2023.03.01 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011849203 |
| Улсын бүртгэлд бүртгэсэн огноо | 2023.05.01 |
| Регистрийн дугаар | 6999131 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж, 101 барилга, 705 тоот |
| Утас | +976 9911-9632 |
| Үнэт цаас гаргагчийн захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн цахим шуудан, цахим хаяг | info@bichilglobus.mn , www.bichilglobus.mn |
| Шуудангийн хаяг | - |
| Биржид бүртгэлтэй эсэх | Үгүй |

*Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл*

| | |
|---|---|
| Зарласан буюу гаргасан хувьцааны тоо | 1,000.0 (нэг мянга) ширхэг |
| Хувьцааны төрөл | Энгийн хувьцаа |
| Нэрлэсэн үнэ | 1,000.0 (нэг мянга) төгрөг |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1,000,000.0 (нэг сая) төгрөг |
| Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр | "Бичил глобус финанс ББСБ" ХХК |
| Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь | 100 (нэг зуун) хувь буюу 1,000 (нэг мянга) ширхэг энгийн хувьцаа |

## 3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй тусгай зориулалтын компани тул бүтэц, зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эрх, үүрэг нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулагдан үйл ажиллагаагаа явуулна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ (ХЭХ)

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байх ба компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлэхээр заажээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх хэмжээг Компанийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

*Схем 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлууд*

- СЗХ-ны зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Үнэт цаас гаргагчийн дүрмийн шинэчилсэн дүрмийг батлах ба энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Дүрэмд нэмэлт өөрчлөлтийг хөрөнгө оруулагчдад ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх;
- Үнэт цаас гаргагчийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Үнэт цаас гаргагчийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- Хууль тогтоомжид заасан бусад асуудал;

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам болон Компанийн дүрэмд заасан Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь дор дурдсан болон бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-15

СЗХ
он сар өдөр
ХҮЛЭЭН АВСАН
№ 01

- ТЗК-ийн хувьцаа эзэмшигчид нь СЗХ-ноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй;
- Үнэт цаас гаргагчийн эсрэг өөрийн шаардлага, эсвэл түүний өмнө Үнэт цаас гаргагчийн аливаа хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотойгоор аливаа хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Үнэт цаас гаргагчид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал гаргах эрхгүй;
- Хууль болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 8.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн татан буулгахаар хүсэлт гаргах эрхгүй байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ хэрэгжүүлэхээр тусгасан. Иймд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ.

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Компанийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч болон хөндлөнгийн аудиторыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох журмын дагуу сонгох;
- Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих;
- Компанийн дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
- ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
- ТЗК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6989131
9023050164

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 .06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- ТЗК-ийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
- Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;
- Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хороо болон Биржээс баталсан журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- Хуульд заасан бусад.

Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасны дагуу ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн ТЗК татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь энэхүү үнэт цаасны танилцуулгын үнэн зөвийг бүрэн хариуцна.

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/25а/02 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 23/25а/03 дугаар тогтоолоор ТУЗ-ийн даргаар Н.Гантулгыг сонгосон байна.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИР ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183865
9021031195 СТС2420

*Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн*

| | |
|---|---|
| <br>Н.Гантулга<br>*ТУЗ-ийн дарга* | **Боловсрол**<br>• 2011-2012, Газарчин их сургууль, Бизнесийн удирдлагын магистр;<br>• 2001-2005, ШУТИС, Математик загварчлал, Бакалавр;<br>• 1991-2001, Увс аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.<br>**Ажлын туршлага**<br>• 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Салбарын удирдлагын мэргэжилтэн, Зээлийн газрын захирал;<br>• 2017-2019, "Бичил глобус ББСБ" ХХК, Салбарын захирал;<br>• 2015-2017, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Зээлийн менежер;<br>• 2014-2015, "Аварга Соёо" ХХК, Оффис менежер; |
| <br>Ц.Азбаяр<br>*ТУЗ-ийн Хараат бус гишүүн* | **Боловсрол**<br>• 2019-Одоо, СЭЗИС, Бизнесийн удирдлагын докторант;<br>• 2007-2010, СЭЗИС, Бизнесийн удирдлагын бакалавр;<br>• 2005-2007, Их засаг Олон Улсын их сургууль, Хууль зүйн магистр;<br>• 2001-2005, Их засаг Олон Улсын их сургууль, Эрх зүйн бакалавр;<br>• 1991-2001, Хэнтий аймаг, Бүрэн дунд.<br>**Ажлын туршлага**<br>• 2022-Одоо, "Өмгөөллийн бизнес Ло ХХН", Захирал;<br>• 2012-2021, "Хан Голомт төв НҮТББ", Захирал;<br>• 2012-2014, "Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар", Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын албанд ахлах;<br>• 2011-2012, "Улсын Их Хурлын Тамгын Газар", Улсын Их Хурлын гишүүний зөвлөх;<br>• 2005-2011, "Их засаг Олон Улсын их сургууль", Багш, Маркетингийн албаны дарга. |
| <br>Б.Баасандорж<br>*ТУЗ-ийн Хараат бус гишүүн* | **Боловсрол**<br>• 2017-2019, СЭЗИС, Санхүүч мэргэжлээр бакалавр;<br>• 2012-2015, Төв Хятадын Шинжлэх ухаан, технологийн их сургууль, харьцуулсан эрх зүйн чиглэлээр Эрх зүйн магистр;<br>• 2005-2010, МУИС-Хууль зүйн сургууль, Олон улсын эрх зүйч мэргэжлээр Эрх зүйн бакалавр;<br>• 1995-2005, Боловсрол цогцолбор, Бүрэн дунд.<br>**Ажлын туршлага**<br>• 2019-Одоо, МУИС-Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн Санхүү, татварын эрх зүйн багш;<br>• 2016-Одоо, "Өмгөөллийн Баасандорж консалтинг" ХХК, Үүсгэн байгуулагч;<br>• 2013-2022, "Өмгөөллийн Батбаяр Энд Партнэрс ХХН", Ахлах хуульч, Гишүүн өмгөөлөгч, Гүйцэтгэх захирал;;<br>• 2010-2011, , "Энержи Ресурс" ХХК, Хуулийн мэргэжилтэн. |

## ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 23/607 дугаартай "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-г нэг талаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК, нөгөө талаас Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК нар байгуулсан. Тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулах зорилготой.

Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх өдөр зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг багц болгон худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг энэхүү гэрээнд заасан солих, хөрөнгийн багцыг гэрээнд заасан үндэслэлээр нэмэх нөхцөлтэйгээр худалдахаар тохиролцсон

байна. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах бөгөөд Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үргэлжлэх хугацаанд талаад Хөрөнгө оруулагч буюу үнэт цаас эзэмшигчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж идэвхтэй, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллах гэрээ байгуулсан.

### Хөрөнгө худалдах үндсэн нөхцөл

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2-т зааснаар ТЗК нь Хөрөнгийг шилжүүлэн авснаар тухайн Хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, фидуци, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хөрөнгөтэй хамт шилжүүлэн авсанд тооцно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийг худалдан шилжүүлэх жагсаалт үйлдэн шилжүүлэх бөгөөд хөрөнгийг солих болон нэмж худалдаж болох нөхцөлтэйгөөр худалдаж байгаа болно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11, 14.3-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо Хөрөнгийн багцыг бүртгэсэн өдөр уг багцад орсон хөрөнгийг ТЗК-ийн өмчлөлд шилжсэнд тооцно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээлдэгчийн зээлтэй холбоотой зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг үнэт цаас гаргагчид хүргүүлэх, хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж,уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэг хүлээнэ.

### Зээлийн данс бүртгэл хөтлөх, баримт бичгийг хадгалах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлээс тусад нь данс бүртгэл үүсгэн хадгалах бөгөөд санхүүгийн тайлан тэнцлийг тусад нь хөтөлж холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална.
- Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч, мөн бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь дээрх шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай ББСБ-д мэдэгдсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан ТЗК-д материалыг хүргүүлэх эсхүл ажлын байран дээрээ ажлын цагаар томилогдсон ажилтныг ажиллах боломжоор хангах үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тайланг хүлээн авч хянан баталгаажуулна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-03-15
СЗХ №01
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164

### Барьцааны зүйл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2 дахь заалтын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээний дагуу худалдах, солих, нэмэх зэргээр ТЗК-д шилжүүлэх Хөрөнгийн багцын авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, барьцаа, фидуци, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа бусад арга, санхүүгийн хэрэгсэл зэрэг орно)-ийг ТЗК-д шилжүүлж барьцаалуулна.

### Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээний хэлцэл биелэгдэх өдөр байгуулна.
- Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ББСБ нь хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийг Зээлдэгчдээс цуглуулан үнэт цаас гаргагчид сар тутамд сарын төлбөрийн хуваарьт өдөр шилжүүлэх, ТЗК нь үйлчилгээний төлбөр болон шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.

### Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийг буцаан худалдаж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг хөрөнгийг бусад гуравдагч этгээдэд худалдах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь гуравдагч этгээдэд хөрөнгө худалдсанаас үүссэн хохирлоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд түүнд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хөрөнгийг буцаан худалдахдаа Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний тусгай нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан доорх нөхцөл байдал үүссэн тохиолдолд ТЗК-ийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-аар тогтоосон зарчмын дагуу буцаан худалдана.
    - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
    - Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
    - Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

## 3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үнэт цаас гаргагч нь Компанийн дүрэмд зааснаар нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1,000 ширхэг зарласан болон гаргасан энгийн хувьцаа бүхий 1,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулагдсан.

*Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн санхүүгийн тайлан, тэнцэл*

| № | Үзүүлэлт | Актив | Пассив |
|---|---|---|---|
| 1 | Мөнгөн хөрөнгө | 1,000,000 | - |
| 2 | Хувь нийлүүлсэн хөрөнгө | - | 1,000,000 |
| | Тэнцэл | 1,000,000 | 1,000,000 |

2023-06-15
СЗХ
№ 01

## 3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/10 тоот "Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай" тогтоолоор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны буюу 2023-2025 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

### САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөллийг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлт дээр үндэслэн дараах байдлаар төсөөлсөн болно. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үндсэн төлбөрийн 50 хувийг ХБҮЦ-ны хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа, үлдсэн төлбөрийг хугацааны эцэст төлөх учраас тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 24 дахь сар дээр нийт зээлийн үлдэгдэл үнэт цаасны нийт үндсэн төлбөрийн дүнгээр буурах төсөөлөлтэй байна.

*Хүснэгт 16. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр*

| Үзүүлэлт | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | 1 | 3,987 | 7,463 | 11,535 | 6,063 | 10,329 | 13,148 | 15,310 | 7,429 |
| Нийт зээл | 24,237 | 21,096 | 18,441 | 15,046 | 11,024 | 7,202 | 4,681 | 2,719 | 702 |
| Эрсдэлийн сан | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | 24,238 | 25,083 | 25,903 | 26,581 | 17,087 | 17,531 | 17,829 | 18,029 | 8,131 |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 20,000 | 20,000 | 20,000 | 20,000 | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 | - |
| Бусад өглөг | 4,237 | 4,236 | 4,236 | 4,236 | 4,236 | 4,236 | 4,236 | 4,236 | 4,236 |
| Өр төлбөрийн дүн | 24,237 | 24,236 | 24,236 | 24,236 | 14,236 | 14,236 | 14,236 | 14,236 | 4,236 |
| Хувьцаат капитал | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хуримтлагдсан ашиг | - | - | 846 | 1,666 | 2,344 | 2,850 | 3,293 | 3,592 | 3,792 |
| Татварын дараах ашиг | - | 846 | 820 | 678 | 506 | 443 | 299 | 199 | 102 |
| Нийт өөрийн хөрөнгө | 1 | 847 | 1,667 | 2,345 | 2,851 | 3,294 | 3,593 | 3,793 | 3,895 |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | 24,238 | 25,083 | 25,903 | 26,581 | 17,087 | 17,531 | 17,829 | 18,029 | 8,131 |

Үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9.2 дахь заалтад баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан тохиолдолд татан буугдах тухай заасны дагуу ТЗК нь татан буугдаж, холбогдох хөрөнгийг үүсгэн байгуулагч буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК руу шилжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

СЗХ
2023 .06. 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг гаргахдаа Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж буй зээлийн багцаас орох мөнгөн урсгал болон үйл ажиллагааны төсөвлөгдсөн зардалд үндэслэж дараах төсөөллийг боловсруулсан.

*Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлэл*

| | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 2,083 | 2,062 | 1,905 | 1,715 | 1,144 | 925 | 784 | 672 |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр | (925) | (925) | (925) | (925) | (463) | (463) | (463) | (463) |
| Цэвэр хүүгийн орлого | 1,158 | 1,137 | 980 | 790 | 681 | 463 | 321 | 210 |
| Эрсдэлийн сангийн зардал | - | - | - | - | - | - | - | - |
| Эрсдэлийн сангийн дараах ашиг | 1,158 | 1,137 | 980 | 790 | 681 | 463 | 321 | 210 |
| Үйл ажиллагааны зардал | (217) | (226) | (227) | (228) | (189) | (131) | (100) | (96) |
| **Татварын өмнөх ашиг** | 940 | 911 | 753 | 562 | 493 | 332 | 221 | 113 |
| **Татвар** | (94) | (91) | (75) | (56) | (49) | (33) | (22) | (11) |
| Татварын дараах цэвэр ашиг | 846 | 820 | 678 | 506 | 443 | 299 | 199 | 102 |

## ЗАРДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүгийн болон үндсэн төлбөрийг үнэт цаас эзэмшигчид олгохоос гадна татвар, төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал, гэрээнд өөрөөр заагаагүй бол ХБҮЦ гаргах, хадгалалттай холбоотой зардал, банктай холбоотой зардал, хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн аудитын болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөр, ажлын хөлс, ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий болон удирдлагын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб хуудастай холбоотой зардал, санхүүгийн программтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал, бичиг хэргийн зардал)-ыг төлнө.

*Хүснэгт 18. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал*

| № | Зардлын зориулалт | Дүн | Давтамж |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр | Удирдаж буй хөрөнгийн 0.75 хувь | Сар бүр |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр | Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь | Сар бүр |

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛЮС ТЗК ХХК
АТА9998 6999931
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183866
9021031196 СТС2420

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр | Жилд 8 сая төгрөг | Жил бүр |
| 4 | ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал | Нийт 24 сая төгрөг | Улирал бүр |
| 5 | Зээлийн программ хангамжийн төлбөр | 1.65 сая төгрөг | Сар бүр |
| 6 | Захиргааны зардал | Сард 1.5 сая төгрөг | Сар бүр |

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК-ийн хооронд байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгийг удирдах үүрэгтэй. Иймд тус үйлчилгээний төлбөр болгож удирдаж буй нийт хөрөнгийн 0.75 хувиар тооцож сар бүр Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани болох Юнайтед Айр Файнэнс ХХК-д төлөх юм.

### Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн хооронд байгуулсан "Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу Үйлчилгээ үзүүлэгч Бичил глобус финанс ББСБ нь зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж, дараа сарын 25-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байх үүрэгтэй. Энэхүү үйлчилгээний төлбөр нь цуглуулсан төлбөрийн 2.5 хувьтай тэнцэнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын 2.3.4-т заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн тайлагнана.

### Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр

Санхүүгийн зохицуулах хорооны "ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 11.4-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх шаардлагатай юм. Иймд Үнэт цаас гаргагч нь Ниямазон аудит ХХК-тай Аудитын үйлчилгээ үзүүлэх №23/6999131 дугаартай гэрээг 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан. Тус гэрээнд заасны аудитын үйлчилгээний төлбөр жилийн 8.0 (найм) сая төгрөг байх юм.

### Ерөнхий ба удирдлагын зардал

Үнэт цаас гаргагч компанийн ерөнхий ба үйл ажиллагааны зардал нь эхний жилд улиралд дунджаар 224.0 сая төгрөг байхаар төсөвлөсөн байна.

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

*Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл*

| | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орох мөнгөн урсгал | 2,017 | 1,882 | 1,603 | 1,273 | 881 | 540 | 314 | 132 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал | 5,623 | 6,106 | 6,410 | 6,480 | 5,611 | 3,640 | 2,635 | 2,355 |
| ХБҮЦ-ны үндсэн төлбөр | - | - | - | (10,000) | - | - | - | (10,000) |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр | (925) | (925) | (925) | (925) | (463) | (463) | (463) | (463) |
| Үйл ажиллагааны зардал | (217) | (226) | (227) | (228) | (189) | (131) | (100) | (96) |
| Татварын зардал төлсөн төлбөр | (94) | (91) | (75) | (56) | (49) | (33) | (22) | (11) |
| Үйл ажиллагааны мөнгөн урсгал | 6,404 | 6,746 | 6,785 | (3,456) | 5,792 | 3,554 | 2,365 | (8,083) |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 66 | 180 | 302 | 442 | 262 | 385 | 470 | 540 |
| Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт | (2,482) | (3,451) | (3,015) | (2,458) | (1,788) | (1,120) | (673) | (338) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал | (2,417) | (3,271) | (2,713) | (2,016) | (1,526) | (735) | (203) | 201 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1 | 3,987 | 7,463 | 11,535 | 6,063 | 10,329 | 13,148 | 15,310 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,987 | 7,463 | 11,535 | 6,063 | 10,329 | 13,148 | 15,310 | 7,429 |
| (Харилцах, хадгаламж+Зээл)/ ХБҮЦ | 129% | 135% | 140% | 188% | 190% | 190% | 191% | - |

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хугацаа нь 24 сарын хугацаатай үргэлжилж, үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрөө төлж дуусах тул багцын хөрөнгийн орж ирэх мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны хуваарьт төлбөр төлөлттэй цаг хугацааны хувьд уялдаатай байх ёстой. Зээлийн хөрөнгийн багцад багтаж буй зээлийн гэрээнүүдийн дундаж үргэлжлэх хугацааг зээлийн үлдэгдлээр жигнэж тооцвол 35.9 сар байгаа нь үнэт цаасны хугацаа болох 24 сараас урт хугацаатай боловч ТЗК-ны мөнгөн урсгалын төсөөллийг харгалзан дараах үндэслэлээр хөрөнгийн багц нь ХБҮЦ-ны үүргийг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Хөрөнгийн багц дахь зээлүүдийн эргэн төлөлт бүхэлдээ илүү төлөлтгүй, хугацаа хэтэрсэн зээлгүй байх тохиолдолд зээлийн багцын хүүгийн болон үндсэн төлбөрийн эхний 24 сарын нийлбэр дүн нь нийт ХБҮЦ-ны гүйцэтгэх үүргийн 90 хувийг гүйцэтгэхэд хүрэлцэнэ;
- Нийт багцын 90 хувь төлөгдсөн тохиолдолд ТЗК-иас хөрөнгийн багцыг буцаан худалдах нөхцөлийн дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид үлдэгдэл багцыг буцаан шилжүүлж ХБҮЦ-ны хэлцэл дуусгавар болох;
- Хөрөнгийн багц дахь зээлүүд нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бусад зээлийн хөрөнгөтэй адил шинж чанараар хугацаа хэтэрсэн зээл болон илүү төлөлт хийгдэх байдлаар эргэн төлөгдөх тохиолдолд ХБҮЦ арилжаалагдсанаас хойш 18 дахь сард хөрөнгийн багц бүхэлдээ төлөгдөж дуусна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

## 3.5. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

### ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ДАНС

ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын 3.2-т заасан буюу дараах үндэслэлээр Төлбөр цуглуулах данснаас гүйлгээ гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руу шилжүүлэх;
- Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
- Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
- ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал.

### ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНС

Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцын зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь сар бүрийн 25-ны өдрийн дотор өмнөх сарын зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг Төлбөр цуглуулах дансанд шилжүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.

## 3.6. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БУЦААН ХУДАЛДАХ НӨХЦӨЛ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагч нь буцаан худалдан авна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3-д заасны дагуу хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5-д заасны дагуу баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдах;

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛЮС ТЗК ХХК
АТА9998 6939131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5133855
9021031155 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-15
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

## 3.7. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтед Айр Файнэнс ХХК 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 23/611 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний дагуу Бичил 2 ХБҮЦ-ны хөрөнгийг итгэмжлэн удирдах үүрэг хүлээж байна. Тус Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани нь Омни актив ХБҮЦ 5.0 тэрбум төгрөг, Симпл ассет ХБҮЦ 50.0 тэрбум төгрөг, Бэрс ХБҮЦ 10.0 тэрбум төгрөг, Нөмөр кредит ассет ХБҮЦ 10.0 тэрбум төгрөг, ЛэндМН актив 4.85 тэрбум төгрөг, Бичил глобус ХБҮЦ 10.0 тэрбум төгрөг, Бэрс 2 ХБҮЦ 9.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус итгэмжлэн удирдаж буй туршлагатай, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөлтэй компани юм.

*Хүснэгт 20. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл*

| | |
|---|---|
| Х.Маргад-Эрдэнэ<br>*Гүйцэтгэх захирал* | Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ нь Монгол улсын Их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Х.Маргад-Эрдэнэ нь багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 14 жил ажилласан арвин туршлагатай юм. МҮЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 05 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан. |
| Ж.Онон<br>*Партнер* | Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн Партнер Ж.Онон нь Лондонгийн Эдийн засгийн Их сургуулийг банк, санхүүгийн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн үүсгэн байгуулагч ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал, Олон Улсын санхүүжилтээр 14 дэх жилдээ ажиллаж буй арвин туршлагатай мэргэжилтэн юм. МҮЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан. |
| Б.Буяннэмэх<br>*Менежер* | Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн Менежер албан тушаалтай Б.Буяннэмэх нь Монгол улсын Их сургуулийг Эдийн засаг мэргэжлээр бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, багцын удирдлага, зээлийн шинжилгээ, үнэт цаасны чиглэлээр 10 дахь жилдээ ажиллаж байна. МҮЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан. |

Доорх ХБҮЦ-нуудын үндсэн төлбөр төлөлтийг Омни Актив ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ны хувьд 50.0 хувийн биелэлттэй амжилттай төлөөд байна. Харин бусад ХБҮЦ-ны үндсэн төлбөр төлөх хуваарьт хугацаа хараахан эхлээгүй байгаа юм. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь өөрийн итгэмжлэн удирдаж буй ХБҮЦ-нуудын хүүгийн төлөлтийг амжилттай гүйцэтгэсэн бөгөөд Омни Актив ТЗК болон Симпл Ассет ТЗК тус бүрийн нийт хүүгийн төлбөрийн 50 орчим хувийг хөрөнгө оруулагч нарт амжилттай төлжээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн вэбэд суурилсан нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн дэлгэрэнгүй нөхцөлийн талаар Хавсралт 13-аас үзнэ үү.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ 2
ЭЙ БИ ЭС
ТЗК ХХК
АТА9998
9923050064

*График 26. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөлтийн гүйцэтгэл*




## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

Энэхүү гэрээг нэг талаас Үнэт цаас гаргагч “Бичил Эй Би Эс плас ТЗК” ХХК болон Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Юнайтед Айр Файнэнс” ХХК нар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 23/611 дугаартай "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-г байгуулсан. Тус гэрээний зорилго нь ТЗК Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан ХБҮЦ-ыг гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагч буюу Юнайтед Айр файнэнс ХХК-иас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлжээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана. Мөн багцын хөрөнгөд багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг өөрчлөлтүүдийг оруулна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасны дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх буюу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна. Мөн Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно.

ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх.

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих нөхцөл

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, үүргээ биелүүлэх

шаардлага хүргүүлсэн болович гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой эсхүл үүргээ биелүүлэх чадваргүй болсон, дампуурах нөхцөл байдал бий болсон, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцална;

- Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журамд заасан үндэслэлээр солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан ХБҮЦ-ны болон хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй;
- Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шинээр томилогдсон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажил хүлээлцэх актын дагуу ТЗК-тай холбоотой эзэмшиж байсан бүхий л мэдээлэл, баримт бичиг, данс тооцоо, бэлэн мөнгө, тайланг баримтаар болон цахимаар ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно.

## Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээг цуцлах нөхцөл

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан 23/611 дугаартай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг гэрээнд заасны гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсны дагуу гүйцэтгээгүйн улмаас ХБҮЦ эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бус хохирол учирсан;
- Хөрөнгийн багцыг буруу удирдсан буюу хөрөнгийн багцад зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ны төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон;
- ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.

ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# ДӨРӨВ. Үнэт цаасны тухай

БИЧИЛ 2.0

ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 4.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ

Бичил 2 ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Үндсэн андеррайтераар "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, хөндлөнгийн хараат бус хуулийн дүгнэлт гаргагчаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, зээлийн шинжилгээ гаргагчаар "Онч аудит" ХХК, хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК нар ажилласан. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглалыг доорх байдлаар дүрслэв.

*Схем 6. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал*




### ТЗК байгуулах

ТЗК нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг, дүрэмд заасан үйл ажиллагааг эрхэлдэг, СЗХ-ны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дүгээр хэсэгт заасны дагуу Бичил глобус финанс ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулсан.

## Үнэт цаасжуулах зээлийн (хөрөнгийн) багцыг сонгох

Хөрөнгийн багцад ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгүүд багтсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нараар давхар баталгаажуулан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан хөрөнгийг ТЗК руу шилжүүлнэ.

## Багцад багтсан хөрөнгүүд шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд тэдгээр шалгуурын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүд шаардлага хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, зээлийн шинжилгээг Онч Аудит ХХК боловсруулсан.

## Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК руу хөрөнгө шилжүүлэх

2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/607 дугаартай "Хөрөнгө худалдах, худалдан авах" урьдчилсан гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-д шилжүүлэхээр харилцан тохиролцсон болно. Тус гэрээ нь нийт 15 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна.

## Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Монголын хөрөнгийн биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, СЗХ, МХБ-д тус тус хүргүүлнэ. Эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаална.

## Анхдагч зах зээлийн захиалгыг зохион байгуулах

СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл олгогдсоны дараа Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулж, МХБ-ээр дамжуулан анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авч, гүйцэтгэнэ.

## Хөрөнгө оруулагчид Бичил 2 ХБҮЦ худалдаж авах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нээгдэх хугацаанд Бичил 2 ХБҮЦ эзэмших хүсэлтэй хөрөнгө оруулагчид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаасны дансандаа мөнгөө байршуулж, захиалгыг хийж гүйцэтгэнэ. Захиалга биелснээр үнэт цаас хөрөнгө оруулагчийн эзэмшилд шилжиж, үнэт

цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүгийн болон үндсэн төлбөрийг хүлээж авна.

### Хөрөнгийг удирдах

Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгөтэй холбоотой бүртгэх, тайлагнах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үнэт цаасны хугацааны турш үзүүлнэ.

### ТЗК татан буулгах

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн, баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагч/худалдагч буцаан худалдан авсан тохиолдолд эсвэл баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан тохиолдолд ТЗК-г татан буулгана.

## 4.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний шинж чанарын хувьд хадгаламж, Засгийн газрын үнэт цаас, компанийн нээлттэй болон Биржийн бус зах зээлийн хаалттай бондтой харьцуулах боломжтой юм. Бичил 2 ХБҮЦ-ны хүүг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, Монголбанкны макро эдийн засгийн төсөөлөл, банкнуудын хадгаламжийн өгөөж, сүүлд олон нийтэд нээлттэй гаргасан ижил төстэй үнэт цаасны өгөөжтэй харьцуулах байдлаар гаргасан.

Бичил 2 ХБҮЦ-ны хөрөнгө оруулалтын өгөөжийг зах зээл дээр хөрөнгө оруулагчдын хүлээлт, хөрөнгө оруулалтын боломжийг харгалзан үзэж 1.) Макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, инфляцын түвшнээс өндөр буюу мөнгөний бодит үнэ цэнийг алдагдуулахгүй байх, 2.) Банкны хугацаатай хадгаламжийн хүүгээс өндөр, 3.) Тогтмол өгөөжтэй үнэт цаасны хүүгийн түвшинтэй харьцуулахад өрсөлдөхүйц байхаар тогтоосон.

### ИНФЛЯЦЫН ТҮВШИНТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд инфляцын түвшин 13.2 хувь буюу өмнөх сараас 1.3 пунктээр буурсан. Сүүлийн байдлаар 2023 оны 3 дугаар сарын инфляцын түвшин 12.2 хувьд хүрч саарч байгаа нь хөрөнгө оруулагч нарт тогтмол өгөөжтэй үнэт цаасны өгөөжийн хэмжээ буурах хүлээлт бий болгож байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15

СЗХ он сар өдөр № 01

График 27. Инфляц ба бодлогын хүү




Эх сурвалж: ҮСХ

Бичил 2 ХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт 18.5 хувийн хүүг санал болгож байгаа нь инфляцын түвшнээс 6.3 хувийн нэмэгдэл өгөөжтэй, бодлогын хүүтэй харьцуулахад 5.5 нэгжээр өндөр өгөөжтэй тогтсон байна.

## БАНКНЫ ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хугацаатай хадгаламжийн зарласан хүү дунджаар 12.1 хувь байна. Банкны системийн хэмжээнд шинээр татсан төгрөгийн, хугацаатай хадгаламжийн дундаж хүү 11.1 хувь байгаа бол валютаар шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүү 3.4 хувь байна.

График 28. Системийн нөлөө бүхий банкнуудын төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү




Эх сурвалж: Банкнуудын албан ёсны вэб хуудас

## НЭЭЛТТЭЙ БОНД БА ХБҮЦ-НЫ ХҮҮ

Монголын хөрөнгийн биржээр 2022 онд олон нийтэд нээлттэй хүрээнд 6 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 1 бонд амжилттай арилжаалагдсан байна. Олон нийтэд нээлттэй санал болгосон ХБҮЦ-ны дундаж хүү 16.4 хувь байгаа бөгөөд хамгийн сүүлд гарсан Бичил глобус ХБҮЦ 17.5 хувь, ЛэндМН актив ХБҮЦ 17.0 хувь, Бэрс 2 ХБҮЦ 19.2 хувь байсан.

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ТЗК ХХК ATA9998 9023050164

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 CTC2420

*График 29. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны жилийн өгөөж*




*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*

Олон нийтэд нээлттэй санал болгож буй Бичил 2 ХБҮЦ нь 2022 оны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дундаж хүүгийн түвшин 16.4 хувиас өндөр буюу 18.5 хувийн өгөөжийг хөрөнгө оруулагч нарт санал болгож байна.

## 4.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Бичил 2 ХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт үндсэн төлбөрийг ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сарын дараа, үлдсэн үндсэн төлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 24 сарын дараа буюу хугацааны эцэст, хүүг улирал тутамд олгохоор шийдвэрлэсэн нь үнэт цаасны хөрвөх чадвар, дахин хөрөнгө оруулалт (reinvestment)-ын боломжийг нэмэгдүүлж байна.

*Хүснэгт 21. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр*

| Улирал | Анхны хөрөнгө оруулалт | Хүүгийн орлого (татварын дараах) | Үндсэн төлбөр хүлээн авах | Хүлээн авах нийт төлбөр |
|---|---|---|---|---|
| 0 | (1,000,000.0) | - | - | - |
| 1 | - | 43,937.5 | - | 42,750.0 |
| 2 | - | 43,937.5 | - | 42,750.0 |
| 3 | - | 43,937.5 | - | 42,750.0 |
| 4 | - | 43,937.5 | 500,000.0 | 543,937.5 |
| 5 | - | 21,968.7 | - | 42,750.0 |
| 6 | - | 21,968.7 | - | 42,750.0 |
| 7 | - | 21,968.7 | - | 42,750.0 |
| 8 | - | 21,968.7 | 500,000.0 | 521,968.7 |
| Нийт | (1,000,000.0) | 263,625.0 | 1,000,000.0 | 1,263,625.0 |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь 1,000,000.0 (нэг сая) төгрөгөөр 10 ширхэг Бичил 2 ХБҮЦ-д хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд хугацааны эцэст буюу 24 сарын дараа татварын дараах байдлаар 26.3 хувийн өгөөж буюу мөнгөн дүнгээр 263,625.0 төгрөгийн өгөөж хүртэхээр байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
СЗХ
2023 06 02
БҮРТГЭВ
№ 01

## 4.4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

### ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ, АРГАЧЛАЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тооцож олгоно. Үүнд, анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийг дараах аргачлалын дагуу хөрөнгө оруулагчид олгоно.

*Хүснэгт 22. Төлбөрийн хуваарь ба төлбөр тооцох аргачлал*

| | |
|---|---|
| **Хүү тооцож эхлэх хугацаа** | Анхдагч зах зээлийн захиалга явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш |
| **Хүү төлөх давтамж** | Улирал тутам |
| **Хүүгийн төлбөр тооцох аргачлал (татварын өмнө)** | Эхний жилд, улирал тутам: $\frac{(\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ}) * 18.5\%}{365} \times \text{Хүү тооцох хоног}$ <br> Хоёр дахь жилд, улирал тутам: $\frac{((\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ})/2) * 18.5\%}{365} \times \text{Хүү тооцох хоног}$ <br> Тайлбар: *Эхний жилд ХБҮЦ-ыг худалдан авсан анхны хөрөнгө оруулалтын дүнгээс хүү тооцогдоно. Эхний жилийн төгсгөлд нийт дүнгийн 50 хувь төлөгдөх учраас хоёр дахь жилийн хүү бодогдох үндсэн дүн нь анхны хөрөнгө оруулалтын 50 хувиас тооцогдох юм. Жилийн хүүг тооцох суурь хоног нь 365 хоног байна.* |
| **Хүүгийн төлбөр тооцох аргачлал (татварын дараа)** | Эхний жилд, улирал тутам: $\frac{(\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ}) * 17.575\%}{365} \times \text{Хүү тооцох хоног}$ <br> Хоёр дахь жилд, улирал тутам: $\frac{((\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ})/2) * 17.575\%}{365} \times \text{Хүү тооцох хоног}$ |
| **Үндсэн төлбөр төлөх давтамж** | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа мөн сарын мөн өдөр хөрөнгө оруулагчийн анх хөрөнгө оруулсан нийт үнийн дүнгийн 50 хувийг төлнө. Үлдэгдэл төлбөрийг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 сарын дараа мөн сарын мөн өдөр шилжүүлнэ. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ) |
| **Үндсэн төлбөр тооцох аргачлал** | Эхний удаагийн төлөлтөд үндсэн төлбөрийн нэрлэсэн дүнгийн 50 хувь, хугацааны эцэст анх оруулсан хөрөнгө оруулалтын үлдсэн 50 хувийг тус тус төлнө. |
| **Нийт төлөгдөх дүн** | $\text{Үндсэн төлбөр} + \frac{\text{Хүү тооцох дүн} * 18.5\%}{365} * \text{Хүү тооцох хоног} * 8 \text{ удаа}$ |

*Эх сурвалж: Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам*

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПАРТ ТЗК ХХК
АТА9998 9999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183865
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -03- 15

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

## БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина. Хэрэв Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ.

- Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Тус үүргийг ТЗК-тай байгуулсан “Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.
- “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, Хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй гаргасан) зөрчлийн улмаас Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.
- Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг Үйлчилгээ үзүүлэгчээс шаардах, хяналт тавих эрхтэй. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу худалдан авах, 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгосон нийт 24,237,058,803 (хорин дөрвөн тэрбум хоёр зуун гучин долоон сая тавин найман мянга найман зуун гурав) төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн Бичил 2 ХБҮЦ-ны тухайд эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПИ ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183655
5021031195 СТС2420

## СУЛ ЧӨЛӨӨТЭЙ ЭХ ҮҮСВЭРИЙН УДИРДЛАГА

Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 дугаарын тогтоолоор батлагдсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ын дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр ТЗК-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрсдэл, өгөөж болон ХБҮЦ-ны холбогдох үүргийг гүйцэтгэхэд аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л бололцоог харгалзан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулна.

*Схем 7. Сул чөлөөтэй хөрөнгийг байршуулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслүүд*




ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарьт өдрөөс ажлын 2 (хоёр)-оос доошгүй өдрийн өмнө дууссан байхаар тохируулсан байна.

## ТӨЛБӨРИЙН ДАРААЛАЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагчийн төлбөр төлөх дараалал нь дараах байдалтай байна. Баталгаат үнэт цаас гаргах болон түүнийг бүртгүүлэхтэй холбоотой зардлыг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны татан төвлөрүүлэх хөрөнгөөс төлөхгүй.

*Схем 8. Төлбөрийн дараалал*

| | |
|---|---|
| 1. | **ТЗК-ийн татварын төлбөр** |
| 2. | **ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар** |
| 3. | **Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой зардал** |
| 4. | **Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал** |
| 5. | **Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр** |
| 6. | **ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин** |
| 7. | **ХБҮЦ-ны хүүгийн төлбөр** |
| 8. | **ХБҮЦ-ны үндсэн төлбөр** |
| 9. | **Бусад зардал** |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -03- 15



2023 .06. 02
БҮРТГЭВ
№ 01

## ҮНЭТ ЦААСЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ОЛГОХООС ӨМНӨ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨР, ЗАРДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнөх дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрийг нэхэмжлэхгүй. Үүнд: Андеррайтерийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийн багцын шинжилгээний аудитын тайлан болон хуулийн дүгнэлт гаргах үйлчилгээний төлбөр, хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр, маркетингийн зардал, Хороо болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой хураамж, ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой маркетингийн зардлууд багтана.

## ТӨЛБӨРИЙН ГРАФИК

*Хүснэгт 23. Төлбөрийн график, сая төгрөгөөр*

| Хугацаа | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үнэт цаасны үлдэгдэл | 20,000 | 20,000 | 20,000 | 20,000 | 20,000 | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 |
| Үндсэн төлбөр төлөлт | - | - | - | - | (10,000 ) | - | - | - | (10,000) |
| Хүүгийн төлбөр төлөлт | - | (925) | (925) | (925) | (925) | (462.5) | (462.5) | (462.5) | (462.5) |
| Нийт төлбөр төлөлт | - | (925) | (925) | (925) | (10,925) | (462.5) | (462.5) | (462.5) | (10,462.5) |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 24,237,058,803.4 төгрөгийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцаас орж ирэх зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдэнэ. Тус зээлийн багцын үнийн дүн нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нийт татан төвлөрүүлэх үнийн дүнгээс 21.1 хувиар илүү байна.

## 4.5. ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ

Бичил 2 ХБҮЦ-ны хөрөнгийн багцын хувьд Зээлийн шинжилгээ гаргагчийн тайланд дурдсанаар 2023 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгосон 1,293 зээлдэгчийн 23,058,772,329.3 төгрөгийн дүн бүхий зээлийн багцаас 168 зээлийн гэрээг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч зээлийн шинжилгээг гүйцэтгэсэн. (Зээлийн шинжилгээ болон Хуулийн дүгнэлтийн дэлгэрэнгүй тайланг Хавсралтаас үзнэ үү.)

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед тус хөрөнгийн багц дахь зарим зээлүүд төлөгдөж дууссан, эргэн төлөлтүүд хийгдсэн учраас хөрөнгийн багцыг нэмэгдүүлж 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 24,237,058,803.4 төгрөгийн үлдэгдэл дүн бүхий 1,468 зээлийн багц болж өөрчлөгдсөн байна. (Энэхүү хөрөнгийн багц дахь зээлийн жагсаалтыг Хавсралтаас харна уу.)

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛЮС ТЗК ХХК
АТА9998 9023050164
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855 9021031195 СТС2420

*Хүснэгт 24. Хөрөнгийн багцын үзүүлэлтүүдийн хураангуй*

| Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| Нийт зээлийн үлдэгдэл, төгрөг | 24,237,058,803.4 |
| Нийт анх олгосон дүн, төгрөг | 28,682,377,000.0 |
| Зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн, төгрөг | 42,719,790,000.0 |
| Зээлийн гэрээний тоо | 1,468 |
| Зээлдэгчийн тоо | 1,468 |
| Зээлийн дундаж үлдэгдэл, мянган төгрөг | 16,510,258.0 |
| Зээлийн төрөл | Автомашины фидуци бүхий зээл |
| **Зээлийн төвлөрөл** | |
| Хамгийн их дүнтэй 1 зээлийн нийт багцад эзлэх хувь | 0.40% |
| Хамгийн их дүнтэй 10 зээлийн нийт багцад эзлэх хувь | 2.49% |
| Хамгийн их дүнтэй 50 зээлийн нийт багцад эзлэх хувь | 8.03% |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| Жигнэсэн дундаж хүү (сарын) | 2.95% |
| Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа (сар) | 42.3 |
| Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа (сар) | 35.99 |
| Багцын зээлийн чанар | 100% хэвийн зээл |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл*

## ХӨРӨНГИЙН БАГЦЫН ШАЛГУУР

Бичил 2 ХБҮЦ-ны зээлийн багц нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан дараах хөрөнгийн багц, түүнд тавих шаардлагыг бүрэн хангасан байна.

*Хүснэгт 25. Хуулийн шаардлагад нийцэж буй байдал*

| Хуулийн хэсэг, заалт | Хуулийн заалт | Хангагдсан эсэх |
|---|---|---|
| 9.1 дэх хэсэг | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ. | **Тийм.** (Үнэт цаас гаргагчийн 20.0 тэрбум төгрөгийн дүнтэй үнэт цаас нь 24.2 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багцаар баталгаажсан.) |
| 9.2 дахь хэсэг | Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед Үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна. | **Тийм.** (Зээлийн багц нь гэрээний үндсэн дээр Бичил Эй Би Эс плас руу шилжих боломжтой. (Дэлгэрэнгүй хуулийн дүгнэлтээс үзнэ үү.) |
| 9.3 дахь хэсэг | Хөрөнгийн багцад дараах хөрөнгийг оруулахыг хориглоно:<br>• Дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа;<br>• Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл;<br>• Хугацаа хэтэрсэн хөрөнгө. | **Тийм.** (Зээлийн багц нь 100.0 хувь хэвийн ангилалтай автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөс бүрдсэн.) |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Бичил 2 ХБҮЦ-ны зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/07 тогтоолоор

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -03- 15

СЗХ
2023 .06. 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

баталсан. Зээлийн багцын санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийн дагуу нийт зээлийн багцаас сонгон шалгаруулж, зээлийн шинжилгээ гаргагч Онч Аудит ХХК болон хуулийн дүгнэлт гаргагч Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН-ээс хараат бус дүгнэлт гаргасан.

*Хүснэгт 26. Зээлдэгч ба зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур*

| Зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур | Зээлийн хөрөнгийн санхүүгийн шалгуур |
|---|---|
| • Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;<br>• Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;<br>• Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, хүүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;<br>• Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;<br>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;<br>• Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх; | • Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;<br>• Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;<br>• Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;<br>• Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх);<br>• Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;<br>• Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх;<br>✓ Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 55 хувиас илүүгүй байх (ӨОХ=Зээлийн сарын төлбөр/Өрхийн сарын орлого (татварын өмнөх));<br>✓ Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75 хувиас хэтрэхгүй байх (ЗҮХ=(Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ));<br>✓ Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх;<br>✓ Үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол сүүлийн дараалсан 6 сарын орлоготой. |

## ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ

Онч Аудит ХХК нь шалгуурын дагуу сонгогдсон зээлийн багцад багтах зээлүүдээс түүвэрлэж, сонгогдсон зээлүүд нь санхүүгийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнд санамсаргүй түүврийн аргаар

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХХК
5183856 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-03-15

СЗХ 2023.06.02 БҮРТГЭВ № 01

сонгон авсан 168 зээлийн зээлдэгчийн хувийн хэрэг, зээлийн гэрээнд тусгагдсан сар бүрийн эргэн төлөлтийн хуваарь, зээлийн дансны хуулга, барьцаа хөрөнгийн даатгалын гэрээ, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21/04А/68 тоот тушаалаар баталсан "Зээлийн үйл ажиллагааны журам" болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тусгайлсан шийдвэрийн дагуу олгосон зээл мөн эсэх зэрэг мэдээллийг шалгасны үндсэн дээр дараах үр дүнг нэгтгэжээ.

*Хүснэгт 27. Хөрөнгийн зээлийн багцын шинжилгээний хураангуй үр дүн*

| Хөрөнгийн зээлийн багцын шалгуур | Үр дүн |
|---|---|
| Хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байгаа эсэх | • Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцсэн ба хүчин төгөлдөр, гарын үсэгтэй зээлийн гэрээтэй байсан. |
| Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон байх | • Зээлүүд нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх хуваарьтай байсан. |
| Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг тусгасан байх | • Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүр төлөх дүнг тусгасан, зээл нь зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар тусгасан байсан. |
| Үндсэн үүрэг гүйцэтгэгчийн даатгал хүчинтэй эсэхийг тодорхойлох | • Үндсэн үүрэг гүйцэтгэгчид нь автомашин худалдан авалтын зээлийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал, автомашины фидуци бүхий зээлийн хувьд жолоочийн албан журмын даатгал хийлгэсэн бөгөөд шинжилгээ хийх өдрийн байдлаар даатгалын гэрээ нь хүчин төгөлдөр байсан. |
| Зээл нь тасалбар болгосон өдрийн байдлаар хэвийн төлөлттэй байгаа эсэх | • Зээл нь шинжилгээ хийх өдрийн байдлаар бүх зээлдэгчдийн хуваарьт төлбөрийн зөрчилгүй байсан. |
| Бичил глобус финанс ББСБ-ын "Зээлийн үйл ажиллагааны журам"-д нийцсэн эсэх | • Тасалбар болгосон өдрийн байдлаар 21 зээлдэгчдээс бусад зээлдэгчдийн өр орлогын харьцаа (ӨОХ) 55%-аас хэтрээгүй байна. Цаашид ӨОХ нь хэтэрсэн зээлүүдийг ТЗК-д шилжүүлэх хөрөнгийн багцаас хасах, оронд нь шаардлага хангасан зээлүүдээр солихыг зөвлөсөн байна;<br>• Нэг зээлдэгчийн зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-аас хэтэрсэн. (Дээрх 2 зөвлөмжийн дагуу эдгээр зээлүүдийг зээлийн багцаас хасаж, оронд нь шалгуур хангасан зээлүүдийг сонгож багцад оруулсан.)<br>• Зээлийн барьцаа хөрөнгүүд нь "барьцаа хөрөнгийн үйлдвэрлэсэн он нь 2002 оноос хойш, импортолсон он нь 2016 оноос хойш эсвэл гаалийн бичигтэй, Япон болон Солонгос улсад үйлдвэрлэгдсэн 2.5 тонноос ихгүй даацтай, суудлын болон ачааны тэрэг байх" гэсэн барьцаа хөрөнгийн шалгуурыг хангасан;<br>• Зээл олгосон өдрийн байдлаар үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажилласан ба хувиараа хөдөлмөр эрхэлдэг үүрэг гүйцэтгэгч нь сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогын мэдээллээ зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн. |

## ХӨНДЛӨНГИЙН ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН нь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн данснуудаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн данснуудад хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, гүйцэтгэсэн. Тус шинжилгээний үр дүнгээр санамсаргүй сонгогдсон 53 зээлийн данснуудаас

БИЧИЛ ... ТЗК ХХК ATA9998 ... 9023056

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15

СЗХ он сар өдөр 2023.06.02

зээлийн хөрөнгө болон зээлдэгчид тавигдах хуулийн шаардлага хангаагүй эрсдэлтэй гэж үзсэн зээлийн данс илрээгүй гэж дүгнэсэн байна.

## ЗЭЭЛИЙН БАГЦЫН ТӨВЛӨРӨЛ

Бичил 2 ХБҮЦ-ны зээлийн багцад хамгийн өндөр дүнтэй нэг зээлийн багцын нийт зээлийн багцад эзлэх хувь 0.4 хувь, хамгийн их дүнтэй 10 зээл 2.49 хувь, хамгийн их дүнтэй 50 зээл 8.03 хувийг тус тус эзэлж байгаа нь хөрөнгийн буюу зээлийн багцын тархаан байршуулалт сайн, төвлөрлийн эрсдэл бага байгааг харуулж байна.

*Хүснэгт 28. Зээлийн багцын дүн, анх зээл олгосон ангиллаар*

| Анх олгосон зээлийн дүн, сая төгрөг | Зээлийн тоо | | Анх олгосон зээлийн дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 10.0-25.0 | 1,249 | 85.1% | 21,721.8 | 75.7% |
| 25.0-50.0 | 209 | 14.2% | 6,278.6 | 21.9% |
| 50.0-75.0 | 7 | 0.5% | 426.4 | 1.5% |
| 75.0-100.0 | 3 | 0.2% | 255.5 | 0.9% |
| Нийт | 1,468 | 100.0% | 28,682.4 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл*

*График 30. Хөрөнгийн багц дахь зээлийн анх олгосон хэмжээ (сая.төг) ба эзлэх хувийн тархалт*




Зээлийн багцад шалгуурын дагуу зөвхөн хэвийн төлөлттэй, автомашины фидуци бүхий зээлээс бүрдсэн. Тухайлбал, хамгийн бага дүнтэй нь анх 10.0 сая төгрөгөөр олгогдсон зээл байна. Нийт багцад багтсан 1,468 зээлийн гэрээний 1,249 буюу 85.1 хувь нь 10.0-25.0 сая төгрөгийн үнийн дүнтэй, 14.2 хувь нь 25.0-50.0 сая төгрөгийн үнийн дүнтэй, 7 нь 50.0-75.0 сая төгрөг, 3 нь 75.0-100.0 сая төгрөгөөр анх олгогдсон зээлийн гэрээнүүд байна.

*Хүснэгт 29. Зээлийн багцын дүн, зээлийн үлдэгдлээр*

| Зээлийн үлдэгдэл, сая төгрөг | Зээлийн тоо | | Зээлийн үлдэгдэл дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 10.0 хүртэл | 85 | 5.8% | 420.3 | 1.7% |
| 10.0-20.0 | 1,074 | 73.2% | 15,963.5 | 65.9% |
| 20.0-30.0 | 263 | 17.9% | 6,025.0 | 24.9% |
| 30.0-40.0 | 37 | 2.5% | 1,264.2 | 5.2% |
| 40.0-50.0 | 2 | 0.1% | 83.8 | 0.3% |
| 50.0-аас дээш | 7 | 0.5% | 480.3 | 2.0% |
| Нийт | 1,468 | 100.0% | 24,237.1 | 100.0% |

УЛААНБААТАР ХОТ ТЭЗ ХХК

УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

*График 31. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдлийн тархалт, сая төгрөг*




Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдлийн тархалтын мэдээлэлд тусгаснаар 10.0-20.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй 1,074 зээлийн гэрээ байгаа бол 20.0-30.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй 263, 30.0-40.0 сая төгрөгийн 37, 40.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 9 зээлийн гэрээ тус тус багтсан байна. Хамгийн өндөр дүнтэй буюу 50.0 сая төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэл дүнтэй нийт 480.3 сая төгрөгийн 7 зээл байгаа бөгөөд нийт зээлийн багцын 2.0 хувийг эзэлж байна.

## ЗЭЭЛИЙН БАГЦЫН ХУГАЦАА

Хөрөнгийн багцад багтаж буй зээлийн гэрээний шалгуурын дагуу зээлийн багцад 12-48 сар хүртэлх хугацаатай автомашины фидуци бүхий зээлүүд багтсан. Нийт зээлийн гэрээний анх олгосон үнийн дүнгийн 99.0 хувь нь 36-48 сарын хугацаатай олгогдож байсан зээлүүд юм.

*Хүснэгт 30. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангиллаар*

| Зээлийн анхны хугацаа (сар) | Зээлийн тоо | | Анх зээлийг олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 12-24 | - | 0.0% | - | 0.0% |
| 30-36 | 14 | 1.0% | 280 | 1.0% |
| 36-42 | 721 | 49.1% | 13,175 | 45.9% |
| 42-48 | 733 | 49.9% | 15,227 | 53.1% |
| Нийт | 1,468 | 100.0% | 28,682 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл*

*График 32. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангиллаар*




УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПАРК ТЗК ХХК
АТА9998 9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хугацаа нь 24 сарын хугацаатай үргэлжилж, үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрөө төлж дуусах тул багцын хөрөнгийн орж ирэх мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны хуваарьт төлбөр төлөлттэй цаг хугацааны хувьд уялдаатай байх ёстой. Зээлийн хөрөнгийн багцад багтаж буй зээлийн гэрээнүүдийн дундаж үргэлжлэх хугацааг зээлийн үлдэгдлээр жигнэж тооцвол 35.9 сар байгаа нь үнэт цаасны хугацаа болох 24 сараас урт хугацаатай боловч үнэт цаасны хугацааны туршид үндсэн болон хүүгийн төлбөр төлөх мөнгөн урсгалыг бий болгох боломжтойг харуулж байна.

*Хүснэгт 31. Хөрөнгийн зээлийн багц, үлдэгдэл хугацааны ангиллаар*

| Зээлийн үлдэгдэл хугацаа (сар) | Зээлийн тоо | | Зээлийн үлдэгдэл дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 12-18 | - | 0.0% | - | 0.0% |
| 18-24 | 30 | 2.0% | 455.6 | 1.9% |
| 24-30 | 334 | 22.8% | 4,659.3 | 19.2% |
| 30-36 | 377 | 25.7% | 6,089.1 | 25.1% |
| 36-42 | 326 | 22.2% | 5,641.2 | 23.3% |
| 42-48 | 401 | 27.3% | 7,391.8 | 30.5% |
| Нийт | 1,468 | 100.0% | 24,237.1 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл*

*График 33. Хөрөнгийн зээлийн багцын үлдэгдлийн тархалт, (сая төгрөг ба хувь)*




## ЗЭЭЛИЙН ОЛГОГДСОН ОГНОО

Зээлийн багцын 82.2 хувь нь 2022 онд олгогдсон зээл, үлдсэн 17.8 хувь нь 2021 оны дөрөвдүгээр улирал болон 2023 оны нэгдүгээр улиралд олгогдсон зээл байна. Нийт зээлийн багц дахь зээлийн гэрээнүүдийн 47.0 хувь нь сүүлийн 6 сард олгогдсон зээлүүд буюу шинэ зээлүүд эзэлж байна.

*Хүснэгт 32. Хөрөнгийн багц дахь зээлийг анх олгосон огноо, улирлаар*

| Анх зээл олгосон огноо | Зээлийн тоо | | Зээлийн дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 2021 | | | | |
| IV улирал | 1 | 0.1% | 25.7 | 0.1% |
| 2022 | | | | |
| I улирал | 36 | 2.5% | 777.4 | 2.7% |
| II улирал | 367 | 25.0% | 7,438.9 | 25.9% |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ

| | | | | |
|---|---|---|---|---|
| III улирал | 291 | 19.8% | 5,674.7 | 19.8% |
| IV улирал | 471 | 32.1% | 8,821.7 | 30.8% |
| 2023 | | | | |
| I улирал | 302 | 20.6% | 5,944.0 | 20.7% |
| Нийт | 1,468 | 100.0% | 28,682.4 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл*

*График 34. Хөрөнгийн багц дахь анх зээл олгосон огнооны тархалтаар*




Хөрөнгийн багц дахь зээлүүдийг анх олгосон хугацааны ангиллаар авч үзвэл 2022 онд олгосон зээлүүд нь хөрөнгийн багцын 79.2 хувийг бүрдүүлж байна. Харин 2023 оны эхний улиралд олгосон зээлийн дүн хөрөнгийн багцын 20.7 хувийг эзэлж байна.

Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацааны тархалтын хувьд зээлийн хугацаа нь дуусах зээлүүд 2025 онд 39.8 хувь, 2026 онд 49.8 хувь, 2027 оны эхний улиралд хугацаа нь дуусах зээлүүд 10.3 хувийг тус бүр харгалзан эзэлж байна.

*Хүснэгт 33.. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацаа, улирлаар*

| Зээл төлөгдөж дуусах хугацаа | Зээлийн тоо | | Зээлийн дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 2025 | | | | |
| I улирал | 30 | 2.0% | 455.6 | 1.9% |
| II улирал | 175 | 11.9% | 2,444.3 | 10.1% |
| III улирал | 159 | 10.8% | 2,215.1 | 9.1% |
| IV улирал | 221 | 15.1% | 3,416.9 | 14.1% |
| 2026 | | | | |
| I улирал | 156 | 10.6% | 2,672.2 | 11.0% |
| II улирал | 193 | 13.1% | 3,268.8 | 13.5% |
| III улирал | 133 | 9.1% | 2,372.4 | 9.8% |
| IV улирал | 250 | 17.0% | 4,430.3 | 18.3% |
| 2027 | | | | |
| I улирал | 151 | 10.3% | 2,961.5 | 12.2% |
| Нийт | 1,468 | 100.0% | 24,237.1 | 100.0% |

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПИ ТЗК ХХК
АТА9998 6599131
9923050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

*График 35. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацааны тархалт*




## ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИН

Зээлийн багцын шалгуурын дагуу сонгогдсон зээлийн хүүгийн түвшин хамгийн багадаа сарын 1.5 хувь байхаар тогтоогдсон. Багцад багтсан зээлийн хамгийн өндөр зээлийн сарын хүү 3.7 хувь, сарын жигнэсэн дундаж хүү 2.95 хувь байна. Зээлийн багцын жигнэсэн дундаж хүү 2022 оны салбарын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.1 хувиас 0.15 пунктээр бага буюу 2.95 хувь байна.

*Хүснэгт 34. Зээлийн багц, хүүгийн түвшнээр*

| Зээлийн хүү | Зээлийн тоо | | Зээлийн дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 1.5-2.0 хувь | 1 | 0.1% | 30.0 | 0.1% |
| 2.0-2.5 хувь | 12 | 0.8% | 222.5 | 0.8% |
| 2.5-3.0 хувь | 1,215 | 82.8% | 24,551.7 | 85.6% |
| 3.0-3.5 хувь | 66 | 4.5% | 1,128.5 | 3.9% |
| 3.5-4.0 хувь | 174 | 11.9% | 2,749.7 | 9.6% |
| Нийт | 1,468 | 100.0% | 28,682.4 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл*

Автомашины фидуци бүхий нийт зээлийн багцын дүнгийн 82.8 хувь нь сарын 2.5-3.0 хувь, 4.5 хувь нь сарын 3.0-3.5 хувь, 11.9 хувь нь сарын 3.5-4.0 хувь, үлдсэн 0.9 хувь нь сарын 1.5-2.5 хувийн хүүтэй зээлүүд байна. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны сарын хүү 1.54 хувь байгаа бол тус үнэт цаасны баталгаа болж буй зээлийн багцын жигнэсэн дундаж хүү нь 2.95 хувь байна. Иймд багц дахь хөрөнгийн мөнгөн урсгалын орлого нь хөрөнгө оруулагч нарт санал болгож буй өгөөжийн түвшнээс өндөр байна.

*Хүснэгт 35. Зээл ба барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа*

| Зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) | Зээлийн тоо | | Барьцааны дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь | Үнийн дүн (сая.төг) | Эзлэх хувь |
| 0-25 хувь | 22 | 1.5% | 489.3 | 1.7% |
| 25-50 хувь | 227 | 15.5% | 4,271.3 | 14.9% |
| 50-75 хувь | 1,213 | 82.6% | 23,786.1 | 82.9% |
| 75-100 хувь | 6 | 0.4% | 135.7 | 0.5% |
| Нийт | 1,468 | 100.0% | 28,682.4 | 100.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл*

10 зээлийн барьцаа хөрөнгийн ЗҮХ нь 75 хувиас хэтэрсэн байсан боловч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн №22/04А/85 дугаартай тушаалаар баталсан "Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл" журмын дагуу зээл олгогдсон тул уг тушаалаас хойш олгогдсон дугааргүй болон Эко-кар ХХК-иас олгосон автомашин худалдан авалтын зээлийн хувьд энэхүү шаардлагыг харгалзан үзээгүй талаар "Зээлийн шинжилгээний тайлан"-д тодруулжээ.

## ЗЭЭЛИЙН ЧАНАР

Автомашины фидуци бүхий зээлийн багц нь 100 хувь хэвийн зээлээс бүрдсэн байх шалгуур үзүүлэлтийг хөрөнгөөр баталгаажсан батлагаат үнэт цаасны хөрөнгийн багцын шалгуурт тавьсан. Бичил 2 ХБҮЦ-ны зээлийн багцыг бүрдүүлж буй бүх зээлийн гэрээнүүд нь хэвийн төлөлттэй буюу хэвийн ангиллын, зээлийн чанар сайн зээлүүд байна.

## ЗЭЭЛИЙН БАГЦЫН ДҮГНЭЛТ

Автомашины фидуци бүхий зээлийн багцын нийт дүнгийн 19.2 хувийг 24-30 сарын зээлийн гэрээний үлдэгдэл хугацаатай, 85.1 хувийг 10.0-25.0 сая төгрөгөөр олгогдсон зээлүүд эзэлж байна. Эндээс дүгнэхэд зээлийн багцад багтсан зээлийн гэрээнүүдийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй үнэт цаасны үндсэн 24 сарын хугацаанд хүү ба үндсэн төлбөр төлөлтийг хийх боломжтой байхаар хугацааны хувьд тархан байршжээ. Мөн зээлийн багц нь 100 хувь хэвийн зээлийн багцаас бүрдэж буй учраас Үнэт цаасны эргэн төлөлт тасалдах, зээлийн эрсдэл маш бага байх боломжтой байна.

Хөрөнгийн багцын нийт үнийн дүн нь Зээлийн шинжилгээний дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар 23,058,772,329 төгрөг байсан бол Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бичил глобус финанс ББСБ ХХК-иас хөрөнгийн багцыг 24,237,058,803 болгож нэмэгдүүлсэн. Хөрөнгийн багцын дүнг ийнхүү нэмэгдүүлсэн нь ХБҮЦ-ны найдвартай эргэн төлөгдөх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгийн багцын үнэлгээг нэмэгдүүлэх зорилготой юм.

## 4.6. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасан дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна. Хөрөнгийн багцыг солих, нэмэгдүүлэх, буцаан худалдах ажиллагааг Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын дагуу зохицуулна.

## ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

*Схем 9. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах хэлбэрүүд*

Багцын хөрөнгийг солих → Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх → Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах

1. Хөрөнгийн (зээлийн) багцад байгааг хөрөнгийг солих нөхцөлүүд:

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
- Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн зээл эргэн төлөх үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

2. Хөрөнгийн (зээлийн) багцад байгаа хөрөнгийг нэмэгдүүлэх нөхцөлүүд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх заалтын дагуу хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах нөхцөлүүд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-д заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

Мөн хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна. ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй.

## 4.7. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн хувьд үнэт цаас гаргагч, хөрөнгө итгэмжлэн удирдагч нартай байгуулсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн хувиар зээлийн хөрөнгийн багцад үйлчилгээ үзүүлж, удирдана.

"Бичил глобус финанс ББСБ" ХХК нь нягтлан бодох бүртгэлийн суурь систем болох Грейпсити Монгол ХХК-ийн "Поларис" үндсэн системийг санхүүгийн болон санхүүгийн бус бүх төрлийн гүйлгээ, бүртгэл, тайлан татаж хянах зэрэгт ашигладаг. Бичил Эй Би Эс Плас ХХК-д худалдах хөрөнгийн зээлийн данс бүртгэлийг хөтлөх, гүйлгээ хийх, бүртгэх, хянах, тайлан татах үйлдлүүдийг өөр тусдаа систем болох "Зээл худалдах систем (Securitization modul)" модулийг ашиглаж хийнэ. "Зээл худалдах систем" модулийг Поларис системд интеграци хийж холбосноор дээрх 2 систем хоорондоо хоршиж ажиллах боломжтой. Зээл худалдах модуль нь Грейпсити Монгол ХХК-ийн хөгжүүлсэн МИК ОССК банкнуудаас зээл худалдан авахад ашигладаг программ хангамж юм.

*Схем 10. Модулийн үндсэн бизнес процесс*




Модуль программ нь зээл худалдах болон худалдан авахтай холбоотой гэрээ болон зээлийн мэдээллийг бүртгэлжүүлж, тэдгээртэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг хийх зорилго бүхий модуль юм. Бүтээгдэхүүний бүртгэлийг ашиглаж зээл худалдах/худалдан авах гэрээлэх үйл ажиллагааг данс болгон бүртгэдэг. Данс бүртгэхийн тулд бүтээгдэхүүнийг урьдчилан тодорхойлж өгөх шаардлагатай ба бүтээгдэхүүний бүртгэл дээр уг бүтээгдэхүүн дээр мөрдөгдөх тохиргоог хийнэ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -03- 15
БҮРТГЭВ-02

2023 .06. 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- **Баримт бичгийн хадгалалт хамгаалалт**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, ТЗК-тай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг ТЗК-д хүргүүлэх хүлээн авах зэргээр хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, ТЗК-г хариуцсан эрх бүхий ажилтныг томилж ажиллуулна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хөрөнгийн багцын дараах баримт бичгүүдийг өөрийн оффис дээр хадгалж хамгаална. Үүнд:

- Хөрөнгийн багцыг бүрдүүлж буй бүх зээлийн баримт бичгүүд;
- Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа;

Зээлийн эргэн төлөлт, харилцагчдын төлбөр цуглуулах үйл ажиллагааг хариуцсан нэгж нь салбар дээрх зээлийн эдийн засагч байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Үйлчилгээ үзүүлэгчийн нийт 16 салбарын 53 зээл дээр мэргэшсэн хүмүүс ажилладаг. Үйлчилгээ үзүүлэгч нь сар бүр Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тухайн сард төлөгдсөн эргэн төлөлтийн мэдээллийг бэлтгэн акт үйлдэх юм.

Грэйпсити Монгол ХХК нь Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдөр ЛА-23/32 дугаартай Поларис суурь системтэй хоршин ажиллах Зээл худалдах системийг түрээсээр ашиглуулах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг зохицуулах гэрээг байгуулсан.

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

### Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

Тус гэрээг нэг талаас "Бичил глобус финанс ББСБ" ХХК буюу Захиргааны үйлчилгээ үзүүлэгч, нөгөө талаас "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК буюу Үнэт цаас гаргагч нь 2023 оны 5 дугээр сарын 3-ны өдөр 23/612 дугаартай байгуулсан. Энэхүү гэрээгээр "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой Захиргааны үйлчилгээ үзүүлэх ажлыг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч хийж гүйцэтгэх, ТЗК нь ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон байна.

### Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ

Тус гэрээг нэг талаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил глобус финанс ББСБ" ХХК болон Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК нь 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан. Энэхүү гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцсэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулсан болно. Үнэт цаас гаргагч нь зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг хөрөнгийн багц болгон худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг гэрээнд заасан үндэслэл, шалгуураар солих, нэмэх нөхцөлтэйгээр худалдахаар тохиролцсон байна.

### Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ

Тус гэрээгээр Үйлчилгээ үзүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК нь Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК-иас гаргах Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон байна.

## 4.8. ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ

Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК-ийн компанийн дүрмийн 8 дугаар зүйлд зааснаар ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.

*Схем 11. Татан буугдах нөхцөл*

- Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн эсхүл Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан
- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдаж авсан
- Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

ТЗК-ийг татан буулгах шийдвэрийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт зааснаар (а) Тусгай зориулалтын компани, (б) Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч эсхүл, (в) Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх тус тус гаргана.

### Татан буугдсан ТЗК-ийн хөрөнгийг хуваарилахдаа дараах дарааллыг мөрдөнө.

* Татан буулгах ажиллагааны зардал;
* Үнэт цаасны танилцуулгад заасан дарааллын дагуу хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны төлбөр;
* Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан гэрээний дагуу ТЗК-иас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
* Хөрөнгөөр батлагаажсан үнэт цаасны тухай хуульд заасан гэрээний дагуу авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;

гэсэн дарааллаар хөрөнгө хуваарилсны дараа үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

## 4.9. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаасжуулах ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлого тасалдах эрсдэл бий болж болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-ыг баталсан.

Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна.

### ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

*Схем 12. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны явцад учир болзошгүй эрсдэлүүд*

| | | |
|---|---|---|
| Зээлтэй холбоотой эрсдэл | Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл | Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл |

Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдэд зээлтэй холбоотой эрсдэл, үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл, гадаад хүчин зүйлс буюу давагдашгүй хүчин зүйлс, хууль, журам, зохицуулалттай холбоотой эрсдэлүүд хамаарч байна.

*Хүснэгт 36. Учирч болзошгүй эрсдэлүүд*

| Эрсдэл | Тодорхойлолт |
|---|---|
| Зээлтэй холбоотой эрсдэл | • Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргэ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно;<br>• Хугацаанаас өмнө эрэн төлөгдөх эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно. |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл | • ТЗК-д шалгуур хангахгүй зээл шилжүүлэх;<br>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болсон;<br>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан. |
| Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл | • Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх;<br>• Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах;<br>• Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, дампуурсан. |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-03-15

2023.06.02

| | |
|---|---|
| Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл | • Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах;<br>• Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах;<br>• Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурсан. |
| Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл | • ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэл;<br>• Давагдашгүй хүчин зүйлс. |

Үнэт цаасжуулах үйл ажилагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг бууруулах, сэргийлэх зорилгоор дараах эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна.

*Хүснэгт 37. Учирч болзошгүй эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө*

| Эрсдэл | Эрсдэлийн удирдлага |
|---|---|
| Зээлтэй холбоотой эрсдэл | • ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг СЗХ-с баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-г мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.<br>• Эрсдэлийн сан байгуулах ТЗК нь дээрх журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.<br>• ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.<br>• ТЗК нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-д заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.<br>• Зээл 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд тухайн зээлийг хэвийн ангилалтай, шалгуур хангасан ижил төрлийн зээлээр солих арга хэмжээ авч, ТЗК-ийн хөрөнгийн багцыг хэвийн ангилалтай зээлээр бүрдүүлж ажиллана. |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл | • ТЗК-д шалгуур хангахгүй зээл шилжүүлсэн эрсдэл үүсэх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.<br>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.<br>• ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна. |
| Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл | • Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг уг дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.<br>• Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо |

ТЗК ХХК АТА9998 6... 9923050...

| | |
|---|---|
| | мөрдөгдөж буй "Зээлийн үйл ажиллагааны журам", "Хугацаа хэтэрсэн зээлтэй ажиллах журам" зэрэг зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.<br>• Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.<br>• ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна. |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл** | • Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.<br>• Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.<br>• ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна. |
| **Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл** | • Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийн удирдлага: ХБҮЦ, ТЗК болон оролцогч талуудтай холбоотой хууль журам, зохицуулалтад өөрчлөлт орсон эрсдэл үүссэн бол (Энэ журмын 3.4 дүгээр зүйлийн 3.4.1-д) заасан эрсдэлтэй холбогдуулан ТЗК-ийн ТУЗ- ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.<br>• Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийн удирдлага: Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд ямар байдлаар давагдашгүй хүчин зүйл үүссэн, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээ, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.<br>• Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь үндсэн үүргээс чөлөөлөхгүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК-ийн үүрэг |

биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

Хөрөнгөөр баталгаажсан Үнэт цаас гаргагч нь уг үйл ажиллагаанд оролцогч аудит, хуулийн үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчтай сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, зохих мэдэгдэл баталгаа гаргуулах, сонирхлын зөрчил үүсч болохоор нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах зэрэг холбогдох арга хэмжээ авна.

## ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Тусгай зориулалтын компани (ТЗК) нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.

- Хөрөнгийн багцыг сайжруулах, солих;
- Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;
- Хөрөнгийн багцын дүнг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгээс багагүй байлгах;
- Эрсдэлийн сан байгуулах;
- Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгах;
- ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-ын 3.3.6 дугаар хэсгийн 3.3.6.1-д заасны дагуу зохион байгуулах;
- ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлэх;
- ТЗК нь татан буугдах үед хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа үлдсэн зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу ТЗК-ийн үүсгэн байгуулагч-Хувьцаа эзэмшигчид шилжинэ.

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, ТЭДГЭЭРИЙГ МЭДЭГДЭХ

Хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудит, Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана. Үнэт цаас гаргах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, дараах үйлдлийг хориглоно.

- Оролцогч талуудын болон хөрөнгө оруулагчдын нууц мэдээллийг задруулах;
- Аливаа гуравдагч этгээдэд үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх;
- Үнэт цаас эзэмшигчид үнэт цаас, түүний эргэн төлөх ажиллагааны талаар буруу ойлголт өгөх, бодит байдлыг нуун дарагдуулах;
- Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг, хүсэл сонирхлын эсрэг ажиллах;
- Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг санаатайгаар буруу хэрэглэх, тайлбарлах;
- Бусад оролцогч талуудын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах.

Мөн ТЗК нь ХБҮЦ гаргахдаа оролцогч талуудаас ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолтыг авсан байна. Оролцогч талуудын зүгээс холбогдох гэрээний дагуу мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсхүл үүсч болзошгүй нөхцөлд энэ талаар ТЗК-д мэдэгдэж, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч, эсхүл тэдгээрийн ажилтнууд нь сонирхлын зөрчилтэй харилцаа үүсгэсэн, үүсгэж болзошгүй бол ТЗК болон холбогдох талуудад мэдэгдэж, мэдээлэлтэй зөвшөөрөл авч болно.

СЗХ-ны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 7 дугаар зүйлийн дагуу Үйлчилгээ үзүүлэгч буюу Бичил глобус финанс ББСБ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

Мөн Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас ТЗК болон хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана. ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулахын өмнө тухай Үйлчилгээ үзүүлэгчийн хууль болон "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын шаардлага хангасан эсэх тухай нотлох баримтыг СЗХ-нд ирүүлнэ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

СЗХ

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# ТАВ. Хууль, эрх зүйн орчин

БИЧИЛ 2.0

ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 5.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМААРАХ ХУУЛЬ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаа нь хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

- Иргэний хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Зээлийн мэдээллийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;

### СЗХ-НООС ГАРГАСАН ДҮРЭМ, ЖУРМУУД

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам;
- Үнэт цаасны бүртгэлийн журам;
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам;
- Үнэт цаас зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам;
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам.

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИЖРИЙН ЖУРМУУД

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлийн журам;
- Арилжааны журам;
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам.

### ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВИЙН ЖУРМУУД

- Үнэт цаасны хадгаламжийн журам;
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам.

### АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа нь Банк бус санхүүгийн байгууллага болохын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

- Монгол Улсын үндсэн хууль;

- Монгол Улсын Олон Улсын гэрээ конвенцийг соёрхон батлах тухай (Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Олон Улсын конвенц);
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар, болон агаараар хууль бусаар тэвээрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай (Палермогийн конвенц);
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам;
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам;
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт хийх журам;
- Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журам, Барьцаа хөрөнгийн үйл ажиллагааны журам;
- Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл.

## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байдаг.

Дээрхээс үзвэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой эрх зүйн үндсийг тогтож байгаа эрх зүйн гол баримт бичиг нь энэ хууль болох бөгөөд уг хуулиар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд танигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат үнэт цаас гаргах харилцаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд бүрд

тусгагдсан байна. Дээрх хуульд үндэслэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс гаргасан журмуудаар зохицуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн №360 тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх)-ыг бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, ХБҮЦ гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулна" гэж заасан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон түүнийг бүртгэх, оролцогчдод тавих шалгуурыг тогтоох, эрх олгохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан байна.

Мөн энэхүү журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч хуулийн этгээдтэй холбоотой Компанийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй асуудлууд болох үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

Монголын хөрөнгийн биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур шаардлага тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд Биржээс хяналт тавих журмыг тогтоосон байна.

## 5.2. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМУУД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан.

*Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчтай холбоотой дүрэм, журмууд*

| Журам | Хураангуй тодорхойлолт |
|---|---|
| **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам** | Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан. |
| **Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам** | Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан. |

| | |
|---|---|
| **Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам** | Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан. |
| **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам** | Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас буюу ХБҮЦ гаргахтай холбоотойгоор байгуулагдсан ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан. |
| **Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам** | Тус журмаар ТЗК-аас гаргах Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулна. |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдах журам** | Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан. |
| **Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам** | Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан. |

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# ЗУРГАА. Үнэт цаасны арилжаа

БИЧИЛ 2.0

ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 6.1. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1 болон 12.2-т зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны олон нийтэд санал болгохыг хүлээн зөвшөөрсөн, мөн Монголын хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлээр арилжихыг заасан байдаг.

Улмаар Бичил 2 ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" (2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан), мөн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д (ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн №05 тогтоолоор өөрчлөлт оруулсан) заасны дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн "ХБҮЦ-ны бүртгэлийн журам"-д заасан шалгуурын дагуу "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд ХБҮЦ-ыг санал болгон арилжаална. Тус үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болно. Бичил 2 ХБҮЦ-ыг ангилалтай гаргахгүй бөгөөд тус баталгаат үнэт цаасыг хөтөлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдахгүй.

Бичил 2 ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд явуулах ба захиалгын дүн татан төвлөрүүлэх хөрөнгийн 100.0 хувьд хүрсэн тохиолдолд арилжааг амжилттай болсонд тооцож, анхдагч зах зээлийн арилжааг хаана. Олон нийтэд танилцуулах, сурталчлах болон ХБҮЦ-ны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд дараах үйл явцын дагуу санал болгоно.

*Схем 13. Анхдагч зах зээлийн арилжааны үйл явц*




Олон нийтэд мэдээлэх аян (roadshow)-ыг ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулах ба анхдагч зах зээлийн захиалгыг ажлын 5 өдөрт бүрэн бүрдүүлж, захиалгыг хаана.

## 6.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд СЗХ-ноос зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан оролцох боломжтой.

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандаа байршуулах боломжтой. Хэрэв үнэт цаасны дансгүй бол Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдгийг та тооцно уу.

1. *Дурын банкнаас бонд авах мөнгөн дүнг дараах зааврын дагуу байршуулаад өөрийн үйлчлүүлдэг брокерийн компанийн аппликэйшнийг ашиглан захиалгаа оруулах эсхүл брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.*

   Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
   Дансны нэр: Таны өөрийн нэр
   Дансны дугаар: **** **** **** (өөрийн брокероос лавлах)
   Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

2. *Дурын данснаас өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн номинал дансанд байршуулаад цахимаар болон утсаар захиалгаа баталгаажуулах боломжтой.*

   Банкны нэр: ҮЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр
   Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр
   Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар
   Гүйлгээний утга: регистрийн дугаар

### ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

ХБҮЦ-ыг олон нийтэд нээлттэй санал болгох үйл ажиллагаа амжилттай болсон тохиолдолд, МХБ-ын холбогдох журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр тус үнэт цаасыг эзэмшигч нь хоёрдогч зах зээл дээр бусдад чөлөөтэй худалдах, бусдаас худалдан авах эрхтэй байна.

## 6.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас эзэмшигч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны гэрээнд заасны дагуу дараах эрхтэй байна. Үүнд:

- ХБҮЦ-ыг Монголын хөрөнгийн биржийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- ХБҮЦ эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -03- 15

СЗХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Үнэт цаасны танилцуулга болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг буцаан худалдах санал гаргах;
- Хууль тогтоомжид заасан бусад.

### Албан татварын тухай

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5.0 хувийн татвар төлнө. Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн 18.6.3-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсан, шилжүүлсэн үнээс худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, энэхүү дүнгээс тус хуулийн 20.2.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

## 6.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

ТЗК нь хөрөнгийн өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй.

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган, үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, ногдох татварыг төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам"-д заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

## 6.5. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй.

Мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛЮС ТЗК ХХК
АТА9998 9999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183865
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -06- 15

СЗХ 2023 .06. 02 өдөр

ил тод байдлын журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээллүүдийг үнэт цаас эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Үнэт цаас гаргагчийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь ТЗК нь татан буугдах хүртэл хугацаанд байршина.

## ХУГАЦААНЫ ТОГТМОЛ ДАВТАМЖТАЙ ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ

### Өөрчлөлт гарсан тохиолдолд хүргүүлэх мэдээлэл

ТЗК нь дараах мэдээлэлд өөрчлөлт орсон бол дараа сарын 10-ны өдрийн дотор Хороо болон хөрөнгө оруулагчид мэдээлнэ.

- Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт;
- Хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал;
- Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ;
- Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;
- Санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан;
- Хууль тогтоомж, энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд албан бичгээр ирүүлэх мэдээллүүд:

- ТЗК нь хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга, гишүүдэд өөрчлөлт оруулсан бол энэ тухай Хороонд ажлын гурван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;
- ТЗК нь баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй хүрээнд худалдах ажиллагааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулснаас үл хамааран олон нийтэд танилцуулах, сурталчлах, захиалга авах, хуваарилах хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд албан бичгээр мэдэгдэх;
- ТЗК нь баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдаж, үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд хүргүүлэх.

Мөн ТЗК-ийн дүрэмд зөвхөн Хорооны зөвшөөрөл өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн

өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэх үүрэгтэй.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан Монголын хөрөнгийн биржид ирүүлэх мэдээллүүд:

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
- Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;
- Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ийг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл;
- Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10.0 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5.0 хувиар өөрчлөгдөх тутамд;
- ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;
- Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах;
- Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;
- Барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд шинээр үнэт цаас гаргахтай холбоотойгоор барьцаа, баталгаа гаргах;
- ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;
- Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;
- Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;
- Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд;
- Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл.

### Хагас жил тутам хүргүүлэх мэдээлэл

СЗХ болон МХБ-д бичгээр хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ. Тус мэдээллийг Хороонд хүргүүлэхдээ цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлэх бөгөөд дараах мэдээллүүд багтсан байна.

- Хөрөнгийн багцын үлдэгдэл;
- Хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;
- Хугацаанаасаа өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;
- Ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ;

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-03-15 БҮРТГЭВ-02
СЗХ БҮРТГЭВ №01
УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИЗНЕС ПЛАН ТЗК ХХК 9023050164
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

СЗХ
он сар өдөр
2023 06 02
ИРСЭН
№ 01

- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл;
- Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл.

Мөн багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээллийг МХБ-д дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.

### Жил тутам хүргүүлэх мэдээлэл

ТЗК нь жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид дараа оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор СЗХ, хөрөнгө оруулагчдад болон Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ. Энэхүү мэдээллийг Хороонд хүргүүлэхдээ цахим болон хэвлэмэл хэлбэрээр мэдээлэх үүрэгтэй.

Үүнд дараах мэдээлэл багтсан байна.

- ТЗК-ийн болон түүний үүсгэн байгуулагчийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт;
- Үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдийн тайлан;
- Хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагчийн сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл;
- ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Дээрх мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр давхар хүргэж болно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
9021031195 СТС2420

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# ДОЛОО. Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагуудын тухай

БИЧИЛ 2.0

ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 7.1. АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, брокер, дилер, номинал дансны үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2007.12.06 |
| Регистрийн дугаар | 5183855 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 |
| Утас | +976 7777-6377 |
| Цахим шуудан | info@ucc.mn |
| ХБҮЦ дээр ажилласан туршлага | Симпл ассет ХБҮЦ, ЛэндМН актив ХБҮЦ |

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, Нью-Йоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

| | |
|---|---|
| 2008 он | Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан. |
| 2009 он | Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан. |
| 2010 он | Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн. |
| 2010 он | Bank of China International-тай түншлэв. |
| 2011 он | Шилдэг брокерын компани |
| 2011 он | Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн |
| 2013 он | Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага" |
| 2015-2018 он | Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх |
| 2016 он | Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч |
| 2018 он | МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч |

| | |
|---|---|
| 2018 он | Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шилдэг Мэргэжилтэн" |
| 2019-2020 он | Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан. |
| 2019 он | "Ард Кредит ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов. |
| 2020 он | "ЛэндМН" ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер |
| 2020 он | Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн |
| 2020 он | МҮОНТ-н "Цагийн хүрдийн баатар" |
| 2020 он | Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер |
| 2021 он | Биржийн бус зах зээл (OTC)-ийн анхны гишүүн байгууллага |
| 2021 он | Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан "Sandbox" төслийн анхны бүтээгдэхүүн болох "Монпэй" бондын андеррайтер |
| 2021 он | Биржийн бус зах зээлийн (OTC)-ийн анхны "БИД" бондын андеррайтер |
| 2022 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Ашид капитал ББСБ" ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| 2022 он | Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер |
| 2022 он | МҮОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд хамтрагч компани |
| 2022 он | "Төрийн банк "ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат болох эхлэлийг тавьсан. |
| 2022 он | "Сэндли ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер |
| 2022 он | "ЛэндМН" ХБҮЦ-д хамтрагч андеррайтер |
| 2023 он | "Сэндли нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Үйзэн-Ивээлт ББСБ" ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |

Өнөөгийн байдлаар **"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК"** нь:

"Мобифинанс ББСБ", "М-Си-Эс Инвестмент" ХХК, "Капитрон банк", "Ай Си Ти групп", "Сүү ХК", "Төрийн банк", "БИД ББСБ" , "Ашид капитал ББСБ", "Монголчех Метал", "ОНДО", "Монголын финтек групп", "Эрхэт Монгол групп", "Бичил глобус финанс ББСБ" гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 200.0 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь Бичил Эй Би Эс плас ТЗК ХХК, Бичил глобус финанс ББСБ ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр №АГ-23/11 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээнд Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн дараах эрх, үүргийг тодорхойлсон. Үүнд:

- Андеррайтер нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн Бүртгэлийн журам болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах;
- Андеррайтер нь гэрээ болон ажлын төлөвлөгөөнд заасан ажил, үүргээ зохих ёсоор шударгаар биелүүлэх үүрэгтэй бөгөөд Андеррайтер нь төлөвлөгөөнд заасан ажил, үүргийг тогтсон хугацаанд нь гүйцэтгэх;
- Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн аливаа дотоод мэдээлэл болон нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр санаатай болон санамсаргүй байдлаар задруулахгүй, дамжуулахгүй байх, мөн түүнчлэн гуравдагч этгээд тэдгээр мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай харилцаж, Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтан, мэргэжилтэнг томилон ажиллуулах ба тэдгээр ажилтан, мэргэжилтэн нартай Андеррайтераас өгсөн удирдамжийн дагуу холбогдох холбогдох ажил үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадаагүй тохиолдолд түүнийг солих шаардлагыг Андеррайтерийн зүгээс тавьж болох бөгөөд Үнэт цаас гаргагч энэхүү шаардлагыг биелүүлэх;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг гэрээнд заасан болон Андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах;
- Хэрэв Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг Андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэлгээнд эрс өөрчлөлт гарсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол Үнэт цаас гаргагч учирсан хохирлыг өөрөө хариуцах;
- Гэрээг хэрэгжүүлэх явцад Андеррайтераас Үнэт цаас гаргачид хүргүүлсэн нийтэд ил болоогүй бүх төрлийн мэдээлэл, зөвлөмж, тайлан мэдээ, төсөл төлөвлөгөөний загвар, агуулга, мэдээлэл зэргийг Үнэт цаас гаргагч нь зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд, Үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангахад ашиглах, Андеррайтерийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх.

МОНГОЛЫН ... БИРЖ
MONG... EXCHANGE
2023-03-15

СЗХ
он сар өдөр
2023.06.02
Бүртгэв
№ 01

## 7.2. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2021.09.16 |
| Регистрийн дугаар | 2870657 |
| Хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005 тоот |
| Утас | +976 7012-2346 |
| Цахим шуудан | info@uaf.mn |
| ХБҮЦ дээр ажилласан туршлага | Омни актив ХБҮЦ, Симпл ассет ХБҮЦ, Бэрс ХБҮЦ, Нөмөр кредит ассет ХБҮЦ, ЛэндМН актив ХБҮЦ, Бичил Глобус ХБҮЦ, Бэрс 2 ХБҮЦ |

Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох Юнайтед Айр Файнэнс ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

Юнайтед Айр Файнэнс ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар банк, банк бус санхүүгийн байгууллага, Орон сууцны санхүүжилтийн компани болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын Тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан нийт 96.35 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж, долоон Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тухайлбал, "Омни Актив ТЗК" ХХК 2.5 тэрбум төгрөг, "Симпл Ассет ТЗК" ХХК 50.0 тэрбум төгрөг, "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК 10.0 тэрбум төгрөг, "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК 10.0 тэрбум төгрөг, "ЛэндМН Актив ТЗК" ХХК 4.85 тэрбум төгрөг, "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК 10.0 тэрбум төгрөгийн хөрөнгө итгэмжлэн удирдаж байна.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ... ТЗК ХХК
АТА9998 ... 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК ХХК
5163655
9021031195 СТС2420

2023-09-15

## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

Нэг талаас "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх), түүнийг төлөөлж ТУЗ-ийн дарга Н.Гантулга, нөгөө талаас СЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 тогтоолоор олгосон Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах ТЗ 316/18 дугаар тусгай зөвшөөрөлтэй "Юнайтед Айр Файнэнс" ХХК (цаашид "Хөрөнгө итгэмжлэн удирдагч" гэх), түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ нар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийг тус тус удиртгал болгон сайн дурын үндсэн дээр 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 23/611 дугаартай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана;
- Хөрөнгийн багцад хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг өөрчлөлтүүдийг оруулна;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасны дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх буюу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна;
- Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно;
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.

## 7.3. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "Онч аудит" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2004 |
| Регистрийн дугаар | 2810743 |
| Хаяг | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян-Гүний гудамж, ICC цамхаг, 15 давхар |
| Утас | (+976) 7012-0450 |
| Цахим шуудан | info@onch.mn |
| ХБҮЦ дээр ажилласан туршлага | Бэрс ХБҮЦ, Бичил Глобус ХБҮЦ, Бэрс 2 ХБҮЦ |

Зээлийн шинжилгээ гаргагч нь 2004 онд "Онч Аудит" ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд өндөр ур чадвартай, туршлагатай, дээд зэргийн чадварлаг, бие даасан үндэсний аудиторуудыг бий болгож хөгжүүлэх зорилго өвөрлөн ажлын гараагаа эхлүүлж байв. Үүсгэн байгуулагч, Onch & Company-ийн Ерөнхий захирал Д.Essential Ончинсүрэн нь олон улсын байгууллагуудад ажиллаж, ур чадвараа таниулсан, арвин их туршлагатай үндэсний мэргэжилтэн юм. Анх зөвхөн аудитын үйлчилгээ үзүүлдэг байсан бол одоо үйлчилгээнийхээ хүрээг амжилттай тэлж татварын зөвлөгөө, нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг, менежментийн зөвлөх үйлчилгээ болон сургалт, коучинг зэрэг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж байна.

"Онч Аудит" ХХК нь 2012 онд дэлхийн алдарт зөвлөх үйлчилгээний сүлжээ болох "Делоитт" групптэй хамтран ажилласан. Монгол Улсын өнөөгийн макро эдийн засгийн бизнес болон зах зээлийн сорилтуудын улмаас Делоитт Монголын зах зээлээс гарах шийдвэр гаргах хүртэл дэлхийн Их дөрвөлийн нэг Делоиттийн сүлжээний нэг бүрэлдэхүүн болж 10 жил ажилласан. 2022 оны хоёрдугаар сарын 1-нээс Үндэсний брэнд "Onch & Company" нэрийн дор дэлхийн түвшний үйлчилгээгээ үргэлжлүүлэн хүргэж байна. Одоогийн байдлаар Онч Аудит ХХК нь Монголд аудит, татвар, удирдлагын болон бизнесийн зөвлөх үйлчилгээгээр салбартаа тэргүүлэгч компаниудын нэг бөгөөд Улаанбаатар дахь оффистоо Big 4 буюу дэлхийн санхүү, аудитын салбарын тэргүүн, Их дөрвөлийн 10 жилийн туршлагатай 50 орчим мэргэжилтэнтэй.

Уул уурхай, банк санхүү, худалдаа, үйлдвэрлэл, агаарын тээврийн салбарт үйл ажиллагаа явуулдаг томоохон олон нийтийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд аудит, татвар болон зөвлөх үйлчилгээг амжилттай үзүүлэн ажиллаж байна. Үүнээс Монголын Ипотекийн Корпорацид Харилцан тохиролцсон горим гүйцэтгэх үйлчилгээг багц 17, 18, 20, 23, 24, 30, 31, 33, Бэрс финанс ББСБ болон Бичил глобус финанс ББСБ-д Харилцан тохиролцсон горим гүйцэтгэх үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Мөн банк санхүүгийн салбарт аудит болон зөвлөх үйлчилгээг тасралтгүй хүргэж байгаа бөгөөд Хасбанк ХХК, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК, Тэнгэр Даатгал ХХК, Мандал ирээдүйн өсөлт ХОС ХХК, ХасЛизинг ХХК, Транскапитал ББСБ-д Олон Улсын аудитын стандартын дагуу аудит баталгаажуулалтын үйлчилгээг, Хаан Банк ХХК-д 2004 оноос эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үнэлгээ, мөн дижитал төлөвшлийн үнэлгээ зэрэг томоохон төслүүдийг чанарын өндөр түвшинд, хараат бусаар хийж гүйцэтгэн харилцагч нарынхаа зорилгодоо хүрэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Өнч Аудит ХХК нь Говь ХК, Таван Богд Групп, Номин Групп, Оюу толгой ХХК, Сүү ХК, Моннис Групп, Монголын Алт (МАК) Корпорац ХХК-аас гадна төрийн байгууллагууд болох Монгол Улсын Сангийн Яам, Улаанбаатар хот, Монголын татварын алба, МУИС-ийн Бизнесийн сургууль зэрэгт аудит баталгаажуулалтын үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, мөн Олон Улсын байгууллагууд болох НҮБ, Азийн Хөгжлийн Сан, КОЙКА зэрэг байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа төслүүдэд зөвлөх болон аудитораар ажиллаж байна.

## ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

Зээлийн шинжилгээ гаргах үйлчилгээ үзүүлэх зорилгоор, Зээлийн шинжилгээ гаргагч гэж “Өнч аудит” ХХК (цаашид “аудитор” гэх), “Харилцагч” гэж “Бичил глобус финанс ББСБ” ХХК (цаашид “Харилцагч” гэх) бөгөөд Үйлчилгээ үзүүлэх гэрээнд дараах Аудитор болон Харилцагчийн эрх, үүргийг тусгажээ.

- Аудитор нь Харилцагчийн, эсвэл бусдын бэлдэж өгсөн мэдээ, мэдээлэлд баталгаажуулалтгүйгээр найдаж, ашиглаж болно. Аудиторын гүйцэтгэл нь Харилцагч хариуцлагаа тухай бүр хэрэгжүүлэх болон Үйлчилгээтэй холбогдуулан тухай бүр шийдвэр, зөвшөөрөл гаргах байдлаас хамаарна;
- Аудитор нь энэхүү гэрээ, түүний хавсралтуудад заасан ажил үүргийг Монгол Улсын болон Олон Улсын холбогдох хууль тогтоомж стандартад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ. Аудитор энэхүү гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлж буй харилцагчийн хүсэлтийнх нь дагуу тайлангийн үйл явцын талаар мэдээлэх үүрэгтэй;
- Үйлчилгээний гүйцэтгэлийн явцад Аудитор нь Харилцагчтай зөвлөлдөх, эсвэл тэдний саналыг тусгахын тулд тайлангаа үзүүлж болно. Ингэхдээ Харилцагч нь урьдчилсан тайлан болоод аман тайлбар болон зөвлөгөөнд түшиглэхгүй гэсэн үндсэн дээр хийгдэнэ. Тиймээс хэрэв Харилцагч урьдчилсан тайлан болоод аман тайлбар болон зөвлөгөөний үндсэн дээр үйлдэл хийх эсвэл үйлдэл хийхээс түдгэлзвэл Аудитор хариуцлага хүлээхгүй. Мөн Харилцагчид тайлангийн электрон хуулбарыг бэлтгэн өгч болно. Санал зөрөлдсөн тохиолдолд гарын үсэг зурсан сүүлийн тайлангийн дагуу шийдвэрлэнэ;
- Аудитор нь энэхүү гэрээний дагуу боловсруулагдсан тайлан, материал, ажил үйлчилгээг дотоод хэрэглээнд болон аливаа гуравдагч этгээдэд ашиглагдах материалыг боловсруулах үед шууд авч ашиглахгүй бөгөөд ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгч байгууллагатай хамтран ажиллах тохиолдолд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх үүднээс харилцагчид мэдээлнэ;
- Аудиторын хариуцлага нь зөвхөн үйлчилгээг үзүүлэхэд гаргасан Аудиторын алдаанаас шууд хамаарах бодит хохирлоор хязгаарлагдана. Аудитор нь үйлчилгээг үзүүлж байхдаа Аудиторын үйлдлээс болж олох байсан ашгийн төлөө Харилцагчийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ямар ч тохиолдолд Харилцагчийн өмнө хүлээх Аудиторын хариуцлага нь Аудиторын үйлчилгээ үзүүлсний төлөө бодитоор төлсөн дүнгээр хязгаарлагдана.

## 7.4. ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН |
| Үйл ажиллагааны чиглэл | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2011 |
| Регистрийн дугаар | 5495997 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас | +976 11 330048 |
| Цахим шуудан | info@mdsa.mn |
| ХБҮЦ дээр ажилласан туршлага | ЛэндМН актив ХБҮЦ, Бэрс ХБҮЦ, Инвескор актив ХБҮЦ, МИК актив 1-13,21,23,24,28,29 |

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг. "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн бирж дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох "Wolf" төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах; "Монгол Улсын Хөрөнгийн Бирж" дээр гаргасан анхны 100% даатгагдсан "Эрчим бонд" гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах; "ЛэндМН" ББСБ ХК-ийн IPO, 2 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох төсөл; "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, "Түмэн шувуут" ХК-ийн IPO гаргах төсөл; "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; "Монголын Ипотекийн Корпораци" ХХК-ийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төслүүд; "Сэндли ББСБ" ХХК, "Төрийн банк" ХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн IPO төсөл, "ЛэндМН актив ТЗК" ХХК болон "Бэрс Актив ТЗК" ХХК, "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төслүүд дээр хууль зүйн дүгнэлт гаргаж ажилласан. Түүнчлэн биржийн бус зах зээлд "Ай си рэйт" ХХК-ийн өрийн хэрэгсэл гаргахад хууль зүйн дүгнэлт гаргасан туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН-ийг "2021, 2022 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байна.

### ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

Энэхүү гэрээний зорилго нь "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "Хуулийн зөвлөх" гэх) нь Гэрээгээр тохиролцсон хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээг Бичил глобус финанс ББСБ ХХК (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-д үзүүлэх, Үйлчлүүлэгч нь тохиролцсон хөлсийг Хуулийн

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15

СЗХ
он сар өдөр
2023.06.03
№ 01

зөвлөхөд төлөхтэй холбоотойгоор Талуудын харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх;
- Хуулийн зөвлөх нь шаардлагатай тохиолдолд өөрийн гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлтийн талаар хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллага болон бусад этгээдийн өмнө шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх үүрэгтэй;
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;
- Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн түвшинд, чанартай үзүүлж, хуулийн дүгнэлтийг аливаа доголдолгүй, бүрэн гүйцэд гаргах;
- Хуулийн зөвлөх нь Гэрээнд заасан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүрд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үйлчлүүлэгчээс шаардан авах эрхтэй;
- Үйлчлүүлэгч нь Гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээ мэдээлэл, баримт бичгээр Хуулийн зөвлөхийг хангах, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах байраар хангах;
- Үйлчлүүлэгч нь гэрээнд заасны дагуу үнэн бодит мэдээллээр хангах, Хуулийн зөвлөхийн нууцыг чандлан хадгалах, Гэрээгээр харилцан тохирсон хугацаанд ажлын хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй
- Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд үйлчилгээний талаар шаардлага тавих санал гаргах эрхтэй.

## 7.5. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бичил глобус финанс ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бичил глобус финанс ББСБ" ХХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
- Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
- Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН;
- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК;

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг Хавсралт 8.13-аас харна уу.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

Bichil ABS plus

# НАЙМ. Хавсралт

БИЧИЛ 2.0

# ХБҮЦ

20 ТЭРБУМ

## 8.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛС

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000272328

2023.03.01
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011849203
/ Хувийн хэргийн дугаар /

6999131
/ Регистрийн дугаар /

Бичил Эй Би Эс плас ТЗК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2023.02.24 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

66300 — Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
/ Код / — / Үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 1 | 1,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / эзэмшүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101, 705 тоот, Утас1: 99119632, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тамга/ Х БОЛОРЧУЛУУН /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 05 сар 01 өдөр

Үнэт цаасны танилцуулга

СЗХ
он сар өдөр
2023.06.02
№ 01

2023-03-15

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтны тэмдэг |
| 1 | Самдан овогтой Отгонбат-ы Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2023.03.01 | Х.Болорчулуун |
| 2 | Дахин гэрчилгээ олгов | 2023.05.01 | Х.Болорчулуун |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000272328

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ... ПЛАС ТЭК ХХК
АТА9998-Г 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163655
9021031195 СТС2420

## 8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 315/57

2023 оны 04 сарын 21 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 04 сарын 21 өдрийн 118 дугаар тогтоолоор **"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК**-д **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах** үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ / MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-15

СЗХ 2023.06.02

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164

УЛААНБААТАР ХОТ ЭРЭНБЭЛЭКО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031196 СТС2420

Үнэт цаасны танилцуулга

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 315/57 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: "БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах | 2023.04.21 | №118 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9923050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЭХ он сар өдөр 2023.06.02 № 01

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 7-р хороолол, ногоон нуур, 101 барилга, 705 тоот. | 99119632 | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2023.04.21 | №118 | 1,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗ ХХК АТА9998 6999131 9023050164

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Бичил глобус финанс ББСБ" ХХК | 5729718 | 1,000,000 | 100% | 2023.04.21 | №118 тогтоол |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## 8.3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ

"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195 СТС2420

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. **"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК** /цаашид **"Компани"** эсхүл **"ТЗК"** гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид "Дүрэм"гэх/-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2. Компанийн оноосон нэр (монголоор)

а) Бүтэн нэр: **"Бичил Эй Би Эс Плас Тусгай Зориулалтын Компани" ХХК**, товчилсон нэр нь **"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК**

б) Англи нэр буюу товчилсон нэр: **"Bichil ABS Plus Speciil Purposed Company" LLC** буюу **"Bichil ABS Plus SPC" LLC**

1.3. Компанийн оршин байгаа газар:

УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11 -р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга, 705 тоот

Харилцах утасны дугаар: 99119632

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

| Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|
| Бичил глобус финанс ББСБ ХХК | 5729718 | УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11 -р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга, 705 тоот | 99119632 |

1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Компани нь ажилтангүй ба өөрийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тооцоор илэрхийлэгдэх ба түүний боломжит эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани байх бөгөөд эрхлэх цорын ганц үйл ажиллагаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө худалдан авах, автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах болон тухайн худалдан авах үнэт цаас гаргахтай холбоотой буюу тэдгээрийн дагуу хийгдэх энэхүү дүрмийн 2.3-т заасан бусад үйл ажиллагаа байна.

2.2. Компанийн зорилго: Компани нь автомашин барьцаалсан зээлүүдийг багцлан худалдан авч, тэдгээрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан Автомашин барьцаалсан зээлүүдийн төлбөрийг төлөх үүднээс автомашин барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаас гаргана.

2.3. Компани нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС2420

СЗХ 2023.06.02 №01

2.3.1. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах;
2.3.2. Автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
2.3.3. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах болон автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор гэрээ байгуулах;
2.3.4. Баталгаат үнэт цаас гаргах, түүний төлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээ байгуулах;
2.3.5. Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт заасан компанийн аливаа үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
2.3.6. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн эрсдэлийг удирдах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
2.3.7. Мөнгөн хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооноос хориглоогүй санхүүгийн хэрэгсэлд эрсдэл үр өгөөжийг тооцоолж зохистой түвшинг харгалзан байршуулах;
2.3.8. Хууль болон дүрэмд заасан бусад.

2.4. Компани дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

2.4.1. Дүрэмд заасныг өөр үйл ажиллагаа эрхлэх, эсхүл үйл ажиллагаа явуулах;
2.4.2. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;
2.4.3. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дуусаагүй байх үед Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;
2.4.4. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;
2.4.5. Хорооны зөвшөөрөлгүйгээр Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
2.4.6. Үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зардлыг төлөхтэй холбоотой хууль зөрчиж, хөрөнгө оруулагчийн эрх ашигт хохиролтой гэрээ хэлцэл байгуулж, эсхүл зах зээлийн ханшаас өндөр үнэ тогтоох;
2.4.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хэтэлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдах;
2.4.8. Хууль, холбогдох журамд заасан бусад.

## ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БА ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

3.1. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 1,000 (нэг мянга) ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 1,000,000 (нэг сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь СЗХ-ноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрмийн 8.2-р заалтад зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ ПИ ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС2420

## ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

4.1. ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "ХЭХ" гэх/ байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ.

4.2. Компанийн ХЭХ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ шийдвэр гарснаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.

4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.

4.4.1. ТЗК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

4.4.2. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.

4.4.3. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр нөхөн сонгоно.

4.4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.4.1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
4.4.4.2. ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
4.4.4.3. Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,
4.4.4.4. Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
4.4.4.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих,
4.4.4.6. Энэхүү Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах,
4.4.4.7. Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах,
4.4.4.8. Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах,
4.4.4.9. Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах,



СЭХ 2023 06 02 өдөр БҮРТГЭВ № 01
УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ ЭЙ ЭС ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195

4.4.4.10. Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэглийг хэрэгжүүлэх.

4.4.4.11. ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;

4.4.4.12. ТЗК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

4.4.4.13. ТЗК-ийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;

4.4.4.14. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;

4.4.4.15. Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;

4.4.4.16. Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх.

4.4.4.17. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

4.4.5. ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

4.4.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.

4.4.7. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

4.4.8. Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийг төлөөлж аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.

4.4.9. ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

## ТАВ. АУДИТ БА ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

5.1. ТЗК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын шаардлага хангасан хөндлөнгийн санхүүгийн аудиторыг томилж гэрээ байгуулна.

5.2. Хөндлөнгийн аудитор нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа хөндлөнгийн хяналт шалгалт хийх ба өөрийн үйл ажиллагаандаа Аудитын олон улсын стандарт, Аудитын тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон хэрэгжүүлнэ.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ ПАРТНЕРС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163655
9021031195 СТС2420

5.3. Хөндлөнгийн аудитор нь аудитын тайлангийн үр дүнг ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид танилцуулж зохих шийдвэр гаргуулах эрхтэй.

## ЗУРГАА. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. ТЗК нь санхүүгийн жил тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байна.

6.2. ТЗК нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг болон бүртгэлийг хадгалж, хувьцаа эзэмшигч болон хуулиар шаардсан эрх бүхий бусад этгээдэд танилцуулахаар санхүүгийн тайланг бэлтгэнэ.

6.3. ТЗК нь санхүүгийн тайлангаа бүртгэх, хөтлөх, тайлагнахдаа Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлана.

6.4. Компанийн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

## ДОЛОО.КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Автомашины фидуци бүхий зээлийг багцлах болон худалдан авсны үндсэн дээр автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, худалдахтай холбоотой аливаа эрсдэл нь Компани болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч, автомашины фидуци бүхий зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгө оруулагч болон тухайн гэрээний тал болсон бусад этгээд бүртэй байгуулсан гэрээ болон бусад баримт бичгээр зохицуулна.

## НАЙМ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ БА ТАТАН БУУГДАХ АЖИЛЛАГАА

8.1. Энэхүү дүрэм нь компани Санхүүгийн зохицуулах хорооноос Тусгай зориулалтын компани байгуулах зөвшөөрөл олгож, дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.2. ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.

- 8.2.1. Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
- 8.2.2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан;
- 8.2.3. Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;
- 8.2.4. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

8.3. ТЗК-ийг татан буулгах асуудлыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ "БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.....................................

Н.ГАНТУЛГА



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
СЗХ 2023 06 02 №01
УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
126

## 8.4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав

МОНГОЛ УЛС
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

000164688

2013.07.17
/ Бүртгэсэн он сар өдөр /

9015002106
/ Хувийн хэргийн дугаар /

5729718
/ Регистрийн дугаар /

Бичил глобус финанс ББСБ — Банк бус санхүүгийн байгууллага хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол — 379 — 2013.10.23
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

6492 — Зээлийн үйл ажиллагаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / / Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй — 1 — 5,000,000.0
/ хугацаа / / эзэмшигчийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 29-р хороо, москва хороолол, Москва бизнес төв 502, Утас1 99116366, Утас2 , Факс.
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

*Гэрчилгээ дахин олгосон 2018 он 6 сар 22 өдөр*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЭХ 2023.06.09

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Самдан овогтой Отгонбат-н Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв | 2013 11 13 | Ш Цэнэл |
| 2 | Давхар зөрчилгүй олгов | 2018 06 22 | Б Гарьлзул |
| 1 | Жоби-72 ' Улаанбаатар, Баянзүрх, 4-р хороо, ... Жоби 72 төв, 209 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Бүрд салбар' Улаанбаатар, Чингэлтэй, 11-р хороо, , нуур 8, 102 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Хархорин салбар' Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, ... Өнөр хороолол, 43 байр 1 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Хороолол ' Улаанбаатар, Баянгол, 8-р хороо, ... VIP центр, 314 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Дорнод аймаг дахь ' Дорнод, Хэрлэн, 9-р баг, , , 62, 4 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Прован оффис салбар' Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101, 204 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Центр-34 салбар ' Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, ... , Центр -34 оффис, 201 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. Техник импорт салбар ' Улаанбаатар, Баянгол, 5-р хороо, 10-р хороолол, эмэгтэйчүүдийн өргөн чөлөө, Отгонтэнгэр эмнэлэг, 1 давхар, 101 тоот байрлах салбар нээжийг бүртгэв. | 2018 08 31 | С Мөнхсайхан |
| 6 | 6430 Факторингийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2018 09 21 | О Шинэбаяр |
| 3 | 64300 Итгэмжлэлийн үйлчилгээний үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2019.12.13 | Г.Санжав |
| 4 | Улаанбаатар Баянзүрх 15-р хороо **13 хороолол наран 1-1 тоот-д** байрлах салбар нээжийг бүртгэв. | 2020-03-26 | Д Чулуунцэцэг |
| 5 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп, Санкт-Петербург төв 2 давхар 201 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2020.05.28 | Э.Эрдэнэбилэг |
| 9 | Эвсийн зөвлөх 1 ... бүртгэв Улаанбаатар ... 1-р хороо, а4, 18 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2020.05.29 2021.10.29 | Э.Эрдэнэбилэг |
| 7 | Улаанбаатар, Сонгинохайрхан, 32-р хороо, Олон улсын худалдаа Ложистикийн төв, Автоком худалдааны төв, B блок 105 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2021.03.31 | Б Алтансух |
| 8 | Улаанбаатар, Баянзүрх, 17-р хороо, ... , 25 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2021.06.03 | Б Баттөмөр |
| | Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, москвагийн гудамж, 24, Модерн ... ХХК-ийн байр 101 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2021.06.27 | Ш Өлзийсүрэн |
| 11 | Улаанбаатар, Баянзүрх, 13-р хороо, "Эко кар центр" ХХК-ийн байр 01 тоот-д байрлах салбар нээжийг бүртгэв. | 2022.08.17 | Н.Энхцэцэг |
| 12 | Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, гудамж,101 барилгын 705 тоот Утас1: 99119632, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв | 2022.09.20 | Н.Энхцэцэг |

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПИ ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

128

## 8.5. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

**МОНГОЛ УЛСЫН**
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/307

2013 оны 10 сарын 23 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 сарын 23 өдрийн 379 дугаар тогтоолоор

**"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК**

**Банк бус санхүүгийн**

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
"тамга"

С.ДАВААСҮРЭН

*Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй*

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

**МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**[illegible] ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр **"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, цуцалсан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2013.10.23 | №379 тогтоол | |
| 2. | Факторингийн үйлчилгээ | 2018.09.12 | №309 тогтоол | |
| 3. | Итгэлцэл | 2019.12.04 | №340 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

130

"Ул[illegible] ББСБ" ХХК-ийн оноосон нэрийг "Бичил глобус финанс ББСБ" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн, 2017.10.09 №440 тушаал

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Алтан гадас Амины орон сууцны хорооллын урд байрлах 72 м² талбай бүхий оффисийн байр. | | |
| 2. | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол, Москва центр, 502 тоот. | 99119632 | 2013.11.29 №7/4575 албан тоот |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2013.10.23 | №379 | 400,000,000 /анх олгосон/ |
| 2. | 202,800,419 /нэмэгдүүлсэн/ | 2013.11.06 | №305 | 602,800,419 |
| 3. | 279,589,566 /нэмэгдүүлсэн/ | 2017.02.21 | №133 | 882,389,985 |
| 4. | 361,312,715 /нэмэгдүүлсэн/ | 2017.07.17 | №352 | 1,243,702,700 |
| 5. | 3,657,297,300 /нэмэгдүүлсэн/ | 2018.06.04 | №390 | 5,000,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Захирамж гарсан огноо | Захирамж гаргасан шийдвэрийн дугаар, төрөл |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 400,000,000 | 100% | 2013.10.23 | №379 тогтоол |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 602,800,419 | 100% | 2015.11.06 | №305 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 882,389,985 | 100% | 2017.02.21 | №133 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 1,243,702,700 | 100% | 2017.07.17 | №352 тушаал |
| 1. | "Бичил глобус" ХХК | 5388961 | 5,000,000,000 | 100% | 2018.06.04 | №390 тушаал |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Салбар-01 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2017.10.25 | №468 тушаал | |
| 2. | Салбар-02 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 3. | Салбар-03 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 4. | Салбар-04 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 5. | Салбар-05 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 6. | Салбар-06 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 7. | Салбар-07 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 8. | Салбар-08 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг | 2018.08.23 | №485 тушаал | |
| 9. | Салбар-09 | Дорнод аймаг, Хэрлэн сум | 2018.08.23 | №485 тушаал | |
| 10. | Салбар-10 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2020.03.17 | №115 тушаал | |
| 11. | Салбар-11 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг | 2020.05.11 | №167 тушаал | |
| 12. | Салбар-12 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2020.10.02 | №331 тушаал | |
| 13. | Салбар-13 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг | 2021.03.22 | №78 тушаал | |
| 14. | Салбар-14 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2021.05.20 | №123 тушаал | |
| 15. | Салбар-15 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | 2021.06.14 | №152 тушаал | |
| 16. | Салбар-16 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг | 2022.08.03 | №380 тушаал | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15

СЗХ
он сар өдөр
2023 .06. 02
№

## 8.6. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

**БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ХХК**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОГТООЛ**

20 23 он 02 сар 24 өдөр №.. 23/25 а/01 Улаанбаатар хот

**Компани үүсгэн байгуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.2 дэх заалт, 62-р зүйлийн 62.1.16 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бичил Эй Би Эс Плас" гэх оноосон нэртэй хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" ("Компани" гэх)-ийг үүсгэн байгуулсугай.

2. Компанийн оршин байх газар буюу хууль ёсны хаяг нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 705 тоот, утасны дугаар 99119632 байхаар тооцон "Бичил глобус" ХХК-тай оффис түрээслэх түрээсийн гэрээ байгуулсугай.

3. Компани үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь 1,000,000 /нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 /нэг мянга/ ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааг гаргахаар шийдвэрлэсүгэй.

4. Компани нь хугацаагүйгээр, дараах үйл ажиллагаа явуулсугай. Үүнд:
   - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

5. Компанийн дүрмийг 1-р хавсралтаар батлсугай.

6. Компанийн Гүйцэтгэх захирал Монгол Улсын иргэн (РД:ИЭ84082978) Самдангийн Отгонботыг томилсугай.

7. Шинээр үүсгэн байгуулж буй компанийн холбогдох баримт бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэхийг "Бичил глобус финанс ББСБ" ХХК-ийн Бичиг хэргийн мэргэжилтэн (Н.Золжаргал)-д үүрэг болгосугай.

"БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ Б.ХҮРЭЛХҮҮ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ С.ОТГОНБАТ

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

## 8.7. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛС

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

000236781

2021.09.16
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011831586
/ Хувийн хэргийн дугаар /

2870657
/ Регистрийн дугаар /

Юнайтед айр файнэнс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| | | |
|---|---|---|
| Шийдвэр | 01 | 2005.01.27 |
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
/ Код/ / Үйл ажиллагааны чиглэл /

| | | |
|---|---|---|
| Хугацаагүй | 1 | 50,000.00 |
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот, Утас1: 80808888, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ Э БАТОЧИР
/ ... / / ...рын үсэг/

2023-06-15
СЗХ 2023.06.07 № 01
УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123
БИЧИГ ЭЙ БИ ЭС ... ТЗК ХХК ATA9998 6999131 9023050164
УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
... STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
он 2023 сар 06 өдөр 07
БҮРТГЭВ
№ 01

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Хурал овогтой Мөрөөдөрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.09.16 | [illegible] |
| 2 | 46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа /2021.10.28-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.11.09 | Т.Зулзаяа |
| 3 | 68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 66110 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2022.04.19 | Т.Зулзаяа |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000236781
УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ... ТЭК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183858
9021031195 СТС2420

## 8.8. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 316/18

2021 оны 10 сарын 28 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 28 өдрийн 473 дугаар тогтоолоор "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК -д ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН
"Тамга"

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

## 8.9. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ

БАТЛАВ:
"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЭК" ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Н.ГАНТУЛГА

БАТЛАВ:
"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.МАРГАДЭРДЭНЭ

**ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ**

2023 оны 05-р сарын 03-ны өдөр

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЭК" ХХК**

**болон**

**"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК**

Гэрээний дугаар: 23/611

УЛААНБААТАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
2023.06.02
ТЭ В
№ 01

Энэхүү ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийн үүс тус тус үндэслэл болгон сайн дурын үндсэн дээр 2023 оны 05 дугаар сарын 03 өдөр доор дурдсан талууд

Нэг талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 байрны 705 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6999131 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 04 сарын 21-ний өдрийн № 118 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй **"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" эсхүл "ТЗК" гэх)**, түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Н.Гантулга

Нөгөө талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 2870657 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 сарын 28-ны өдөр № 473 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй **"Юнайтед Айр Файнэнс" ХХК (цаашид "Хөрөнгө итгэмжлэн удирдагч" гэх)**, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ

дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1. Энэхүү гэрээний зорилго нь ТЗК Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлоход оршино.
2. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, Гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог туушгай хадгалах, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг хууль болон гэрээнд заасныг гадуур, эрх бусаар захиран зарцуулах, ашиглахгүй бөгөөд гагцхүү гэрээгээр тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд ажиллах зарчмыг баримтална.
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үйл ажиллагаанд энэхүү гэрээ болон ТЗК-ийн батлан мөрдөж буй дараах журмуудын холбогдох зохицуулалтыг энэхүү гэрээнд нийцүүлэн даган мөрдөнө. Үүнд:
    - 4.1 Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөндлөнгийн аудиторыг сонгох солих журам;
    - 4.2 Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
    - 4.3 Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
    - 4.4 Үнэт цаас эзэмшигчид мэдээлэл хүргүүлэх журам;
    - 4.5 Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;
    - 4.6 Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
5. Энэхүү Гэрээний үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд Талууд өөрөөс шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана.
6. Хэрэв Гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дараах дарааллын дагуу ...

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6163855
9021031195 СТС2420

холбогдол бүхий шийдвэрлэнэ.

6.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль;
6.2. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам;
6.3. Монголын Хөрөнгийн биржийн журам;
6.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
6.5. ТЗК-аас баталсан бүх дүрэм, журмууд.

7. Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, и-мэйл, утсаар харилцана.

| Үнэт цаас гаргагчийг төлөөлж: | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг төлөөлж: |
|---|---|
| "БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК " ХХК-ИЙН | "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК-ИЙН |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Н.ГАНТУЯА | ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.МАРГАД-ЭРДЭНЭ |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
STOCK EXCHANGE
2023-06-15
ГЭВ-02
СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**1. Нэр томъёо**

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

1.1.1. **"Анхны үүрэг гүйцэтгүүлэгч"** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хувьд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК байна.

1.1.2. **"Үйлчилгээ үзүүлэгч"** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хувьд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК байна.

1.1.3. **"Зээлдэгч"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн хүү болон үндсэн төлбөрийг зээлийн гэрээний дагуу буцаан төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг;

1.1.4. **"Зээл"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу зээл олгохыг;

1.1.5. **"Зээлийн данс бүртгэл"** гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;

1.1.6. **"Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах"** Багцын хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, буцаан худалдахыг;

1.1.7. **"Зээлийн эргэн төлөлт"** гэж Зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан хуваарьт үндсэн болон хүүгийн төлбөрийг;

1.1.8. **"Төлбөр цуглуулах данс"** гэж ТЗК-ийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам"-ын 2.2.1-д заасан данс болох бөгөөд Цугларсан төлбөрийг хүлээн авах Голомт банканд нээсэн 3305139985 дансыг;

1.1.9. **"Тасалбар болох огноо"** гэж "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам" 4.4.1 дэх хэсэгт заасан ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах эзэмшигчдийн жагсаалтыг авсан өдрийг;

1.1.10. **"Багцын эргэн төлөлт"** гэж Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу шилжүүлж буй зээлийн эргэн төлөлтийг;

1.1.11. **"Цугларсан төлбөр"** гэж Төлбөр цуглуулах дансанд цугларсан мөнгөн дүнг;

1.1.12. **"ҮЦТХТ"** гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийг.

**2. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ**

2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээг үзүүлнэ.

2.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно.

**3. Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах**

3.1. Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих:

3.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтын дагуу компанийн нэрийн

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
9023050164
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195
СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

өмнөөс өөрийн програм хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;

3.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцоо, хөрөнгийн бүртгэлээс тусад нь бүртгэх, хөтлөх;

3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;

3.1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах, Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага хүргүүлэх;

3.1.5. Зээлийн багцтай холбоотой бичиг баримт, мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нараас шаардан авах эрхтэй;

3.1.6. ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх.

3.2. Багцын хөрөнгөд дараах байдлаар өөрчлөлт оруулна.

3.2.1. Багцын хөрөнгийг солих;

3.2.2. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;

3.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

3.3. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож хөрөнгийг солино. Үүнд:

3.3.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Компаниас үзсэн;

3.3.2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;

3.3.3. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;

3.3.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон.

3.4. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

3.4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;

3.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Компани нь нэмэлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;

3.4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС
ТЗ ХХК



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

3.5. Багц дахь хөрөнгөд доор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.

3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;

3.5.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувьд зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоног хэтэрсэн, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;

3.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.1.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

3.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс багц дахь зээлийн эргэн төлөлт болон Үйлчилгээ үзүүлэгчийн сарын тайланд үндэслэн хянан баталгаажуулалт хийж энэхүү гэрээний 3.3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг солихтой холбоотойгоор дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.6.1. Анхны үүрэг гүйцэтгэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн програмд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно.

3.6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлсэн орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэр дүнгээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж, барагдуулна.

3.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү гэрээний 3.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид дараах байдлаар мэдээлж, хөрөнгийг нэмэгдүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

3.7.1. Багц дахь зээлүүдийн төлөлтийн мэдээлэлд үндэслэн сард 1 удаа багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт"-ыг авч харилцан тохирно.

3.7.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн програмд оруулж холбогдох актыг үйлдэж, тооцоог хийснээр хөрөнгийн багцыг нэмэгдүүлж бүртгэсэнд тооцно.

3.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү гэрээний 3.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид дараах байдлаар мэдээлж, багцыг буцаан худалдах ажиллагааг гүйцэтгэнэ.

3.8.1. Гэрээний 3.5.1-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах актыг үйлдэж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ.

3.8.2. Гэрээний 3.5.2, 3.5.3-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийн үлдэгдлийг гаргаж ТЗК-ийн ТУЗ-д танилцуулж буцаан худалдах эсэхийг шийдвэрлүүлнэ.

3.8.3. Гэрээний 3.8.2-д заасны дагуу багцыг буцаан худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТЗК нь буцаан худалдах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.

3.8.4. Гэрээний 3.8.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай Хөрөнгийн багцыг буцаан худалдах гэрээг байгуулж, холбогдох төлбөрийг төлнө.

3.9. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ гэрээний 3.2-д заасан нөхцөлийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг гүйцэтгүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шууд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.10. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасан багцад өөрчлөлт оруулахтай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллана.

3.11. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 11.3, 11.4-д заасан мэдээлэл, тайланг тус журамд заасан хугацаанд хүргүүлнэ.

4. **Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх**

4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээнд заасны дагуу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг Зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна.

4.2. ТЗК-н төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөс зарлага гаргахтай холбоотой эрхийг ТЗК болон Захиргааны үйлчилгээ үзүүлэх этгээдтэй байгуулсан гэрээгээр зохицуулах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гүйлгээнд зөвшөөрөл олгох, төлбөр цуглуулах дансны зарлагын гүйлгээнд хяналт тавина.

4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийг төлөөлөн ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах бөгөөд Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс авч, ХБҮЦ-ны төлбөрийн тооцооллыг хийж ҮЦТХТ-д хүргүүлнэ.

4.4. ТЗК нь ҮЦТХТ-тэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулах бөгөөд "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасны дагуу тухай бүр холбогдох төлбөрийг ҮЦТХТ-ийн дансанд байршуулна.

4.5. ТЗК нь ҮЦТХТ-өөс үүсгэн байгуулагчийн дансанд ХБҮЦ борлуулсны орлого орж ирсэн өдрөөс Хүүгийн төлбөрийг улирал тутамд, үндсэн төлбөрийг жил тутамд төлнө.

4.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөрийн тооцоог гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ-д шилжүүлж, ТЗК нь үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.

4.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарь, үнийн дүнгийн тооцооллыг алдсан, үнэт цаас эзэмшигчийн мэдээллийг буруу бичсэн зэрэг төлбөр тооцоотой алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан алдаанаас болж үнэт цаас эзэмшигч, компани болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

4.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн

дотор "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ.

4.9. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор ХБҮЦ эзэмшигчдийн жагсаалт, эзэмшиж буй нэгж ХБҮЦ-ны тоо, ХБҮЦ эзэмшигчид төлөгдсөн төлбөр, татвар төлсөн дүн зэрэг мэдээллийг ТЗК-ийн ТУЗ-д танилцуулна.

**5. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт**

5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах данс дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр дараах зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно. Үүнд:

5.1.1. Арилжааны банкны хадгаламжид байршуулах;

5.1.2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкаас гаргасан үнэт цаасыг худалдан авах;

5.1.3. Зохицуулагч байгууллагаас хориглоогүй аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах.

5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн шийдвэрийн дагуу 5.1-т заасан зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын гүйлгээг ТЗК хийнэ. Тус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

5.3. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийх үед эрсдэл үүсэхээр бол зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

5.4. ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарьт өдрөөс ахлын хоёр (2)-оос доошгүй өдрийн өмнө дууссан байхаар тохируулсан байна.

**6. Баталгаа**

6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний хугацаанд дараах баталгааг ТЗК болон ХБҮЦ эзэмшигч нарт гаргаж байна. Үүнд:

6.1.1. ХБҮЦ эзэмшигчийн эрх ашгийг тэргүүн ээлжид хамгаалж ажиллах;

6.1.2. Хөрөнгийн багцыг зохистой удирдах болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэхээс өөрөөр итгэмжилсэн хөрөнгийг ашиглахгүй, мэдээллийг тухай бүр үнэн зөвөөр ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий байгууллага болон ТЗК-ийн ТУЗ-д тайлагнаж ажиллах;

6.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх холбогдох зөвшөөрлийг авсан болно;

6.1.4. ТЗК-ийн хөрөнгийг өөрийн компанийн хөрөнгөөс тусад нь бүртгэх;

6.1.5. ТЗК-д энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлсэн бөгөөд харилцан ажиллах мэргэжлийн, ёс зүйтэй мэргэжилтнийг томилон ажиллуулах;

6.1.6. ТЗК болон ХБҮЦ эзэмшигчийн эрх ашигт харш, тэдгээрийг хохироосон аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

6.1.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсхүл түүнээс томилсон ажилтны буруутай үйлдлийн улмаас ТЗК, ХБҮЦ эзэмшигч нарт шууд болон шууд бус хохирол учруулсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.

**7. Үйлчилгээний хөлс**

7.1. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн энэхүү гэрээний хавсралт №1-д заасан хуваарийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн

Худалдаа хөгжлийн банкны 499358818 тоот дансанд төлнө. Төлбөр төлөх өдөр нь амралтын өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ.

7.2. Үйлчилгээний хөлсөнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар багтсан бөгөөд хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч тайлагнана.

7.3. ТЗК нь Гэрээний 7.1-т заасан хугацаанд үйлчилгээний хөлсийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоногийн 0.1 хувийн алданги тооцно.

7.4. ТЗК нь үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хугацаанаас өмнө урьдчилан төлж дуусгасан эсхүл Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-т заасан нөхцөл үүсээгүй байхад Үнэт цаас гаргагчийн саналаар гэрээг үндэслэлгүйгээр цуцалсан тохиолдолд үлдэх хугацаанд хамаарах гэрээний Хавсралт №1-т тусгасан үйлчилгээний хөлсийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид 1 (нэг) удаа бөөн дүнгээр төлнө.

8. **Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Энэхүү гэрээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалах зөвшөөрөл олгосноор талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээг 6 хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, СЗХ, МХБирж, Андеррайтерт хадгалуулна.

9. **Гэрээний хугацаа**

9.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

9.2. ХБҮЦ-ны хугацаа дуусахаас өмнө Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг буцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгох болно.

10. **Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал**

10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хөл хорио гэх мэт) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.

10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол иргэдүйд үг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

11. **Гэрээнд ашиглах хэл**

11.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

12. **Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

12.1. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцөнө.

12.2. Талууд харилцан зөвшилцсөн гэрээний нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрөл авснаар нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр байгуулж, талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

12.3. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний нэгэн адил үйлчилнэ.

## 13. Эрх залгамжлах болон гэрээний үүргийг шилжүүлэх

13.1. Энэхүү Гэрээ нь Талуудын холбогдох эрх залгамжлагчид мөн адил үйлчилнэ.

13.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан "эрх хүлээн авагч" нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, тусгай зориулалтын компанийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг зэргийг хүлээн авч Үнэт цаас гаргагчийн эрх залгамжлагчаар тооцогдоно.

13.3. Хууль ёсны эрх залгамжлагчдаас бусад этгээдэд үүргийг шилжүүлэхийг хориглоно.

13.4. Дээрх тохиолдолд энэхүү гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр байна.

## 14. Гэрээний нууцлал

14.1. Нийтэд ил болгосон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээллээс бусад мэдээллийг нууц мэдээлэл гэнэ.

14.2. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

14.3. Нууц мэдээллийг талууд гэрээ цуцлагдсан эсхүл дуусгавар болсон өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална.

14.4. Дээрх тохиолдолд нууц мэдээллийг задруулсан тал нөгөө талдаа учруулсан хохирлыг барагдуулах буюу хариуцлага хүлээнэ.

## 15. Хүчингүй заалтууд

15.1. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол:

15.1.1. Тус заалт нь бүрэн салгах боломжтой;

15.1.2. Тус хууль бус, хүчингүй болон хэрэгжих боломжгүй заалт нь өмнө энэхүү гэрээний заалт байгаагүйд тооцогдох бол;

15.1.3. Гэрээний бусад заалтууд хүчинтэй хэвээр байх бөгөөд тус хүчингүй, хууль бус болон хэрэгжих боломжгүй заалт нь ямар нэг байдлаар гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

## 16. Гэрээний нэгдмэл байдал

16.1. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйлтэй холбоотой асуудлаар өмнө нь хэлэлцэгдэж байсан хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичиг, урьдчилсан нөхцөлүүд, Гэрээ болон бусад хэлэлцээр (Бичгээр болон амаар хийгдсэнээс үл хамааран бүх харилцаа холбоог үүнд хамааруулна) байгаа бол тэдгээрийг энэхүү Гэрээ бусад хэлэлцээрийн баримт бичгийн хамт орлох бөгөөд энэхүү Гэрээ нь (аливаа нэмэлт өөрчлөлт болон

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ... ТЭК ХХК
АТА9998 6999131
9023050164

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 оны 06 сарын 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих**

1.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой эсхүл үүргээ биелүүлэх чадваргүй болсон, дампуурах нөхцөл байдал бий болсон, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүсэн тохиолдолд Гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцална.

1.2. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журамд заасан үндэслэлээр солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан ХБҮЦ-ны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.

1.3. Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.

1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шинээр томилогдсон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажил хүлээлцэх актын дагуу ТЗК-тай холбоотой эзэмшиж байсан бүхий л мэдээлэл, баримт бичиг, данс тооцоо, бэлэн мөнгө, тайлант баримтаар болон цахимаар ямар нэгэн шилжүүлэгүйгээр хүлээлгэн өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно.

2. **Гэрээний үүрэг зөрчсөнд тооцох**

2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.1. Энэхүү гэрээнд заасан Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй;

2.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсны дагуу гүйцэтгээгүйн улмаас ХБҮЦ эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бус хохирол учирсан;

2.1.3. Хөрөнгийн багцыг буруу удирдсан буюу хөрөнгийн багцад зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ны төлбөр хуримтлагдахгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон;

2.1.4. ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.

2.2. ТЗК-ийг дараах тохиолдолд зөрчил гаргасан тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.

2.2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ ПИ ЭС ПИ ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
12
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK
2023 -06- 15
БҮРТГЭЛ 02

СЗХ
2023 .06. 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2.3. Гэрээний үүрэг зөрчсөний хариуцлага.

2.3.1. Зөрчил гаргасан тал нь уг зөрчилтэй холбоотой нөгөө талд учирсан хохирлыг шууд болон шууд бус хохирлыг төлөх үүргийг хүлээнэ.

2.3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн буруутай үйл ажиллагаанаас хамааран ХБҮЦ-ны төлбөрийг хоцроосон бол хоцроосон өдрөөр тооцон ХБҮЦ эзэмшигчид холбогдох хүүг нэмж төлөх үүргийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

3. **Эрх шилжүүлэх**

3.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай туслалцаа авах зорилгоор туслах этгээдийг томилон ажиллуулах боломжтой. Энэ тохиолдолд туслах этгээдийн мэдээлэл, гүйцэтгүүлэх ажлыг урьдчилан ТЗК-д мэдэгдсэн байна.

3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үзүүлэх үйлчилгээтэй холбоотой туслах этгээд ажиллуулахтай холбоотой зардлыг дангаараа хариуцна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Нэр: Н.Гантулга

Албан тушаал: ТУЗ-ийн дарга

Гарын үсэг: ____________

**"ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Нэр: Х.Маргад-Эрдэнэ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ____________

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
9021031195 СТС2420

13

## 8.11. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ

Сонгогдсон зээлүүдэд
гүйцэтгэсэн харилцан тохиролцсон
ажил үйлчилгээний

**үр дүнгийн тайлан**

2023 -06- 15
БҮРТГЭЛ-02
СЗХ
2023.06.02
№ 01
УЛААНБААТАР ХОТ
АТА9998 6999131
9023050164
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС242

Үнэт цаасны танилцуулга

Onch& Company

2023 -06- 15 БҮРТГЭВ-02

СЗХ 2023 .06. 02 БҮРТГЭЛ № 01

## ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**Бичил Глобус Финанс ББСБ ХХК-д,**

он сар өдөр
№ 01

гэрээний дагуу тээврийн хэрэгсэл буюу автомашин нь тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн эсэх, мөнгөн төлбөрийн үүрэг болон фидуцийн зүйлийг шаардах эрх нь аливаа үүргээс ангид байсан эсэхийг нягтлан шалгалаа.

Бичил Глобус Финанс ББСБ-ын үндсэн зээлдэгч болон хамтран зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээг талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан эх хувь, фидуцийн зүйлийн өмчлөгчөөр бүртгэгдсэн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар хувийг шалгасан. Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашины өмчлөх эрхийг Зээлдүүлэгчид шилжүүлж, автомашины эзэмших, ашиглах эрх Зээлдэгчид байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зорчлын тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8[1]-д зааснаар механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх ба тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад баримт бичигтэйгээр тээврийн хэрэгслийг жолоодохоор заажээ. Ийнхүү тус хууль тогтоомжийн дагуу Бичил Глобус Финанс ББСБ-д тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар хувь нь хадгалагдаж байх тул эх хувийг хуулийн хөндлөнгийн шинжээчид үзүүлэх боломжгүй байна.

Бид зээлийн хувийн хэргийн материалыг шалгахад Бичил Глобус Финанс ББСБ нь сонгогдсон 53 зээлийн дансны тээврийн хэрэгсэл (автомашин)-ийн гэрчилгээний хуулбарт өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.

Тээврийн хэрэгслийн гэрчилгээ (хуулбар хувь)-г бүртгэгчийн тамга, тэмдэглэгээгээр гэрчилснээс үзвэл бүртгэлийн байгууллага бүртгэж, баталгаажуулан, фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь зохих ёсоор бүртгэгдэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Бичил Глобус Финанс ББСБ-д олгогдсон байна.

Авто тээврийн тухай хуулийн 17.1[2], Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д зааснаар бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээг авто тээврийн асуудал эрхэлсэн бүртгэлийн байгууллагаас олгосон байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д "*Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна*", мөн хуулийн 21.4-д "*Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно*", Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар "*техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй бол авто тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана*" гэж тус тус заасны дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь хуульд заасан техникийн хяналтын үзлэг, оношилгоонд хамрагдсан гэж үзлээ. Мөн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.9-т тус тус зааснаар авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлж барагдуулаагүй, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзахаар зохицуулсан тул тээврийн хэрэгсэлтэй холбоотой албан татвар, торгууль байхгүй, эсхүл бүрэн төлөгдсөний дараа тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн гэж үзэв.

Иймд дүн шинжилгээ хийх явцад зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан материал, Бичил Глобус Финанс ББСБ-ын өгсөн нэмэлт мэдээллийн дагуу зээлийн дансыг бусад гуравдагч этгээдэд худалдах, уг зээлийн мөнгөн хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөрийн шаардах эрх, фидуцийн зүйлийн шаардлагыг бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлд тавьсан нөхцөл байдал илрээгүй учир сонгогдсон зээлийн дансдын фидуцийн зүйл

[1] Зорчлын тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8. Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
[2] Авто тээврийн тухай хуулийн 17.1 Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн туршид техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПАРТ ТЗ ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАНИАНС ХХК
5183855
9021031195 СТС2420

болох автомашин нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх шалгуур хангагдаж байна гэж дүгнэлээ.

МДСХ-ийн санамсаргүй түүврээр сонгогдсон 53 зээлийн дансанд хамаарах автомашины зээл нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бичил Глобус Финанс ББСБ-ын бүрэн өмчлөлд байгаа бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байна гэж үзлээ.

**Шалгуур үзүүлэлт 2.** Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бичил Глобус Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн эсэх, хүчин төгөлдөр эсэх, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардлагатай тохиолдолд фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслээс гаргуулан төлүүлэх нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Нийт дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансдын хувьд Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид "БЭБХЭМХМХШЗҮАтХ" гэх)-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, 20.2.8[3]-д заасан "*зээлийн дансны дугаар*", "*зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл*" "*оршин байгаа хаяг*" нь зээлийн гэрээнд тусгагдаагүй байсан бөгөөд "Холбогдолтой шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт"-д зарим нөхцөл тусгагдаагүй байж болох тухай заасны дагуу бид эрсдэлтэй зээлийн дансдын тоонд оруулаагүй болно. МДСХ нь зээлийн гэрээнд тусгасан байх ёстой нөхцөлүүдийг бүрэн тусгах зөвлөмжийг энэхүү Тайлангийн зөвлөмж хэсэгт тусгасныг анхаарах шаардлагатай байна.

Энэхүү дурдсан 3 нөхцөлөөс бусад зээлийн гэрээнд тусгасан байх хуульд заасан нөхцөлийг зээлийн гэрээндээ тусгасан, зээлийн гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд зээлдүүлэгч болон хамтран зээлдэгч нар гарын үсэг зурсан нь Иргэний хуулийн 42.2, 451.2 дугаар зүйл, БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19.3 болон 20 дугаар зүйлд тус тус тодорхойлсон шаардлагыг хангасан байна (Тайлангийн зөвлөмж хэсгийг харна уу).

Бичил Глобус Финанс ББСБ-аас зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд, эсхүл гэрээгээр тохиролцсон, тусгайлан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гуравдагч этгээдийн дансанд шилжүүлсэн нь БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19.5-д "*Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно*" гэж заасанд нийцэх үндэслэлтэй тул зээл олголт нь хуулийн хүчин төгөлдөр болно.

Түүнчлэн зээлийн гэрээ нь Бичил Глобус Финанс ББСБ-аас зээлдэгчид санал болгож байгаа, хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх шинжтэй, урьдчилан тогтоосон нөхцөл болохын хувьд Иргэний хуулийн 200 дугаар зүйлд заасан гэрээний стандарт нөхцөл болно. Гэрээний зохицуулалтаас харвал, зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 202 дугаар зүйлд заасан гэрээний стандарт нөхцөлийг хүчин төгөлдөр бусад тооцох зохицуулалт агуулаагүй байна.

Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлийн гэрээний 1.2[4]-т зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх тухай дурдсан байх тул зээлийг фидуцийн хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байна.

**Иймд,** сонгогдсон нийт 53 зээлийн дансны тээврийн хэрэгсэл/автомашин худалдан авах зориулалтаар зээл олгох хэлцэл нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин

[3] БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20.2 Зээлийн гэрээнд заавал тусгах зүйлийг тусгасан байна. 20.2.3 зээлийн дансны дугаар, 20.2.6 зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл, 20.2.8 зээлийн гэрээнд оролцогч талуудын оршин байгаа, оршин суугаа хаяг
[4] Зээлийн гэрээний 1.2.4 гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор барьцаа хөрөнгө болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг Зээлдүүлэгч, хамтран зээлдэгчийн төлөөлөгч рүү шилжүүлнэ

тохиолдол, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд зээлийн гэрээ нь хоёрдугаар шалгуур үзүүлэлтийг хангаж байна гэж үзлээ.

**Шалгуур үзүүлэлт 3.** Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь түүврийн аргаар сонгосон 53 зээлийн дансдын хувьд зээлийн гэрээ, фидуцийн гэрээнд тусгагдсан үүрэг хугацаанаас өмнө дуусгавар болох, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах нөхцөлүүд болон үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай хүсэл зориг илэрхийлсэн эсэх талаар шалгаж үзлээ.

БЭБХЭМХМХШЗУАтХ-ийн 25.1-д зааснаар зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэж болно. Зээлийн гэрээнд зээлийг хугацаанаас нь өмнө буцаан төлөх талаар зохицуулалт тусгаагүй байгаа боловч зээлдэгч нь хуульд заасны дагуу зээлийн гэрээний төлбөрийг урьдчилан төлөх эрхтэй болохыг дурдаж байна.

Тайлан гаргах өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр сонгогдсон 53 зээлийн дансдын зээл олгох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

**Шалгуур үзүүлэлт 4.** Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуци болон зээлийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хууль болон гэрээгээр хориглосон, хязгаарласан нөхцөл байгаа эсэх, фидуцийн зүйл хамтран өмчлөгчтэй тохиолдолд хамтран өмчлөгчийн зөвшөөрөл байгаа эсэх, хамтран өмчлөгч фидуцийн гэрээнд гарын үсэг зурсан эсэх зэрэг асуудлыг шалган үзлээ.

Бичил Глобус Финанс ББСБ нь зээлдүүлэгч зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглоогүй, аливаа байдлаар хязгаарласан талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна. Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна. Зээлийн гэрээнд энэхүү эрхийг хязгаарласан аливаа зохицуулалт ороогүй болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшигч болохыг дурдахын тэргүүнд дүн шинжилгээнд хамрагдсан 53 зээлийн дансдаас 53 зээлийн дансдын хувьд автомашины зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглоогүй, эсхүл хязгаарлаагүй байх шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв. Түүнчлэн фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашины цорын ганц өмчлөгч нь Зээлдүүлэгч (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) байх ба фидуцийн зүйлтэй холбоотой хамтран өмчлөгчийн эрх байхгүй болохыг бид шалгасан болно. Иймд, зээл төлүүлэх зорилгоор автомашиныг барьцаалуулах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхийг фидуцийн гэрээний дагуу түүнийг өмчилж буй Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эдэлнэ. Харин эзэмших, ашиглах эрхийг өөр этгээд хэрэгжүүлж байгаа нь ажиллагааны шуурхай байдалд нөлөөлж болох талтайг дурдах нь зүйтэй.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

**Шалгуур үзүүлэлт 5.** Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, түүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бичил Глобус Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан фидуцийн гэрээ нь хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн эсэх, хүчин төгөлдөр эсэх, хуульд заасны дагуу, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн эрх нь үүргийн гүйцэтгэлээр хангах аргаар баталгаажсан бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжид шаардлага хангуулах боломжтой эсэх, зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Тайлангийн шалгуур 2-т дурдсанчлан түүврийн аргаар сонгосон зээлүүдийн зээлийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр байна. Зээлдэгч зохих ёсоор үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн гэрээ болон фидуцийн гэрээгээр зохицуулсан байна. Иймд талууд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Иргэний хуулийн 235.5-д *"хуульд өөрөөр заагаагүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ"* гэж заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн эрхийг баталгаажуулсан гэрээг зээлдэгчтэй бичгээр байгуулсан нь фидуцийн гэрээний хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Бичил Глобус Финанс ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журмын 9.1-д заасны дагуу зээлдэгч нь зээлийн гэрээг биечлэн байгуулах бөгөөд итгэмжлэлийн үндсэн дээр гэрээ байгуулахыг хориглосон дотоод дүрэм журам тогтоон мөрддөг байна. Сонгогдсон 53 зээлийн дансад итгэмжлэлээр төлөөлүүлж гэрээг байгуулсан тохиолдол гараагүй тул хуульд заасан төлөөлөх, төлөөлүүлэх харилцаа үүсээгүй болно.

Фидуцийн гэрээний 1.9-т *"Энэхүү гэрээний 1.7-д заасан мэдэгдлийг авснаас хойш Зээлдэгч нь зээл төлөх хэмжээгээр үйлдэл хийгээгүй бол мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа ... хөрөнгийг бусдад худалдах, болон бусад хэлбэрээр борлуулж хохирлоо барагдуулна"* гэж зохицуулснаас үзвэл, фидуцийн эрх нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн зээлийг фидуцийн зүйл болох автомашиныг худалдан борлуулж төлүүлэх боломжтой байх шалгуурыг хангаж байна (Тайлангийн Зөвлөмж хэсгийг харна уу).

Мөн Иргэний хуулийн 235.1[5]. Фидуцийн гэрээний 1.4-т *"Барьцаалагчийн зөвшөөрөлгүй, зээл хаагдаагүй байхад Барьцаалуулагч нь барьцаа болох хөдлөх хөрөнгийн эзэмшил ашиглалтыг, өмчлөх эрхийг хууль бусаар гуравдагч этгээдэд шилжүүлэх, бусдад дамжуулах худалдах, барьцаалахыг хориглоно"* гэж зохицуулснаас үзвэл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн өмчлөгч бөгөөд зээлдэгч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр фидуцийн хөрөнгийг бусад үүргийн гүйцэтгэл хангуулахаар худалдах, барьцаалах зэргээр захиран зарцуулах боломжгүй тул зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг давуу буюу тэргүүн ээлжид фидуцийн эрхээр хангуулахаар талууд тохиролцсон гэж үзнэ.

Иймд, Бичил Глобус Финанс ББСБ-ын фидуцийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг фидуцийн эрхээр гаргуулах боломжтой байна.

**Шалгуур үзүүлэлт 6.** Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зээлийг ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу олгосон эсэх, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх

[5] Иргэний хуулийн 235.1. Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр /цаашид "фидуци" гэх/ үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ПЛЮС ПИ ТЭК ХХК
АТА9998 / 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

2023-06-15
БҮРТГЭВ-02

баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа.

МДСХ нь сонгогдсон зээлийн дансдыг шалгах явцад Бичил Глобус Финанс ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн шимтгэлийг зарим тохиолдолд суутган авах, зарим тохиолдолд суутгалгүйгээр хүлээн авсан зэрэг ялгаатай байдал илэрсэн болно. "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 6-р сарын 17-ны өдрийн 22/04а/52 тоот тушаалаар зээлийн шимтгэлийг зээл олголтын дүнгээс суутган төлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн ба тус тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацааны зээлийн хувьд зээлийн шимтгэлийг зээлийн төлбөрөөс суутган тооцож болно. Түүнчлэн "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 3-р сарын 10-ны өдрийн 20/04а/22 тоот тушаалаар дэлхий нийтээр дэлгэрч буй коронавирусын дэгдэлттэй холбоотойгоор 2020 оны 3-р сарын 09-ний өдрөөс эхлэн "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь зээлийн шимтгэл, хураамжийг түр хугацаанд зогсоож шийдвэрлэсэн бөгөөд салбар, салбарын онцлогоос хамаарч ялгаатай хугацаанд зээлийн шимтгэлийг тооцоогүй байна. Хэдийгээр Зээлийн үйл ажиллагааны журмын шимтгэлтэй холбоотой нөхцөлд өөрчлөлт оруулаагүй боловч зээлийн үйл ажиллагааны журам батлах эрх бүхий субъект нь өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байх тул дурдсан тушаалыг үндэслэл болгон шалгасан болно.

Түүнчлэн Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн хорооны шийдвэр гарах нөхцөл, журам буюу зээлийн хорооны шийдвэрээр шийдвэрлэх зээлийн үнийн дүнгийн хэмжээг Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 02-р сарын 14-ний өдрийн 22/04а/19 тоот тушаалаар өөрчлөлт оруулан шийдвэрлэснийг мөн дээр дурдсантай адил удирдлага болгон зээлийн дансдыг шалгасан болно.

Бичил Глобус Финанс ББСБ-ын сонгогдсон 53 зээл нь зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор дотоодод дагаж мөрддөг журмын дагуу олгогдсон, фидуцийн хөрөнгө нь фидуцийн хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой дотоодод дагаж мөрддөг журмын дагуу тодорхойлогдож, шаардлага хангасан байна.

Шалгуур 1-т дурдсаны дагуу зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь эх хувиар, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хуулбараар хувийн хэрэгт хадгалагдаж байв. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшиж, ашиглаж байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эзэмшил, хадгалалтад эх хувиар байлгадаггүй нь Автотээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д заасны хууль зүйн үндэслэлтэй, хуулбарыг хувийн хэрэгт хадгалдаг байна. Ийнхүү үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй дээр дурдсан баримт бичгийн эх хувь, эсхүл хуулбар хувь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалтад хамгаалалтад байна гэж үзлээ.

**Нэгдсэн дүгнэлт**

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нийт 53 зээлийн дансны хувьд Дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр, аливаа эрсдэл үүсээгүй байна.

Зээлийн болон фидуцийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийн зүйл (фидуци)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болно.

Энэхүү Тайлангийн Хавсралт 2-т заасан Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын шинжилгээний явцад анхаарах, банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалтад заасны дагуу бид тус зөрүүтэй зохицуулалтыг илрүүлсэн хэдий ч хүлээн зөвшөөрсөн бөгөөд дүн шинжилгээ хийх явцад гарсан алдаа, зөрчлийг тухай бүр засуулсан болно.

1. **Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан дансууд.**



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БЭ ЭС ПИ ТЭ ХХК
АТА9999 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5163855
9021031195 СТС2420

192

Энэ ангилалд багтсан нийт данс Үнэт цаас гаргагчаас тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан (Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус) бөгөөд Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр байгаа утгыг илэрхийлнэ. Энд гарсан алдаа нь эрх зүйн эрсдэл үүсгэхгүй, хууль тогтоомжоор заасан шаардлага зөрчөөгүй зээлийг ойлгоно. Гэвч энд зарим эрсдэл болох тухайн зээл авахад шаардлага хангаж байсан боловч хөндлөнгийн дүн шинжилгээ хийх үед өөрчлөгдсөн нөхцөл байдал орж байгаа болно. Тухайлбал, зээл авах үед ажил эрхлэлт, тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ нь хүчинтэй байсан боловч энэхүү тайлан гаргах өдрийн байдлаар хугацаа нь дууссан байх магадлалтай зээлийн данс орсон байж болно.

**2. Эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай данс.**

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай зээлийн данс илрээгүй болно.

**3. Хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй данс.**

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдож болзошгүй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй болно.

*График 3 Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний хүчин төгөлдөр байдлын үзүүлэлт.*




Энэхүү тайлан нь түүнийг тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй.

## ГУРАВ. САНАЛ/ЗӨВЛӨМЖ

Фидуцийн гэрээний загварыг хуульд нийцүүлэх шаардлагатай. Фидуцийн гэрээ нь үүргийн гүйцэтгэлийн хангах харилцааны зүйл болох хөдлөх хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг үндсэн шинжийг үгүйсгэж, барьцааны зохицуулалттай хольсон агуулгыг тусгасан тул гэрээний загварыг зөвтгөх шаардлагатай.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн дансдын хувийн хэрэгт зээлийн хяналтын тайлан үйлдээгүй байна. Зээл олгосноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа зээлийг эргэн шалгадаг байх, даатгалын хугацаа дууссан эсэх зэрэг мэдээллийг шалгах шаардлагатай учраас зээлийн хяналтын тайлан үйлдэн хувийн хэрэгт хавсаргадаг байх шаардлагатай гэж үзлээ.

БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг нэмж бүрдүүлдэг болох шаардлагатай. Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн материалын бүрдүүлбэрт зээлийн ашиглалт шалгасан



193

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023-06-02
БҮРТГЭВ
№ 01

баримтыг шаардаагүй ба зээлдүүлэгч нь автомашин худалдан авах зориулалтаар зээл олгож байгваас үзвэл фидуцийн зүйл болох автомашиныг худалдан авахдаа уг зээлийг зориулалтын дагуу зарцуулсан гэж үзэх талтай. Харин зээл төлж дуусгах хүртэл хугацаанд фидуцийн гэрээний дагуу ББСБ-ын өмчлөлд байгаа автомашиныг ихэнх тохиолдолд Зээлдэгч ашиглаж, унаж байгаа учраас уг хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын талаар ББСБ-ын зүгээс зохих хяналттай байх нь Үнэт цаас гаргагчийн эрх ашигт нийцэхээр байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор Зээлийн үйл ажиллагааны журамд фидуцийн зүйлийн бүрэн бүтэн байдал, ашиглалт шалгасан баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргах зохицуулалт оруулах зэрэг арга хэмжээ авахыг зөвлөж байна.

Зөрчлийн тухай хуулийн 11.8-д БЭБХЭМХМХШЗҮАтХууль зөрчих талаар зохицуулсны 5.6-д зааснаар зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангаагүй бол учруулсан хохирол, нохон төлбөрийг гаргуулж, тухайн зөрчил гаргасан үйлдлээс олсон орлогыг хурааж хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулах хариуцлага хүлээхээр байгааг анхаарна уу.

Сонгогдсон зээлийн дансдын заримд нь зээлийн үндсэн дүнг хуулийн этгээд "ХХХ" ХХК, эсхүл Монгол Улсын иргэн ХХХ буюу тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь тээврийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллага болон хувь хүнтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, автомашины зээлийн бүтээгдэхүүний хувьд зээлийн төлбөрийг нийлүүлэгчид дараа тооцоогоор шилжүүлж байхаар тохиролцсон байна. Хэдийгээр зээлийн төлбөрийг автомашин нийлүүлэгчийн дансанд шилжүүлэхийг талууд гэрээ ( эсхүл тусгайлсан зөвшөөрөл бүхий бичиг)-ээр тохиролцсон боловч зээлийн гэрээ нь бодит хэлцэлд хамаарахын хувьд зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд шилжүүлж байх нь зүйтэй байна.

Шалгуур үзүүлэлт 2-т дурдсанчлан зээлийн гэрээнд БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т заасан "*зээлийн дансны дугаар*", 20.2.8-д заасан "*зээлдүүлэгчийн оршин байгаа хаяг*" тусгагдаагүй зөрчил илэрсэн. Ийнхүү илэрсэн зөрчил нь яаралтай шийдвэрлэсэн асуудлуудын жагсаалтад багтсан хэдий ч цаашдаа БЭБХЭМХМХШЗҮАтХ-д нийцүүлэн тус нөхцөлүүдийг тусгах нь зүйтэй байна. Ийнхүү тусгаагүйтэй холбоотойгоор Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1[6]-д заасны дагуу хууль зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлдэгч, хамтран зээлдэгч нар нь шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг аваагүй байсан. Үүнтэй холбоотойгоор зээлдэгчийн төлбөрийн чадварыг судлахдаа шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг авдаг, энэ талаарх мэдээллийг аливаа хэлбэрээр шалгадаг байх нь зээлийн төлбөр төлөгдөх боломжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Зээлийг судлах хугацаанд үндсэн болон хамтран зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн зээлийн ангилал нь анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй, муу байх тохиолдолд зээл олгох эсэх, хэрэв зээл олгох бол нөхцөл, шаардлага, шалгуурыг Зээлийн үйл ажиллагааны журамд нэмж тусгах нь зүйтэй.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.1-д "*Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулна*" гэж заасны дагуу жолоочийн албан журмын хариуцлагын гэрээг байгуулагдсан гэж үзэх талтай. Гэвч Иргэний хуулийн 499.4-д "*тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй*" гэж заасан тул Фидуцийн гэрээний дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгчөөр

[6] 56.1. Дараах хэлцэл хүчин төгөлдөр бус байна: 56.1.1. хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
ATA9998 9999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
...ЗЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

194

бүртгэлсэн Бичил Глобус Финанс ББСБ-аас тээврийн хэрэгслийг эзэмшиж, ашиглаж буй зээлдэгч (жолооч)-ийн замын хөдөлгөөнд оролцох үедээ буслан учруулсан хохирлыг шаардаж болохоор байна. Тиймээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг шалгаж, зээлийн бүрдүүлбэрт хавсаргаж байх нь зүйтэй.

Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тээврийн хэрэгслийн өмчлөгчийн мэдээлэлд Бичил Глобус Финанс ББСБ-ын мэдээллийг оруулж, даатгалын тохиолдол үүссэн бол нөхөн төлбөрийг даатгуулагч буюу Бичил Глобус Финанс ББСБ хүлээн авах боломжтой байдлаар зохицуулах нь зүйтэй.

Зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө зээлийн төлбөрийг илүү дүнгээр төлж байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчилж батлан зээлдэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулж байх нь зүйтэй.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ



195

Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус

| № | ББСБ | Зээлийн дансны дугаар | Статус |
|---|---|---|---|
| 1. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110004937 | ★ |
| 2. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110004976 | ★ |
| 3. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110004979 | ★ |
| 4. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110004990 | ★ |
| 5. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005010 | ★ |
| 6. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005022 | ★ |
| 7. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005038 | ★ |
| 8. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005072 | ★ |
| 9. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005089 | ★ |
| 10. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005086 | ★ |
| 11. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005119 | ★ |
| 12. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005139 | ★ |
| 13. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005248 | ★ |
| 14. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005258 | ★ |
| 15. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005267 | ★ |
| 16. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005287 | ★ |
| 17. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005329 | ★ |
| 18. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005541 | ★ |
| 19. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005600 | ★ |
| 20. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005661 | ★ |
| 21. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005665 | ★ |
| 22. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005687 | ★ |
| 23. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005714 | ★ |
| 24. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005711 | ★ |
| 25. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005721 | ★ |
| 26. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005729 | ★ |
| 27. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005735 | ★ |
| 28. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005757 | ★ |
| 29. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005777 | ★ |
| 30. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005785 | ★ |
| 31. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005818 | ★ |
| 32. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005840 | ★ |
| 33. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005846 | ★ |
| 34. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005858 | ★ |
| 35. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005884 | ★ |
| 36. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005904 | ★ |
| 37. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005900 | ★ |
| 38. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005915 | ★ |
| 39. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005949 | ★ |
| 40. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005964 | ★ |
| 41. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005986 | ★ |
| 42. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005980 | ★ |
| 43. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005991 | ★ |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02



СЗХ
он 2023 сар 06 . 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | |
|---|---|---|---|
| 44. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110005995 | ★ |
| 45. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006064 | ★ |
| 46. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006070 | ★ |
| 47. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006088 | ★ |
| 48. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006084 | ★ |
| 49. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006090 | ★ |
| 50. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006104 | ★ |
| 51. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006110 | ★ |
| 52. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006144 | ★ |
| 53. | Бичил Глобус Финанс ББСБ ХХК | 2100130110006150 | ★ |

-ooOoo-



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛЮС ТЗК ХХК
АТА9999 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ 2023-06-02
№ 01

Хавсралт 2. Үнэт цаас гаргагчийн зүгээс өгсөн хөндлөнгийн шинжилгээнд зөрчилд тооцохгүй ялгаатай шийдвэрлэгдсэн асуудал

**Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгоход анхаарах ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт**

**Нэг.** Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад анхаарах асуудлууд нь Захиалагч буюу "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК (цаашид "анхны үүрэг гүйцэтгэгч" гэх)-ийн өгсөн ажлын даалгаврын салшгүй хэсэг тооцогдоно.

**Хоёр.** Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад эдгээр харилцан тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд үүссэн нөхцөлд тухайн дансыг хуулийн шаардлага хангасан (зөвхөн энэхүү харилцан тохиролцсон асуудлын хувьд) гэж тооцно.

**Гурав.** Бичил Эй Би Эс Плас багцад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын тайлбартай давхацсан зээл байж болно.

**Дөрөв.** Ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын дэлгэрэнгүй тайлбар, жагсаалт

| | | |
|---|---|---|
| 1 | Зээлийн шимтгэл, хамтран зээлдэгч, тээврийн хэрэгслийн урьдчилгаа төлбөр, татвартай холбоотой | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6.5-д заснаар "Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй" гэж заасны дагуу "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Зээлийн гэрээний 6.6-д "*зээлийн төлбөр төлөхтэй холбоотой аливаа төлбөр тооцоог Зээлдүүлэгчийн тухайн үед мөрдөгдөж буй хүү, шимтгэлийн нөхцөлөөр гүйцэтгэхийг зөвшөөрч байна*" гэж зохицуулж, харилцагчаас зээлийн хүү, ерөнхий нөхцөлийн дагуу зээл тус бүрээс тодорхой хэмжээний зээлийн шимтгэл авдаг. "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 6-р сарын 17-ны өдрийн 22/04а/52 тоот тушаалаар зээлийн шимтгэлийг зээл олголтын дүнгээс суутган төлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн ба тус тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацааны зээлийн хувьд зээлийн шимтгэлийг зээлийн төлбөрөөс суутган тооцож болно. Түүнчлэн "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 3-р сарын 10-ны өдрийн 20/04а/22 тоот тушаалаар дэлхий нийтээр дэгдэж буй коронавирусын дэгдэлттэй холбоотойгоор 2020 оны 3-р сарын 09-ний өдрөөс эхлэн "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь зээлийн шимтгэл, хураамжийг түр хугацаанд зогсоож шийдвэрлэсэн бөгөөд салбар, салбарын онцлогоос хамаарч ялгаатай хугацаанд зээлийн шимтгэлийг тооцоогүй байна.<br><br>"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журмын 3.2 дугаар зүйлийн 3.2.6-д заснаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий автомашины зээлд хамтран зээлдэгчтэй байх шаардлага тавьсан. Харин "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 09-р сарын 21-ний өдрийн 22/04а/85 тоот тушаалаар автомашины худалдан авалтын зээлийн хувьд харилцагч урьдчилгаа төлбөрөө 30 болон түүнээс дээш хувь төлсөн тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгчгүй байж болохоор зохицуулсан тул зарим зээлийн хувьд хамтран зээлдэгчгүй байгаа болно.<br><br>Тээврийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд зээлдэгч урьдчилгаа төлбөр төлөх гэх агуулга бүхий заалт орсон бол урьдчилгаа төлбөрийн баримтыг хувийн хэрэгт хавсаргадаггүй тул зарим зээлийн хувийн хэрэгт энэ талаарх баримтыг бүрдүүлээгүй байж болно.<br><br>Зээлийн гэрээний харилцаа дуусгавар болоход Бичил Глобус Финанс ББСБ ХХК нь тээврийн хэрэгслийн татвар төлөгдсөн эсэхийг шалгасны үндсэн дээр |



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

| | | |
|---|---|---|
| | | тээврийн хэрэгслийг Зээлдэгчийн нэр дээр шилжүүлдэг тул тээврийн хэрэгслийн татвар төлсөн баримтыг заавал олгоход шаардлагагүй, энэ талаарх баримтыг зээлийн хувийн хэрэгт хавсаргадаггүй болно.<br><br>Зээлийн гэрээний 3.2.5-д заасанаар зээлдэгч нь тээврийн хэрэгслийн даатгал, албан татвар, бусад татвар хураамж, тээврийн хэрэгсэлд ноогдсон торгуулийн хуулас, журамлагдсан зогсоолын төлбөр зэргийг цаг тухайд нь төлөх үүрэгтэй тул зарим фидуцийн эд зүйл буюу автомашин нь татвар, торгуультай байж болно. |
| 2 | Зээлийн хорооны шийдвэртэй холбоотой | "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журмын 9.1-т заасанаар зээлийн шийдвэрийн дагуу зөвшөөрсөн зээлийн гэрээ байгуулахаар заасан. Харин "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 14-ний өдрийн 22/04а/19 тоот тушаалаар салбарын зээлийн хороогоор шийдвэрлүүлэх зээлийн хэмжээ 30 сая төгрөг хүртэлх байсныг 40 сая төгрөг хүртэлх болгож, салбар дангаараа төвийн зээлийн хорооны шийдвэргүйгээр шийдвэрлэх боломжтой болсон. Иймд, зарим зээлийн дансдын хувийн хэрэг зээлийн хорооны шийдвэр хавсаргаагүй байж болно.<br><br>Зарим зээлийн дансдын хувьд зээлдэгчийн орлого хүрэлцээтэй, барьцаа хөрөнгийн үнэлгээ хангалттай байсан тул Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авч салбартаа зээлийг шийдвэрлэж гаргасан байж болно. |
| 3 | Даатгалтай холбоотой | "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журмын 6.7-д автомашин худалдан авалтын зээлд тээврийн хэрэгслийн даатгалыг зайлшгүй хийлгэх ба даатгалыг зээлийн гэрээний хугацаа дуустал жил бүр сунгахыг харилцагчид мэдэгдэнэ гэж заасанаар тээврийн хэрэгслийн даатгалын гэрээг зээлийн хувийн хэрэгт хавсаргадаг. Зээлдэгч даатгалын төлбөрийг тухайн даатгалын компанийн дансанд шилжүүлсний дараа гэрээ болон баталгаа гардаг, мөн www.portal.smartcar.mn вэбсайтад оруулсан мэдээллээр автомашин нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай байх тул тээврийн хэрэгслийн даатгалын төлбөр, хураамжийг төлж даатгуулсан байна. Зээлийн үйл ажиллагааны журмын дагуу даатгалын хураамж төлсөн баримтыг зээлийн хувийн хэрэгт хавсаргахгүй байж болно.<br><br>Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тээврийн хэрэгсэл өмчлөгчийн мэдээлэл нь даатгалын компанийн программын онцлогоос хамааран алгаатай тэмдэглэгдэж болох бөгөөд гэрээнд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн мэдээлэл тусгагдаагүй байж болно. Үүнээс гадна зарим даатгалын компани нь тээврийн хэрэгслийн даатгалын гэрээг хувь хүн (зээлдэгч)-тэй байгуулж, зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлж дуусахад нь даатгалын гэрээний хугацааг сунгадаг байна.<br><br>Жолоочийн хариуцлагын даатгал нь хуульд заасны дагуу албан журмаар даатгуулах бөгөөд Зээлийн үйл ажиллагааны журамд жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг зээлийн хувийн хэрэгт хавсаргах талаар зохицуулаагүй байна.<br><br>Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд даатгалын эрсдэлийг хязгааргүй хариуцахаар тэмдэглэсэн бол даатгалын гэрээнд жолоочийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг оруулахгүй байж болно. |
| 4 | Хувийн хэрэгт ааагдсан баримттай холбоотой | Зээлийн үйл ажиллагааны журамд заасанаар зээлдэгчийн орлого нотлох баримт нь үндсэн болон хамтран зээлдэгчийн дансны хуулга, нийгмийн даатгалын лавлагаагаар тодорхойлогдох тул хөдөлмөрийн гэрээ, ажлын газрын тодорхойлолт, цалингийн дансны хуулгыг зээлийн хувийн хэрэгт |

| | | |
|---|---|---|
| | | хавсаргаагүй. "Бичил Глобус Финанс" ББСБ ХХК нь зээлийн судалгаа хийхдээ зээлдэгчийн дансны хуулгыг шалгаж, нэмэлт материал шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын тодорхойлолт зэрэг бусад баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргадаг байна. Зээлдэгч нь бизнесийн орлоготой бол багадаа 6 сарын дансны хуулгыг шалгадаг болно.<br><br>Мөн Үндсэн зээлдэгчийн өр орлогын харьцаа өндөр, урьдчилгаа төлбөрийг өндөр хувиар төлсөн бол хамтран зээлдэгчийн зээлийн судалгаа хийдэггүй.<br><br>Харилцагч нь "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-иас 2 ба түүнээс дээш удаа зээл авч байгаа тохиолдолд зээлдэгч болон хамтран зээлдэгчийг орлого нотлохыг шаардлагагүй болно.<br><br>Зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн хэвийн бус ангилал хасагдсан эсхүл өр төлбөргүй, зээлийн эргэн төлөлт хэвийн болсон бол түүнийг Зээлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зээлийн мэдээллийн санд хэвийн ангилалтай байх шаардлагыг хангасан гэж үзнэ.<br><br>2100130110006110 тоот зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан баримтаас үзвэл тээврийн хэрэгсэл худалдагч "ХХ" ХХК нь тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг зээлдэгчид шилжүүлэхгүйгээр Бичил Глобус Финанс ББСБ-д шилжүүлсэн байна. "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Зээлээр худалдах, худалдан авах гэрээ, Хамтран ажиллах гэрээгээр "ХХ" ХХК-иас тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлж авахаар тохиролцсон байх тул зээлдэгчид тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлэхгүй байж болно.<br><br>**Фидуци буюу автомашины өмчлөх эрхийг "Бичил Глобус Финанс" ББСБ ХХК нь шилжүүлэн авсан, зээлдэгч автомашиныг бодит эзэмшилдээ авч ашиглаж байгаа нь зээл зориулалтын дагуу ашиглагдсан гэж үзэх тул БЭБХЭМХМХШЗУАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг бүрдүүлээгүй байж болно.**<br><br>**Үндсэн болон Хамтран зээлдэгч нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газарт өр төлбөртэй эсэх лавлагаа аваагүй байж болно.** |
| 5 | **Зээлийн гэрээ, фидуцийн гэрээтэй холбоотой** | **Хамтран зээлдэгч нь фидуцийн зүйлийг өмчлөөгүй тохиолдолд барьцааны гэрээ буюу Фидуцийн гэрээнд хамтран зээлдэгчийн мэдээллийг оруулаагүй, гарын үсэг зуруулаагүй байж болно.**<br><br>**Зээлийн данслын хувьд фидуцийн гэрээнд хамтран зээлдэгчийн мэдээллийг оруулаагүй, гарын үсгээр баталгаажуулаагүй байж болно. Иргэний хуулийн 235.1-т "*үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр (цаашид "фидуци" гэх) үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ*", 235.4-т "*үүрэг хүлээгч мөнгө төлөх үүргээ хугацаанд нь биелүүлж, шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан авсан буюу эсхүл үүргээ биелүүлээгүй бол өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитоор гаргуулан авснаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ дуусгавар болно*" гэж тус тус заасан. Мөн фидуцийн гэрээний 1.1-т зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулахаар доорх барьцааны зүйлийг барьцаалав, 1.3-т МУ-ын Иргэний хуулийн 235.1 заалтыг үндэслэн барьцаа болох автомашины өмчлөх эрхийг Бичил Глобус Финанс ББСБ-ын болон төлөөлөгчийн нэр дээр шилжүүлэх ба зээлийн гэрээний үүрэг бүрэн дуусгавар болсон үед Барьцаалуулагчид буцаан шилжүүлнэ гэж заажээ. Дээрхээс үзвэл, фидуцийн гэрээний дагуу "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК** |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02



СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | |
|---|---|---|
| | | нь зээлийн гэрээний үүрэг хангагдсан тохиолдолд тээврийн хэрэгслийн өмчлөлийг үүрэг гүйцэтгэгчид буюу зээлдэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна. Иймд, зээлийн гэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч нь үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчийн хэн байгаагаас үл шалтгаалан зээлийн гэрээний үүрэг гүйцэтгэж буй этгээдэд (үндсэн зээлдэгч) тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна.<br><br>Фидуцийн зүйл болох автомашиныг тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасан арлын дугаараар тодорхойлох бөгөөд тээврийн хэрэгслийн улсын дугаар өөрчлөгдсөнийг зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд оруулаагүй нь зөрчил болохгүй.<br><br>Зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд зээлдэгчийн оршин суугаа хаягийг оршин суугаа газрын тодорхойлолтоор бус иргэний үнэмлэхийн хаягаар бичсэн тохиолдолд зөрчил гэж үзэхгүй.<br><br>Зээлийн гэрээ, барьцааны гэрээ (фидуцийн гэрээ)-нд үндсэн болон хамтран зээлдэгчийн хаягийг тусгахдаа утгад нөлөөлөхгүй, илт алдаатай бус техникийн алдаа гаргасан тохиолдолд хүлээн зөвшөөрнө.<br><br>Талууд зээлийн гэрээ, фидуцийн гэрээг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн салбарт биечлэн ирж байгуулж буй тул Зээлийн гэрээнд Зээлдүүлэгчийн оршин байгаа хаягийг бичээгүй байж болно.<br><br>Зээлийн дансны дугаараар Зээлийн гэрээнд дугаар олгож буй тул тус гэрээнд зээлийн дансны дугаар оруулахгүй байж болно.<br><br>Зарим зээлийн дансдын хувьд зээлийн үнийн дүнг "XXX" ХХК, эсхүл Монгол Улсын иргэн XXX буюу тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь тээврийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллага болон хувь хүнтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, автомашины зээлийн бүтээгдэхүүний хувьд зээлийн төлбөрийг нийлүүлэгчид дараа тооцоогоор шилжүүлж байхаар тохиролцсон байна. Хэдийгээр зээлийн төлбөрийг автомашин нийлүүлэгчийн дансанд шилжүүлэхийг талууд гэрээ (эсхүл тусгайлсан зөвшөөрөл бүхий бичиг)-ээр тохиролцсон боловч зээлийн гэрээ нь бодит хэлцэлд хамаарахын хувьд зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд шилжүүлж байх нь зүйтэй байна. |

—oOo—



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИЗНЕС ПЛЮС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
6163855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИАС АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

| | |
|---|---|
| **ХААНА:** | **"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-д** |
| **ХАЯГ:** | **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 11-Р ХОРОО, 7 ХОРООЛОЛ, НОГООН НУУР, 101 БАРИЛГА, 706 ТООТ** |
| **УТАС/ФАКС:** | **(976) 99119632** |
| **ХААНААС:** | **"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН** |
| **ХАЯГ:** | **УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, СҮХБААТАРЫН ТАЛБАЙ 2 СЭНТРАЛ ТАУЭР, 13 ДАВХАР, 1301 ТООТ** |
| **УТАС/ФАКС:** | **(976-11) 330048, (976-11) 330049** |
| **ОГНОО:** | **2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 5-НЫ ӨДӨР** |

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02



СЗХ
он сар өдөр
2023.06.1
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

2023.05.05 № Б-23/94

"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС
ТЗК" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТАНАА

**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК" ХХК-ИАС АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "МДСХ" гэх) нь "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх)-ийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаж нийтэд санал болгохтой холбогдуулан энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг, хариуцлага бий болгохгүй. Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа агуулах зорилгогүй болно.

Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа бусад мэдээлэл, түүний дотор тоон мэдээллүүдийн талаар МДСХ нь нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд ороор дурдсанаас бусад тохиолдолд МДСХ-ийн хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Эд хөрөнгө, эдийн бус баялгийн үнэлгээ, хувьцааны үнэ, ханшийн мэдээллийн талаар;
7. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ЭНЗИН ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ
№ 01



холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар архив, хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;

8. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг МДСХ нь энэхүү Дүгнэлттэй холбоотой гаргахгүй болно;
9. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд МДСХ нь өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах (цаашид "Үнэт цаас" эсхүл "ХБҮЦ" гэх)-тай холбогдуулан Компани болон Компанитай гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Компанийн мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаас гаргагч-"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан МДСХ нэмэлт хууль зүйн дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЭХ
2023 .06. 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

**АГУУЛГА**

Удиртгал ........................................................................................................ 5

Хангагдсанд тооцох нөхцөл.............................................................................. 5

1. **Компани үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх** ....................................................... 8

2. **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх** ....................................................................................... 10

3. **Компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, заавруул нь хууль тогтоомжид нийцсэн эсэх** ........................................................... 12

4. **Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх** ............................................................................................ 16

5. **Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх** ........ 19

6. **Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх** ............................................................... 22

7. **Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх** 23

8. **Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх** .............. 24

9. **Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ** ......................................................... 26

1. ..................................................................................................... 32

2. ..................................................................................................... 32



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 9023050164

УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 06 07
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

## Удиртгал

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**МДСХ**", эсхүл "**Бид**" гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасны дагуу Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Бичил Эй Би Эс Плас" ХХК (Регистрийн дугаар: 6999131) (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "**ХБҮЦ**" гэх) гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг Компанийн үүсгэн байгуулагч-"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК (цаашид "Бичил Глобус Финанс ББСБ" гэх) нь биднээс хүсэж, улмаар 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах), 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйл (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах), Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.5.5 дугаар зүйл (Хууль зүйн дүгнэлтийн агуулга), Санхүүгийн Зохицуулах хорооны 2022 оны 06-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 2 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанид тавигдах шаардлага), 5 дугаар зүйл (Баталгаат үнэт цаасыг бүртгэх шаардлага), 3 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц), 7 дугаар зүйл (Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага), 8 дугаар зүйл (Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ), 10 дугаар зүйл (Аудитын шалгалт болон хууль зүйн дүгнэлт)-д тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган СЗХ, МХБ-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Хангагдсанд тооцох нөхцөл**

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Дүгнэлт гаргахад ашигласан Үнэт цаасны танилцуулга нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргэгдэж, ХБҮЦ-ны албан ёсны үнэт цаасны танилцуулга болж ашиглагдах;



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
6999131

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээ, мэдээллийг оруулсан этгээд нь хууль тогтоомж буюу тухайн талын дүрэм, дотоод дүрэм журам, эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, эрх бүхий этгээдээс авбал зохих хууль ёсны, хүчин төгөлдөр зөвшөөрөл, итгэмжлэл, эрхийг зохих ёсоор авсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгад мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт байдлаар тусгасан;
3. Үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөл ирээдүйд хэрэгжих тохиолдолд тухайн нөхцөл нь хуулийн дагуу, зохих ёсоор, эрхийн болон биет байдлын доголдолгүй хэрэгжих;
4. Үнэт цаасны танилцуулгыг батлах, бүртгүүлэх үйлдэл нь хуульд нийцсэн, зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
5. Үнэт цаасны танилцуулгад дурдсан санхүүгийн тоо, мэдээ, баримт, үзүүлэлт, тооцоо, тайлан болон бусад үзүүлэлтийг аудитын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага хянан баталгаажуулсан, эдгээр мэдээ мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт;
6. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хөрөнгийн багцаа хийсэн судалгаа шинжилгээ үнэн зөв, бүрэн гүйцэт байх;
7. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хэлцэл хийх, гэрээ байгуулах, хэлцэл батлах талаарх үйлдэл нь хуульд нийцэж зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
8. Үнэт цаасны танилцуулгад тусгасан талуудын хооронд байгуулагдах гэрээ, хэлцлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу зохих ёсоор байгуулах, гэрчлүүлэх, бүртгүүлэх;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, мэргэжлийн оролцогчдын хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Дүгнэлт гаргахад ашигласан гэрээ хэлцлийн төсөл нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар байгуулагдах;
11. Дүгнэлт гаргахад ашиглагдсан (а) бидэнд ирүүлсэн бүх баримт бичигт дурдсан мэдээлэл үнэн, зөв, бүрэн гүйцэт; (б) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг зохих ёсны бөгөөд үнэн зөв; (в) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтууд нь хамгийн сүүлд батлагдсан хувилбар буюу тэдгээрт өөрчлөлт ороогүй, хүчингүй болоогүй;
12. МДСХ-ээс тавьсан асуулт, тодруулгад Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигч, бусад оролцогчоос амаар болон бичгээр өгсөн хариулт, тайлбар, түүнийг нотлох баримт бичиг үнэн зөв;
13. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл загвар, маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
14. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
15. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
16. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
17. Компани, түүний албан тушаалтан, ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
18. Шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 Ү 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

19. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь гийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;
20. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргахтай холбоотойгоор бэлтгэл ажил гүйцэтгэхэд шаардлагатай гэрээ, хэлцэл (Хөрөнгийн зөвлөх үйлчилгээний гэрээ, Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ, Хамтран ажиллах гэрээ)-г "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК байгуулсан болно. Эдгээр гэрээг "Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийн эрх ашгийн үүднээс байгуулсан тул тэдгээр гэрээнд тусгагдсан "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн зарим эрх, үүргийг Үнэт цаас гаргагч хэрэгжүүлж болно.

Энэхүү ХБҮЦ-ны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам ("СЗХ-ны журам"), Хууль зүйн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 тоот тушаалаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам" болон ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн Арилжааны журам"-д заасны дагуу явагдана гэж үзэв.

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгож, зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнүүд нь тусгай зориулалтын компанийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд компанийн нэр уг хутацааас өмнө ба дараа өөрөөр туссан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаасны танилцуулга, бусад холбогдох мэдээллүүдийг үндэслэн Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна.

"Бичил Эй Би Эс Плас" ХХК нь 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/01а/01 тоот тогтоол (Хавсралт 1.3), "Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/25а/01 тоот тогтоол (Хавсралт 1.4)-ийн үндсэн дээр Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдаж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн (Хавсралт 1.5, 1.6) байна. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7-д заасан үндэслэлээр тус хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчид мэдэгдсэн байна. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК бөгөөд тус компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр "Бичил Глобус" ХХК (Хавсралт 1.13) байх ба тогтоолд "Бичил Глобус" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох С.Отгонбат, Б.Хүрэлхүү нар (Хавсралт 10.6) гарын үсэг зурсан байна.

"Бичил Эй Би Эс Плас" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө уг үнэт цаасаа бүртгүүлэхийн өмнө Санхүүгийн зохицуулах хорооноос авахаар төлөвлөж, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 25/09 дугаартай албан бичгээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг (Хавсралт 1.7), холбогдох материалаа Хороонд хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 118 дугаар тогтоолоор Компани нь Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.8)-ийг авч "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болж, оноосон нэр, эрхлэх үйл ажиллагааны төрөлд өөрчлөлт оруулан дүрмээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байна (Хавсралт 1.9, 1.10).

**Компанийн тухай мэдээлэл:**

*Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар:* 000272328
*Улсын бүртгэлийн дугаар:* 9011849203;
*Регистрийн дугаар:* 6999131;
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* "Бичил Эй Би Эс Плас ТЗК" Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл:* Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
*Хугацаа:* Хугацаагүй;
*Хувьцаа эзэмшигчдийн тоо:* 1;

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ | | |
| | | | Нэг бүрийн үнэ | Бүгд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК | 1,000 | 1,000 | 1,000,000 | 100% |

*Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:* 1,000,000 төгрөг;
*Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:* Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Цогоон нуур, 101 барилга, 705 тоот;
*Гүйцэтгэх захирал:* С.Оттонбат.

**Компани үүсгэн байгуулагчийн тухай мэдээлэл:**

*Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар:* 000164688;
*Улсын бүртгэлийн дугаар:* 9015002106;
*Регистрийн дугаар:* 5729718;
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* "Бичил Глобус Финанс ББСБ" Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Хавсралт 1.11, 1.12);
*Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ:* СЗХ-ны 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 379 тоот тогтоолын дагуу ТЗ 101/307 дугаар бүхий Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Хавсралт 1.14)
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл:* Зээлийн үйл ажиллагаа эрхлэх, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх (Хавсралт 1.14);
*Хугацаа:* Хугацаагүй.

ТЗК үүсгэн байгуулах этгээд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4 дүгээр зүйлд заасныг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байж болно. Компанийг үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 3.1.1, 8.1.2.8, 8.1.2.9, 8.1.2.11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6.1, 9.1-д тус тус заасны дагуу СЗХ-ны 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 379 тоот тогтоол (Хавсралт 1.15)-оор Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 309 тоот тогтоол (Хавсралт 1.16)-оор факторингийн үйлчилгээ үзүүлэх, 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 340 тоот тогтоол (Хавсралт 1.17)-оор итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 23900002001017 тоот лавлагаа (Хавсралт 1.11)-нд заасныг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь татан буугдсан, дампуурсан талаарх тэмдэглэлгүй тул Дүгнэлт гаргах өдрийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, эрх зүйн чадвар, чадамжтай хуулийн этгээд тул "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах эрх бүхий этгээд болно.

Иймд, энэхүү улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000272328, Улсын бүртгэлийн дугаар 9011849203, Регистрийн дугаар 6999131) бүхий "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 оны 06 сар 1? өдөр
БҮРТГЭВ
№ 01



- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид [illegible]

***Үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай:***

"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай 23/01а/03 тоот тогтоол (Хавсралт 2.1)-оор "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн зээлүүдээс бүрдсэн 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангахыг Бичил Глобус Финанс ББСБ-ын холбогдох ажилтнуудад үүрэг болгон шийдвэрлэсэн байна.

СЗХ-ны журмын 10.4.6 дахь хэсэгт заасны дагуу зээлийн шинжилгээ хийж, "Онч Аудит" ХХК-иас 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр "Үр дүнгийн тайлан", "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр "Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан"-г тус тус гаргажээ. Эдгээр тайлан нь "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 23/25а/07 тоот тогтоол (Хавсралт 2.2)-ын 2, 3 дугаар хавсралтаар баталсан хөрөнгийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн данслад нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, "Хөрөнгийн багцын хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт"-ийг хангасан болохыг баталгаажуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл хангах тухай 23/01а/03 тоот тогтоол (Хавсралт 2.1), Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч нарын хооронд 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ (Хавсралт 4.1)-ний дагуу "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн багцалсан зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхээр тохиролцож, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна.

***Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шийдвэр:***

Компанийн хувьцаа эзэмшигч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 23/01а/01 тоот ХЭХ-ийн тогтоол (Хавсралт 1.3)-ын дагуу Компанийн хувьцаа эзэмшигч нь "Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийг байгуулж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 118 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрөл олгосныг үндэслэн "Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай" Компанийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/07 дугаар тогтоол (Хавсралт 2.2)-оор Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "Үнэт цаас" гэх)-ыг дараах нөхцөлтэйгээр гаргахаар шийдвэрлэсэн. Үүнд:



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК ХХК
6183955
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

| | |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| Үнэт цаасны нэр | Бичил-2 ХБҮЦ |
| Үнэт цаасны тоо ширхэг | 200,000 (хоёр зуун мянга) ширхэг хүртэл |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| ХБҮЦ-аар татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг хүртэл |
| Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа | 2023 оны 6 дугаар сар |
| Үнэт цаасны хүү, хувь хэмжээ: /жил/ | 18.5 % |
| Үнэт цаасны хугацаа: /хоног, сар, жил/ | 24 (хорин дөрөв) сар |
| Үнэт цаасны хүүгийн төрөл | Тогтмол |
| Үнэт цаасны хүү тооцох суурь хоног | 365 |
| Үнэт цаасны хүү төлөх хугацаа: давтамж/ | Улирал тутам |
| Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хугацаа | Хөрөнге оруулагчид төлөх үндсэн төлбөрийн 50 хувийг Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа мөн сарын мөн өдөр төлнө. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.) Үлдэгдэл төлбөрийг Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 сарын дараа мөн сарын мөн өдөр шилжүүлнэ. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.) |
| Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо: | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Үнэт цаасны зарцуулалт: | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээсийн зээлийн багцыг худалдан авах санхүүжилт |
| Барьцаа: | Автомашины фидуци бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс |

Энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.4 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ПИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



*Компанийн дүрэм*

***"Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 23/25а/01 дугаар шийдвэр (Хавсралт 1.4)-ээр баталж, улсын бүртгэлийн тамгаар "Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийн дүрмийг (Хавсралт 1.6) баталгаажуулсан байна. Дүрэм нь нийт 11 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хугацаа, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайланд хяналт тавих, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна. Мөн "Бичил Эй Би Эс Плас" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай 62 дугаар зүйлийн 62.1.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд дүрмийг баталсан, дүрэм батлах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол нь тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан саналын эрхийн хэмжээнд хүрсэн, 17.9-т заасны дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 118 дугаар тогтоолоор Компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрөл олгосон.

***"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн дүрэм.*** Ийнхүү зөвшөөрөл олгосон тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 23/01а/06 тоот шийдвэр (Хавсралт 3.2)-ийн 1 дүгээр хавсралтаар "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн дүрэм (Хавсралт 1.10)-ийг баталсан байна. Энэхүү дүрэм нь нийт 8 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, гаргасан хувьцаа, Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлж, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, аудит ба хяналтын тогтолцоо, Компанийг татан буулгах, Компанийн дүрэм хүчин төгөлдөр болохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. СЗХ-оос 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 118 тоот тогтоол (Хавсралт 1.8)-оор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Компанид олгосноор дүрэм нь хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэслэл бий болж, 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна (Хавсралт 1.10). Энэхүү дүрэмд Компанийн оноосон нэрд "ТЗК" болох болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.9 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9, 12.11, 12.12 дугаар зүйлүүд, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.4, 5.11, 6.11 болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

*Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд:*



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
ATA9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031155 СТС2420

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот шийдвэр (Хавсралт 3.1)-ийн 1 дүгээр хавсралтаар энэхүү ТУЗ-ийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.5)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга, гишүүдийг сонгох, бүрдүүлэх баримт бичиг, бүрэн эрхийн хугацаа, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох үндэслэл, ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүний эрх үүрэг, ТУЗ-ийн зохион байгуулалт, ажиллах нөхцөл, хангамж, ТУЗ-ийн хурал, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 75.8, 76.1, 80.1, 80.5, 80.6, 80.9, 80.11, 80.12, 80.14, 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байхаас гадна болон Компанийн дүрэмд нийцсэн байна.

***Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам.*** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 12 дугаар хавсралтаар Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам (Хавсралт 3.4)-ыг баталжээ. Энэхүү журам нь нийт 8 бүлэгтэй бөгөөд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, гэрээ байгуулах, хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, 33.2 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, 12.11.4, 19.1, 19.8, 19.10, 20.1, 20.3, 40.1 дэх хэсэг, Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох хэсэг, Монголын хөрөнгийн биржээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.2 дэх хэсэг болон бусад холбогдох зохицуулалттай нийцсэн байна.

***Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам.*** Компанийн хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилгоор нийт 4 бүлэг бүхий зохицуулалттай энэхүү журам (Хавсралт 3.3)-ыг 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тогтоол (Хавсралт 3.1)-ын 3 дугаар хавсралтаар баталсан байна. Энэхүү журмаар Компанийн хугацаат тайланг нийтэд мэдээлэх, тогтмол мэдээлэх, тухай бүр нөлөөтэй мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийг үнэт цаас эзэмшигчид хүргэхэд баримтлах зарчмыг тодорхойлох, мэдээллийг хадгалах, архивлахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 20.1, 79.1 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.2.3, 39, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11 дүгээр зүйлийн холбогдох хэсэг, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам, Монголын Хөрөнгийн Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5-9.7 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

MDSKhanLex

***Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам.*** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 7 дугаар хавсралтаар Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам (Хавсралт 3.6)-ыг баталжээ. Журмаар ТЗК-ийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг Зээлдэгчид болон Үйлчилгээ үзүүлэгчдээс цуглуулах, цуглуулсан төлбөрөөр үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбогдсон Компанийн үйл ажиллагаа болон Компанийн Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдүүдийн үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам.*** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 8 дугаар хавсралтаар энэхүү журам (Хавсралт 3.7)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, эрсдэлийн ангилал, эрсдэлийг удирдах арга хэмжээ, эрсдэл төлөвтийг сайжруулах, журам зөрчсөн ажилтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***Хөрөнгө итгэмжлэн удирдах журам.*** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 10 дугаар хавсралтаар энэхүү журам (Хавсралт 3.8)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах дараалал, үндэслэлийг тодорхойлж, журмыг зөрчсөн ажилтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцаа зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 18.2 дах хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 13 дугаар хавсралтаар энэхүү журам (Хавсралт 3.9)-ыг баталсан байна. Журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, СЗХ-ны 2019 оны 01-р сарын 21-ний өдрийн А-26 дугаар тушаалаар баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн, холбогдох бусад хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн ТУЗ нь Компанийн дотоод үйл ажиллагааны журмуудыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 76.1.13 дах хэсэг, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд баталсан. ТУЗ-ийн хурал нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5-д заасны дагуу хүчин төгөлдөр байх ба ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 80.6-д заасны дагуу саналын эрхийн хэмжээнд



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15 БҮРТГЭВ-02
СЗХ 2023.08.02 өдөр БҮРТГЭВ № 01
УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164
УЛААНБААТАР ХОТ КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



хүрсэн байх тул дээр дурдсан журмуудыг баталсан ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоол (Хавсралт 3.1) нь хуулийн хүчин төгөлдөр байна.

Компанийн дүрэм, ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 23/25а/08 тоот тогтоолоор баталсан журмууд нь хуулийн хүчин төгөлдөр, хууль тогтоомжид нийцсэн ба ТЗК-ийн дүрэм нь холбогдох эрх зүйн актаар тогтоосон аливаа зөрчилгүй байна.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПИ ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
6183856
9021031195

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02



СЗХ
2023 .08. 02
БҮРТГЭВ
№ 01



[illegible]

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд гоплох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

*Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний төслүүд.*

***Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нарын хооронд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 23/607 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" (Хавсралт 4.1) байгуулагдсан байна. Тус гэрээ нь Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 23/609 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.2) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Фидуцийн барьцааны гэрээ.*** "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нарын хооронд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 20/608 тоот "Фидуцийн барьцааны гэрээ" (Хавсралт 4.3) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 8 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээгээр Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багц, уг багцад буй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг барьцаалагчид барьцаалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ.*** "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 23/611 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" (Хавсралт 4.4) байгуулагдсан байна. Тус гэрээ нь гэрээний тусгай нөхцөл,



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙТ КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 оны 06 сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

гэрээний ерөнхий нөхцөл, хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 8.2 дугаар зүйлд заасан мэдээллийг тусгасан, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 23/610 тоот "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ" (Хавсралт 1.5) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 13 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн нэр дээр банканд нээлгэсэн зээлийн эргэн төлөлтийн мөнгөн хөрөнгийг цуглуулах данс дахь Үнэт цаас гаргагчийн өмчлөлийн мөнгөн хөрөнгийг барьцаалах, түүний захиран зарцуулалтыг хязгаарлахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Үнэт цаас гаргахтай холбоотойгоор байгуулсан гэрээнүүд***

***Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн 2023 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС) болон Аудитын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгон гүйцэтгүүлэх зорилгоор "Ниямазон аудит" ХХК-тай 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр 23/6999131 тоот "Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ" (Хавсралт 1.6)-ээр зохицуулсан байна. Уг гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, гэрээний хугацаа, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, давагдашгүй хүчин зүйл, гэрээ дуусгавар болох, цуцлах, бусад гэсэн 9 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Гэрээний агуулгаас харвал, Аудитын тухай хуульд заасан гэрээнд тусгавал зохих мэдээллийг тусгасан, гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр гэрээ байна. "Ниямазон аудит" ХХК нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 02 тоот тушаалын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх 02-2015 тоот тусгай зөвшөөрөл (Хавсралт 4.7, Хавсралт 4.8)-тэй байх тул аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн, энэхүү гэрээг байгуулах эрхтэй болно.

***Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ.*** СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.1.5, 11.2-т заасны дагуу ТЗК нь хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хадгалах нэгдсэн системтэй байх шаардлага тавигдсан. Үүнтэй холбоотойгоор "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон "Грэйпсити Монгол" ХХК нарын хооронд 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдөр ЛА-23/32 тоот "Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ" (Хавсралт 4.9) байгуулсан байна. Уг гэрээгээр "Грэйпсити Монгол" ХХК нь Захиалагчийн захиалгын дагуу поларис системийг хөгжүүлж захиалагчид түрээсээр ашиглуулах, түүнтэй холбоотой нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

***Ажлын байр түрээслэх гэрээ.*** Үнэт цаас гаргагч нь "Бичил Глобус" ХХК-тай 2023 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур 101 барилга, 706 тоот хаягт байрлах 90.14 м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийн 20 м.кв талбайг оффис (ажлын байр)-ын зориулалтаар түрээслэхээр Ажлын байр түрээслэх гэрээ (Хавсралт 4.10)



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 / 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ЭЗЭНИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2429

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 .06 02 өдөр
БҮРТГЭВ
№01



байгуулжээ. Түрээсийн гэрээг 2028 оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаатайгаар байгуулсан ба тус гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

***Хэлцлийн зөвлөхийн гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн тусгай зориулалттай компани үүсгэн байгуулах, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхэд зөвлөх үйлчилгээ авахаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь "Юнайтед Айр Файнэнс" ХХК-тай 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр ЗҮ/23-01 тоот "Хэлцлийн зөвлөхийн гэрээ" (Хавсралт 4.11)-г байгуулжээ. Гэрээ нь 16 бүлэг бүхий нийтлэг үндэслэл, гэрээ байгуулах хугацаа, талуудыг төлөөлөх, талуудын баталгаа, гэрээт ажил, ажлын хөлс, талуудын эрх, үүрэг, мэдээллийн нууцыг хадгалах, хариуцлага, давагдашгүй хүчин зүйл, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний зарим хэсэг хүчингүй болох, гэрээ цуцлах, маргаан шийдвэрлэх, гэрээ дуусгавар болох, бусад зүйл зэрэг зохицуулалттай байна. Тус гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***Андеррайтерийн, аудитын, хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ.*** Энэхүү гэрээний талаар Дугнэлтийн 5 дугаар бүлгээс танилцана уу.

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан гэрээ, Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

MDSKhanLex

*Оролцогч байгууллагууд:*

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд Үйлчилгээ үзүүлэгч болон Захиргааны ажил гүйцэтгэгчээр "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК, Хөндлөнгийн хуулийн шинжээч, хуулийн зөвлөхөөр "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, Санхүүгийн шинжээчээр "Онч Аудит" ХХК, Андеррайтераар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, Хөлшлийн зөвлөх болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК, Хөндлөнгийн аудитороор "Нямазон аудит" ХХК нар тус тус ажиллаж байгаа болно (Хавсралт 5.1).

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ.*** Гэрээний дэлгэрэнгүй тайлбартай Дүгнэлтийн 4 дэх хэсгээс танилцана уу (Хавсралт 4.4). Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолын дагуу ТЗ 316/18 тоот үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.2, 5.3)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

***Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 1.2)-г 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг зүйл, гэрээт ажил, гэрээний хугацаа, гэрээт ажлын хөлс, зардал, төлбөр тооцоо, хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Дүгнэлтийн 1 дүгээр бүлэгт заасныаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд болно (Хавсралт 1.1).

***Хамтран ажиллах гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах, олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар "Онч аудит" ХХК-тай Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.4)-г 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, хязгаарлалт, ажлын баг, цаг хугацаа болон үйлчилгээний хөлс, бизнес үйл ажиллагааны ерөнхий нөхцөл буюу талуудын хүлээх хариуцлага, үйлчилгээний төлбөр зэрэг бусад харилцааг зохицуулсан байна. Гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох шаардлагыг хангасан байна. "Онч Аудит" ХХК нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд аудитын үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон этгээд байна (Хавсралт 5.5, 5.6).

***Андеррайтерийн гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн нийтэд нээлттэй үнэт цаас санал болгох хүрээнд 20 тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий ХБҮЦ гаргах ажлыг зохион байгуулах,



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС П/ХОФ ТЗК ХХК
ATA9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

мэргэжлийн андеррайтераар ажиллуулахаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай АГ-23/08 тоот "Андеррайтерийн гэрээ" (Хавсралт 5.7)-г 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигчийн үүрэг, хариуцлага, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.1-т заасан үнэт цаасны танилцуулга бэлтгэх, 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах холбоотой үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна. Гэрээ нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна. "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТЗ 301/42 тоот үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.8, 5.9)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

***Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 23/612 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 5.10)-г Үнэт цаас гаргагч нь "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа, мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5-д заасанаар Тусгай зориулалтын компани нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог тул компанийн захиргааны шинжтэй ажлуудыг бие даасан хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр тохиролцсон энэхүү гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр байна.

***Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай.*** ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 23/25а/09 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл батлах тухай" тогтоол (Хавсралт 5.11)-оор "Бичил Финанс ББСБ" ХХК-тай дараах гэрээг байгуулахыг зөвшөөрсөн байна.

- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (Хавсралт 5.1)
- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.2)
- Фидуцийн барьцааны гэрээ (Хавсралт 4.3)
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ (Хавсралт 4.5)
- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.10)

Энэхүү тогтоолыг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт нийцүүлэн гаргасан байна (Хавсралт 5.12).



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПИ ТЗК ХХК
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

2023-06-15
БҮРТГЭВ-02

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн хуулийн шинжээч, санхүүгийн шинжээч байгууллагуудтай аливаа сонирхлын зөрчилгүй талаарх мэдээллийг бидэнд ирүүлсэн (Хавсралт 5.13).



УЛААНБААТАР ХОТ
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
БҮРТГЭВ-02
2023-06-15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЭХ
он сар өдөр
2023.06.02
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Бид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгосон 53 зээлийн дансдад Үнэт цаас гаргагчийн тогтоосон 6 шалгуур үзүүлэлтээр 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хууль зүйн дүн шинжилгээ гүйцэтгэж, 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлттэй нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-г гаргасан.

Тус тайлангаар санамсаргүй түүврийн аргаар сонгосон 53 зээлийн дансдууд нь Үнэт цаас гаргагчийн тогтоосон дараах шалгуурыг хангасан болохыг тэмдэглэж байна. Үүнд:

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх;
5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж төлөх, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Дэлгэрэнгүй мэдээллийг тус тайлан (Хавсралт 6.1)-аас үзнэ үү.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИЗНЕС ПЛАН ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.02
он сар өдөр
БҮРТГЭВ

MDSKhanLex

Хууль зүйн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-аар багийн хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох зээлийн болон фидуцийн гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд тус гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйл (фидуци)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Хууль зүйн дүгнэлтийн (Хавсралт 6.1)-ээс үзнэ үү.



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПАРК ТЗК ХХК
АТА9998 6999131
9923050164

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

MDSKhanLex

- [illegible]

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах шийдвэр, нөхцөл;
- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлт, хүү, хүүг тооцох аргачлал, төлбөрийн хуваарь, үнэт цаас гаргагч гаргасан үнэт цаасаа буцаан худалдаж авах эрхтэй эсэх тухай;
- Хөрөнгийн багц дахь зээлийн дансдын тоо;
- Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн гишүүний талаарх мэдээлэл, тэдгээрийн боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл;
- Зөвшөөрөгдсөн данснуудын мэдээлэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны буцаан дуудах нөхцөл;
- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, зээлийн шинжилгээ гаргагч, хууль зүйн дүгнэлт гаргагч, хөндлөнгийн аудитор, хөрөнгө итгэмжлэн удирдагч, андеррайтерийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо, хаяг, холбоо барих мэдээлэл болон тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл, түүний хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;
- 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийн хугацаа хэтэрсэн буюу чанаргүй зээлийн талаарх мэдээлэл;
- Төлбөрийн чадваргүй байдалд орсон хөрөнгийг цуглуулах, худалдан борлуулах, хөрөнгийг итгэмжлэн удирдагчийн гүйцэтгэхийг хянах, түүнийг солих зохицуулалт;
- ТЗК-ийн ТУЗ-ийн эрх, үүргийн талаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тухай;
- Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ;
- ТЗК-ийн журмууд;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж оруулах, хасах, солих нөхцөл, түүний зохицуулалт;
- Хөрөнгийн багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт;
- Үнэт цаасны арилжаа зохион байгуулах үндсэн мэдээлэл;
- Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг;



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПИ ЭС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

MDSKhanLex

- ТЗК-ийг татан буулгах нөхцөл, журам;
- Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийг тайлагнах хугацаа.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагч, түүний үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгийн баги дахь нийт зээлийн дансдын тооноос бусад мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, хөрөнгө оруулалтын орчин, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт. Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, ХБҮЦ-ийг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж (МДСХ-ээс бусад) байгаа этгээдийн туршлага, удирдлага, бүтэц зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны боловсрол, ажлын туршлага зэрэг энэхүү Дүгнэлтийн 8 дугаар бүлэгт заасан мэдээллээс бусад үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл буюу андеррайтерийн цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаа, таамаглалд МДСХ нь дүн шинжилгээ хийгээгүй, үнэн зөв болохыг тогтоогоогүй болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Компанийн төлөөлөн удирдах зөвлөл**

"Бичил Эй Бн Эс Плас" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 23/25а/02 тоот тогтоол (Хавсралт 9.1)-оор компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож, ТУЗ-ийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 23/25а/03 дугаартай тогтоол (Хавсралт 9.2)-оор ТУЗ-ийн даргаар Н.Гантулгыг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Ц.Дашбилэгтийг томилсон байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| № | Овог, нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| Ердийн гишүүн: | | | |
| 1. | Нямжаргал овогтой Гантулга* (Хавсралт 9.3) | 2001-2005 онд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн математик загварчлалын бакалавр;<br>2011-2012 онд Газарчин Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын магистр. | 2014-2015 онд "Аварга Соёо" ХХК-д Менежер;<br>2015-2017 онд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-д Зээлийн менежер;<br>2017-2019 онд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-д Салбарын захирал;<br>2019-2021 онд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-д Салбарын удирдлагын мэргэжилтэн;<br>2021 оноос одоог хүртэл "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-д Зээлийн газрын захирал. |
| Хараат бус гишүүд: | | | |



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 ✓ 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

2023-06-15 БҮРТГЭВ-02

СЗХ 2023 06. 02 БҮРТГЭВ №01

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Цэдэл овогтой Азбаяр (Хавсралт 9.4) | 2001-2005 онд Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Эрх зүйн бакалавр;<br><br>2005-2007 онд Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Хууль зүйн магистр;<br><br>2007-2010 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын бакалавр;<br><br>2019 оноос одоог хүртэл Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын докторант. | 2005-2011 онд онд Их Засаг Олон Улсын Их Сургуульд Багш, Маркетингийн албаны дарга;<br><br>2011-2012 онд Улсын Их Хурлын Тамгын Газарт Улсын Их Хурлын Гишүүний зөвлөх;<br><br>2012-2014 онд Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын албанд ахлах;<br><br>2012-2021 онд "Хан Голомт" төв НҮТББ-д Захирал;<br><br>2022 оноос одоог хүртэл Өмгөөллийн "Бизнес Ло" ХХН-д Захирал;<br><br>2022 оны 12 дугаар сараас одоог хүртэл "Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн. |
| 3. | Баярөа овогтой Баасандорж (Хавсралт 9.5) | 2005-2010 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Олон улсын эрх зүйн бакалавр;<br><br>2012-2015 онд Төв Хятадын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Харьцуулсан эрх зүйн чиглэлээр Эрх зүйн магистр;<br><br>2017-2019 онд Санхүү Эдийн Засгийн Бизнесийн Удирдлагын бакалавр. | 2010-2011 онд "Энержи Ресурс" ХХК-д Хуулийн мэргэжилтэн;<br><br>2013-2022 онд Өмгөөллийн Батбаяр энд Партнерс ХХН, Бизнесийн хуулийн фирмд Ахлах хуульч, Гишүүн өмгөөлөгч, Гүйцэтгэх захирал;<br><br>2016 оноос одоог хүртэл Өмгөөллийн Баасандорж консалтинг ХХК-ийн Үүсгэн байгуулагч;<br><br>2019 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуульд Нийтийн эрх зүйн тэнхимийн Санхүү, татварын эрх зүйн багш;<br><br>2022 оны 12 дугаар сараас одоог хүртэл "Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн. |

***ТУЗ-ийн дарга**



УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПАК ТЗК ХХК АТА9998 6999131 9023050164

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.06.07
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| **КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэрс/Шаардлага** | **Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашаагүй эсэх** | **Ял шийтгэл эдлээгүй байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** |
| 1. | **Н.Гантулга** (ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн ердийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.09.27-ны өдөр, Дугаар 0230512/ (Хавсралт 9.6) | Тийм |
| 2. | **Ц.Азбаяр** (ТУЗ-ийн ердийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.04.22-ны өдөр, Дугаар 0521249/ (Хавсралт 9.7) | Тийм |
| 3. | **Б.Баасандорж** (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.05.27-ны өдөр, Дугаар 0520700/ (Хавсралт 9.8) | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг аж ахуйн нэгжид олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл хүлээгээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг СЗХ-ны "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэй эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын дагуу бөглөсөн асуулгын хуудас болон ТУЗ-ийн гишүүдийн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв*

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:



УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ПИ ЭС ПЛАС ТЭК ХХК
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

| ТУЗ-ийн гишүүнд тавигдах нэмэлт шаардлага | | | |
|---|---|---|---|
| № | Шаардлага | ТУЗ-ийн хараат бус гишүүд | |
| | | Ц.Азбаяр (Хавсралт 9.4) | Б.Баасандорж (Хавсралт 9.5) |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** |
| 2. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** | Тийм** |
| 3. | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн биш (ХБҮЦтХ-ийн 12.8) | Үгүй** (СЗХ-ны журмын 3.3-т заасныг ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүн нь гурваас дээшгүй ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг хавсран эрхэлж болно) | Тийм** |
| 4. | Бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болоогүй. | Тийм** | Тийм** |
| 5. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** |
| 6. | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй (КтХ-ийн 84.3.1) | Тийм** | Тийм** |
| 7. | Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан (КтХ-ийн 75.8) | Тийм** | Тийм** |
| 8. | Ял шийтгэл эдлээгүй ( КтХ-ийн 84.3.2) | Тийм** | Тийм** |
| 9. | Мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай (СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.13) | Тийм** | Тийм** |
| 10. | Тохиромжтой этгээд байх (МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 6.4, | Тийм** (Хавсралт 1.8) | Тийм** (Хавсралт 1.8) |

| | | | |
|---|---|---|---|
| | СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 2.1.3) | | |

***Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмуудад заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгаа үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь холбогдох хууль, журмуудад заасан ТУЗ-ийн гишүүний шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

**Үйлчилгээ үзүүлэгчийн удирдах албан тушаалтнуудын мэдээлэл:**

"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 19/02а/106 тоот тогтоол (Хавсралт 9.24)-оор компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож, ТУЗ-ийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 19/01в/138 дугаартай тогтоол (Хавсралт 9.25)-оор ТУЗ-ийн даргаар Б.Хүрэлхүүг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Ц.Дашбилэгтийг томилсон байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| № | Овог, нэр | Ажлын туршлага |
|---|---|---|
| 1. | Бямбаа овогтой Хүрэлхүү (ТУЗ-ийн дарга) (Хавсралт 9.26) | 2003-2005 онд "Номин Холдинг" ХХК-д Дотоод аудитын газрын дарга;<br>2005-2012 онд "Номин реалтор" ХХК-д Гүйцэтгэх захирал;<br>2012 оноос одоог хүртэл "Эн Си Ди" (NCD) групп-д Гүйцэтгэх захирал. |
| 2. | Самдан овогтой Отгонбат (ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал) (Хавсралт 9.26) | 2006-2007 онд "Оргил хотхон" ХХК-д Гүйцэтгэх захирал;<br>2008-2009 онд "Номин Холдинг" ХХК-д Ахлах менежер;<br>2013 оноос одоог хүртэл "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-д Гүйцэтгэх захирал. |
| 3. | Даваадорж овогтой Ганболор (ТУЗ-ийн ердийн гишүүн) (Хавсралт 9.26) | 2009-2012 онд "Нью Арена" (New Arena) ХХК-д Захирал;<br>2013-2017 онд "Ноёдын туурь" ХХК-д Зураг төслийн инженер;<br>2017-2019 онд "Баянтохом шандат" ХХК-д Зураг төслийн удирдах инженер. |
| 4. | Батмөнх овогтой Хишигсүрэн (ТУЗ-ийн хараат бус гишүүн) (Хавсралт 9.26) | 2007-2009 онд "Очир угалз солюшн" ХХК-д Хуулийн зөвлөх;<br>2009-2015 онд "Сод Монгол" групп-д Хүний нөөцийн менежер;<br>2015 оноос одоог хүртэл "Бэрс Финанс ББСБ" ХХК-д Хүний нөөцийн менежер. |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

| | | |
|---|---|---|
| 5. | Нармандах овогтой Золжаргал (ТУЗ-ийн хараат бус гишүүн)<br><br>(Хавсралт 9.26) | 2007-2008 онд "МУИС-ОАСС"-д Нарийн бичиг;<br>2008-2012 онд "Умбайн шим" ХХК-д Менежер;<br>2013-2016 онд "Төрийн банк"-д Захирлын туслах;<br>2017 оноос одоог хүртэл "Бэрс Финанс ББСБ" ХХК-д Бичиг хэргийн ажилтан.<br>Банк, санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулсан болон ажилласан жил: |



УЛААНБААТАР ХОТ
БИЧИГ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998 6999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
БОЗ... КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

MDSKhanLex

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн мэдээлэл:**

| № | Шаардлага | Хөрөнгө итгэмжлэн удирдагч | | |
|---|---|---|---|---|
| | | Х.Маргад-Эрдэнэ | Ж.Онон | Б.Буяннэмэх |
| 1. | Тохиромжтой этгээд байх (СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 8.1.2) | Тийм** (Хавсралт 9.27) | Тийм** (Хавсралт 9.28) | Тийм** (Хавсралт 9.29) |
| 2. | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх байх (СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 8.1.4) | Тийм (Хавсралт 9.27) | Тийм (Хавсралт 9.28) | Тийм (Хавсралт 9.29) |

*** Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь СЗХ-оос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудсыг үндэслэж дүгнэв.*

MDSKhanLex

**Бусад нэмэлт судалгаа:**

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад эч холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 4/379 тоот Тодорхойлолт (Хавсралт 9.9)-д тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт сүүлийн 3 жилийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Үндэсний ба Олон улсын Арилжааны арбитрын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А-23/28 тоот тодорхойлолт (Хавсралт 9.10)-д тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба Олон улсын Арилжааны арбитрт тус өдрийг хүртэл арбитрын хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Тодорхойлолт (Хавсралт 9.11)-д "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/737 тоот албан бичиг (Хавсралт 9.12)-т тусгаснаас үзвэл "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны шүүхүүдэд шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцоогүй байна.
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газрын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 449 тоот Тодорхойлолт (Хавсралт 9.13)-д тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй байна;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 03-04/372 тоот албан бичиг (Хавсралт 9.14)-т тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр сүүлийн 5 жилд захиргааны шийтгэл хүлээж байгаагүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй байна;
- "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-ийн 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01/383 тоот албан бичиг (Хавсралт 9.15)-т тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь тус өдрийн байдлаар нийт 13 төрлийн өрийн хэрэгсэл (BGF Бонд1-3.0-10.8%, BGF Бонд2-6.0-13.2%, BGF Бонд3-12.0-15.6%, BGF Бонд5-3M-10.8%, BGF Бонд6-12M-15.6%, BGF Бонд7-12M-15.6%, BGF-6M-14%, BGF Бонд4-18.0-16.2%, BGF Бонд8-12M-15.6%, BG1-12M-16.4%, BG2-12M-16.4%, BG4-12M-16.8%, BG-Бонд 11)-

ийг Биржийн бус зах зээлд гаргасан, үүнээс 8 төрлийн өрийн хэрэгсэл хэрэгсэл (BGF Бонд1-3.0-10.8%, BGF Бонд2-6.0-13.2%, BGF Бонд3-12.0-15.6%, BGF Бонд5-3М-10.8%, BGF Бонд6-12М-15.6%, BGF Бонд7-12М-15.6%, BGF-6М-14%) нь хугацаа дуусаж, төлөгдсөн хадгаламжийн бүртгэлээс хасагдсан байна. Өрийн хэрэгслийн нөхцөлийн дагуу үндсэн төлбөр болон хүү нь хугацаандаа төлөгдсөн ба аливаа өр төлбөрийн үлдэгдэлгүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Монголын татварын албанаас 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 9.16)-д тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь 71,335,468.46 төгрөгийн дутуу төлөлттэй, 405,733.00 төгрөгийн илүү төлөлттэйгөөр бүртгэгдсэн байна;
- Монголын татварын албанаас 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 9.17)-д тусгаснаар "Бичил Эй Би Эс Плас" ХХК нь татвар төлөлтийн аливаа мэдээлэл бүртгэгдээгүй, татварын үлдэгдэлгүй байна;
- Цагдаагийн ерөнхий газар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 13б/640 тоот албан бичиг (Хавсралт 9.18)-т "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийг гэмт хэрэг зөрчилд холбогдон шалгагдаж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас шалгахад тус компанид холбогдох мэдээлэл бүртгэгдээгүй гэж тусгасан байна;
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн 9/1016 тоот албан бичиг (Хавсралт 9.19)-т тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь СЗХ-ны 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор банк бус санхүүгийн байгууллага байгуулж, банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ, 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 340 дугаар тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус тус эзэмшдэг байна. Мөн СЗХ-ны даргын 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 389 дүгээр тушаалаар "Үлэмж мэлмий ББСБ" ХХК-ийн оноосон нэрийг "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК болгон өөрчилсөн байна. ББСБ-ын үйл ажиллагаанд СЗХ-ны даргын 2022 оны 280 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар СЗХ-ны 2008 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар"-ыг зөрчсөн байх тул Санхүү бүртгэлийн газрын захирал (х)-т Зөрчлийн тухай хуулийн 11.5 дугаар зүйлийн 11.5.2 дахь заалтаар 2 сая төгрөгийн торгууль ногдуулсан, ББСБ торгуулийг бүрэн төлж гүйцэтгэсэн. Зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдол байхгүй байна.
- 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар КУБ зээлийн мэдээллийн систем (Хавсралт 9.20)-ийн мэдээллээр "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 2023 оны 5 дугаар сарын 20-ний өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 34,710,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 3,000,000,000 төгрөг, 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 3,000,000,000 төгрөгийн

MDSKhanLex

үнийн дүн бүхий зээлээс 2,700,000,000 төгрөг, 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 1,500,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 1,500,000,000 төгрөг, 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 2023 оны 8 дугаар сарын 12-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 761,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 761,000,000 төгрөг, 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 500,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 500,000,000 төгрөг, 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 296,115,612.19 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 296,115,612.19 төгрөг, 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 2023 оны 8 дугаар сарын 05-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 260,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 260,000,000 төгрөгийн тус тус зээлийн үлдэгдэлтэй, бусад зээлийн үлдэгдэл 0 төгрөг байна. Эдгээр зээлүүдийн ангилал нь "хэвийн" байна.

- УБЕГ-ын Эд хөрөнгийн бүртгэлийн 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/06 тоот албан бичиг (Хавсралт 9.21)-ээр "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн өмчлөлд урьд нь болон тус өдрийн байдлаар хөрөнгө бүртгэгдээгүй байна.
- Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 98 тоот албан бичиг (Хавсралт 9.22)-т тусгаснаар "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь МҮЦАЭХ-ны биржийн бус зах зээлийн Бүртгэлийн хорооны 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн БХ21/18 дугаар тогтоол болон 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн БХ22/22 дугаар тогтоолоор нийт 9,343,000,000 (есөн тэрбум гурван зуун дөчин сая) төгрөгийн үнийн дүн бүхий, эргэлтийн (roll over) нөхцөлтэй өрийн хэрэгслийг бүртгүүлсэн байна. Тус өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд 12 транч арилжаалсан бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хүүгийн болон үндсэн төлбөр нь хугацаандаа хэвийн төлөгдөж байна.
- Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын холбооны 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 2023/033 тоот албан бичиг (Хавсралт 9.23)-т тус тус заасны дагуу лавлагаа авсан өдрийн байдлаар, "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК нь Холбооны гишүүн бөгөөд гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж, хариуцлага хүлээж байгаагүй байна.

ХҮНДЭТГЭСЭН,

"ОМГООЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

## 8.13. НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

**БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол,
Ногоон нуур, 101 барилга, 705 тоот
Утас: 99119632

2023.05.03 № 25/14

Танай ____________-ны № ____________

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД**

Тайлбар хүргүүлэх тухай

"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотойгоор дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бичил глобус финанс ББСБ" ХХК, түүний эрх бүхий албан тушаалтан нь Санхүүгийн зохицуулах хороо болон Төрийн эрх бүхий байгууллагаас аливаа байдлаар захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болно.

2. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө худалдагч этгээдтэй аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй ажиллах бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ хэлцэл байгуулан ажиллана.

3. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор Санхүүгийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ болон хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгч "Оюч аудит" ХХК, Хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Хэлцлийн зөвлөх "Юнайтед Айр Файнэнс" ХХК, Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК-тай тус тус аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр тодорхойлж байна.

Хүндэтгэсэн,

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Н.ГАНТУЛГА

БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11-р хороо, 7-р хороолол /14180/,
Pro One оффис 7 давхар #706
харилцах утас: +976 7000-2020 | и-мэйл: info@bichilglobus.mn
вэб: www.bichilglobus.mn

2023.05.05 № 04/283

танай ______ -ны № ______ -т

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

"Бичил глобус финанс ББСБ" ХХК нь биржийн зах зээлд Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгоор "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд тус компанийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэ бүхий 1,000 (нэг мянга) ширхэг энгийн эрхийн хувьцааг дангаар эзэмших 100 хувийн хувьцаа эзэмшигч билээ.

Түүнчлэн, үнэт цаас гаргах үйл ажиллагаанд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байгаа ба Компанийн тухай хууль, Үнэт цаас гаргагчийн дүрэм болон холбогдох бусад зохицуулалтад нийцүүлэн холбогдох тогтоол, шийдвэрийг гаргасан болно.

Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
2. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
3. Андеррайтер, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК;
4. Хөндлөнгийн Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С. ОТГОНБАТ

ULZII&Co CAPITAL

Улаанбаатар хот, СБД, Сити
тауэр, 25 давхар 2506 тоот
Утас/Факс:+976-77776377
Вэб сайт: http: //www.ucc.mn

2023 оны 5 дугаар сарын 5 №23/74 Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

*Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай*

Тус компани нь "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгох үйл ажиллагаанд Андеррайтерийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаа билээ. Компани нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй хууль, журам болон байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд дараах этгээдүүдтэй үнэт цаас гаргахаас бусад байдлаар аливаа нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

1. Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлж буй "Бичил глобус финанс ББСБ" ХХК;
3. Хөндлөнгийн аудит буюу Зээлийн шинжилгээний тайлан гаргагч "Онч Аудит" ХХК;
4. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН;
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК.

"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК
Гүйцэтгэх захирал

Б. ӨЛЗИЙБАЯР

СЭХ 2023.06.02 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-06-15 БҮРТГЭВ-02

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9032574

2023.05.05 № Д-23/93

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД**

***Мэдэгдэл хүргүүлэх тухай***

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан хууль зүйн дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болно.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг удирдлага болгон, үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн тийм нөхцөл үүсэж болзошгүй тохиолдолд сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлэхээ илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183875

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№01

Onch& Company

Онч Аудит ХХК
15-р давхар Ай Си Си
цамхаг, Жамъян гүний
гудамж Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Улаанбаатар хот
14240, Монгол Улс

Утас: +976 70100450
976 70120450
Факс: +976 70130450
www.onch.mn

2023 оны 5 дугаар сарын 08 — Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хороо
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3,
Засгийн газрын IV байр,
Шуудангийн хаяг-15160

Санхүүгийн зохицуулах хороонд,

Онч Аудит ХХК нь "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд зээлийн хөндлөнгийн шинжээчээр ажиллаж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбоотой дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна.

1. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож буй дараах этгээдүүдтэй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа хэлбэрээр ашиг сонирхолгүй болно. Үүнд:
   - "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК;
   - Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа хариуцагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК;
   - Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК;
   - Хуулийн зүйн дүгнэлт гаргаж буй "Өнгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН
2. Манай компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд зээлийн хөндлөнгийн шинжээчээр ажиллах эрхтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тогтоол журмын шалгуур, шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.
3. Компанийн зүгээс уг ажлын хэсэгт мэргэжлийн өндөр ур чадвар, салбарын туршлага хосолсон чадвартай мэргэжлийн багийг бүрдүүлж, томилсон бөгөөд хөндлөнгийн шинжилгээ хийх үйлчилгээ, тайлан дүгнэлтийг ашиг сонирхлын зөрчилгүй, зохих журмын дагуу гүйцэтгэнэ гэдгийг энэхүү албан бичгээр мэдэгдэж байна.

Та бүхэнд ямар нэг асуулт эсвэл нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол nshagdarsuren@onch.mn хаягаар эсвэл +976 7010 0450 дугаарын утсаар чөлөөтэй холбогдоно уу.

Хүндэтгэсэн,
Ш. Норжинбат
Гүйцэтгэх захирал
Онч Аудит ХХК

**Onch & Company тухай**

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-нууд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчдад үзүүлдэг байгууллагууд юм.

Тус баримт бичигт ерөнхий мэдээлэл агуулагдсан бөгөөд энэхүү танилцуулгаар Onch & Company, түүний гишүүн компани, холбоотой талуудыг мэргэжлийн зөвлөгөө өгсөнд эсвэл үйлчилгээ үзүүлсэнд тооцохгүй. Та өөрийн санхүү, бизнест нөлөөлөхүйц аливаа шийдвэр гаргах эсвэл үйлдэл хийхээс өмнө мэргэжлийн зөвлөхөд хандан зөвлөгөө авна уу. Энэхүү танилцуулгад найдаж шийдвэр гаргасан эсвэл үйлдэл хийсний улмаас аливаа хохирол учирсан бол бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2022. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК ХХК
АТА9998...9999131
9023050164

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС
Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо
Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот
Утас/факс: 976-70122346, Утас: 976-70142346
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот15160, Ш/Х 186

2023.04.11 № 23/18

танай ______ -ны № ______ -т

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

*Баталгаа гаргах тухай,*

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (РД: 2870657) (цаашид "Компани" гэх) нь "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна. Үүнд:

1. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хамтран оролцож буйгаас өөрөөр Компани нь дараах этгээдтэй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа нэгдмэл ашиг сонирхолгүй болно. Үүнд:

   i. "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК;
   ii. Зээлийн шинжилгээ гаргагч "Онч Аудит" ХХК;
   iii. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК;
   iv. Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргаж буй "Өмгөөллийн Эм Ди Эс Энд ХаанЛекс" ХХН.

2. Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх бүрэн эрхтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн болон бусад шалгуур, шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.

3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцоход шаардлагатай мэдлэг туршлагатай бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагыг хангаж байгаа болно.

БАТАЛГАА ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.МАРГАД-ЭРДЭНЭ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн програмын тухай**

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцын Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үйлчилгээ үзүүлэгчээс тайлан мэдээлэл хүлээн авах зорилгоор вэбэд суурилсан програмыг хөгжүүлсэн. Энэхүү програм нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. **Зээлийн мэдээллийг бүртгэх:**
   1.1. Зээлийн хөрөнгийн төрлөөс хамааруулан цахим зээлийн хувьд 15 талбар, автомашины фидуци бүхий зээлийн хувьд 21 талбар мэдээллийг бүртгэнэ. /Мэдээллийн жагсаалтыг Хавсралт №1-ээс харна уу./
   1.2. Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийг бүртгэнэ.

2. **Зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих**
   Зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчээс гэрээнд заасан хугацааны давтамжтайгаар хүлээн авч, тулган баталгаажуулна. /Тайлангийн загварыг Хавсралт №2-оос харна уу./

3. **Багц дахь хугацаа хэтэрсэн зээлийг солих, багцыг нэмэгдүүлэх**
   3.1. <u>Зээл солих:</u> 90 хоногоос дээш төлбөрийн зөрчилтэй зээлийг сардаа 1 удаа тооцоо нийлж солих бөгөөд солих нөхцөл үүссэн зээлийн дараах мэдээллийг бэлтгэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдээлнэ:
   - Хугацаа хэтэрсэн зээлийн дугаар
   - Үндсэн өрийн үлдэгдэл
   - Хуримтлагдсан хүү

   Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дээрх мэдээлэлд үндэслэн хугацаа хэтэрсэн зээлийн нийт дүнд тааруулан ТЗК-д санал болгох зээлүүдийн 1.1-т заасан мэдээллийг програмд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

   3.2. <u>Багцыг нэмэгдүүлэх:</u> Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтөд үндэслэн сард 1 удаа багцыг нэмэгдүүлэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-д нэмж санал болгох зээлүүдийн 1.1-т заасан мэдээллийг програмд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

УЛААНБААТАР ХОТ
БИЧИЛ ЭЙ ПИ ЭС ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЭЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -06- 15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 .06. 07
БҮРТГЭВ
№ 01

**Хавсралт №1: Зээлийн мэдээлэл хүлээн авах загвар**

*Хүснэгт №1. Цахим зээлийн мэдээллийн жагсаалт*

| № | Талбарын нэр |
|---|---|
| 1 | Зээлийн дугаар |
| 2 | Зээлдэгчийн овог |
| 3 | Зээлдэгчийн нэр |
| 4 | Зээлдэгчийн регистрийн дугаар |
| 5 | Сарын орлого |
| 6 | Зээл олгосон огноо |
| 7 | Төлж дуусах огноо |
| 8 | Олгосон зээл дүн |
| 9 | Зээлийн үлдэгдэл |
| 10 | Зээлийн хүү /сар/ |
| 11 | Зээлийн валют |
| 12 | Сарын төлөлт |
| 13 | Алданги хувь |
| 14 | Зээлийн төлбөр төлж эхлэх огноо |
| 15 | Сард зээл төлөх давтамж |

*Хүснэгт №2. Автомашины фидуци бүхий зээлийн мэдээллийн жагсаалт*

| № | Талбарын нэр |
|---|---|
| 1 | Зээлийн дугаар |
| 2 | Гэрээний дугаар |
| 3 | Зээлдэгчийн овог |
| 4 | Зээлдэгчийн нэр |
| 5 | Зээлдэгчийн регистерийн дугаар |
| 6 | Сарын орлого |
| 7 | Зээл олгосон огноо |
| 8 | Төлж дуусах огноо |
| 9 | Олгосон зээл дүн |
| 10 | Зээлийн үлдэгдэл |
| 11 | Зээлийн хүү /сар/ |
| 12 | Зээлийн валют |
| 13 | Сарын төлөлт |
